




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



**НОТОЛГООНЫ ӨНӨӨГИЙН ПРАКТИК,  
АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ,  
АНХААРАХ АСУУДАЛ**



**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**





НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

**НОТОЛГООНЫ ӨНӨӨГИЙН ПРАКТИК,  
АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ,  
АНХААРАХ АСУУДАЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2021 он

НАА 67.51  
ДАА 364  
Н-751

## **НОТОЛГООНЫ ӨНӨӨГИЙН ПРАКТИК, АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, АНХААРАХ АСУУДАЛ**

### **СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Багийн ахлагчаар хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор Б.Батзориг, үндсэн судлаачаар хууль зүйн магистр Б.Эрдэнэбат, хууль зүйн магистр Ц.Шийтэрчулуун, зөвлөхөөр Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн ахлах шинжээч, цагдаагийн хошууч Г.Ганхүлэг нар ажиллалаа.

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү тайланд туссан хөндлөнгийн дүгнэлт, үзэл бодол нь Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй болно.

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN 978-9919-9742-2-0

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	9
ТАЛАРХАЛ .....	10
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ .....	11
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	12
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....	12
Нэг. ҮНДЭСНИЙ БОЛОН ГАДААД УЛСЫН НОТЛОГООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..	15
1.1. Нотлох ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын онцлог .....	15
1.2. Монгол Улс дахь нотлох ажиллагааны эрх зүйн орчин .....	18
Дүгнэлт .....	28
1.3. Гадаад орны нотлох ажиллагааны эрх зүйн орчин.....	30
1.3.1. Эрүүгийн процессын загвар хууль .....	33
1.3.2. ОХУ-ын Эрүүгийн процессын хууль .....	35
1.3.3. БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль .....	37
1.3.4. БНСУ-ын Эрүүгийн процессын хууль .....	39
1.3.5. АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны хууль .....	42
1.3.6. Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хууль .....	44
Дүгнэлт .....	46
Хоёр. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ, БЭХЖҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	48
2.1. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онцлог .....	48
2.1.1. Гэмт хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ .....	51
2.1.2. Эрүүгийн хуулийн 10.1. Хүнийг алах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт .....	54

2.1.3. Эрүүгийн хуулийн 17.1. Хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт.....	56
2.1.4. Эрүүгийн хуулийн 20.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт .....	58
Дүгнэлт .....	60
2.2. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд мөрдөгчийн ашиглаж байгаа техник, хэрэгсэлд хийсэн дүн шинжилгээ.....	61
Дүгнэлт .....	70
2.3. Шүүхийн шинжилгээ хийхэд хэрэглэх арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдалд хийсэн дүн шинжилгээ .....	71
2.3.1 Нотлох ажиллагаанд шүүх шинжилгээний байгууллага, шинжээчийн оролцоо .....	71
2.3.2. Шүүхийн шинжилгээний байгууллагад хэрэглэх арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдалд хийсэн дүн шинжилгээ.....	74
2.3.3. Шүүхийн шинжилгээ хийж буй бусад байгууллагад хийх шинжилгээ .....	91
Дүгнэлт .....	100
<b>Гурав. ГЭМТ ХЭРГИЙГ НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....</b>	<b>101</b>
3.1. Гэмт хэргийг нотлох ажиллагааны сургалтын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ .....	101
Дүгнэлт .....	106
3.2. Гэмт хэргийг нотлох ажиллагааны ном, гарын авлага, бүтээлүүдэд хийсэн дүн шинжилгээ .....	108
Дүгнэлт .....	110
<b>НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>111</b>
<b>ХАВСРАЛТ 1 .....</b>	<b>117</b>
<b>ХАВСРАЛТ 2.....</b>	<b>137</b>
<b>ХАВСРАЛТ 3.....</b>	<b>145</b>
<b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>147</b>

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ЭХХШТХ, ЭБШХ-ийн харьцуулалт .....	21
Хүснэгт 2. ЭХХШТХ, Дэлхийн эрүүгийн процессын загвар хуулийн харьцуулалт .....	33
Хүснэгт 3. ЭХХШТХ, ОХУ-ын Эрүүгийн процессын хуулийн харьцуулалт .....	35
Хүснэгт 4. ЭХХШТХ, БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн харьцуулалт ..	38
Хүснэгт 5. ЭХХШТХ, БНСУ-ын Эрүүгийн процессын хуулийн харьцуулалт ....	40
Хүснэгт 6. ЭХХШТХ, АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны журмын харьцуулалт .....	43
Хүснэгт 7. Их, дээд сургуулиас хамгийн түгээмэл ашиглаж сурдаг нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх арга.....	63
Хүснэгт 8. Шүүхийн шинжилгээний талаарх талуудын санал.....	73
Хүснэгт 9. Мөр судлалын шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	80
Хүснэгт 10. Бичиг баримтын шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	80
Хүснэгт 11. Галт зэвсгийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	81
Хүснэгт 12. Авто техникийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	82
Хүснэгт 13. Криминалистикийн шинжилгээний газрын хийсэн шинжилгээний талаарх дэлгэрэнгүй судалгаа.....	86
Хүснэгт 14. Химийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	87
Хүснэгт 15. Биологийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	88
Хүснэгт 16. Физикийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	88
Хүснэгт 17. Бактериологийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	89
Хүснэгт 18. ДНХ-гийн шинжилгээнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа.....	90
Хүснэгт 19. Нотлох ажиллагааны талаарх хичээлийн төлөвлөлтийн харьцуулалт .....	102
Хүснэгт 20. Нотлох ажиллагааны талаарх хичээлийн үнэлгээ.....	104

## ЖИШЭЭНИЙ ЖАГСААЛТ

Жишээ 1.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлага.....	28
Жишээ 2.	Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчтэй хийсэн ярилцлага.....	53
Жишээ 3.	Орон нутгийн Цагдаагийн газрын даргатай хийсэн ярилцлага ....	63
Жишээ 4.	Мөрдөгч, прокурор, шүүгчтэй хийсэн ярилцлага .....	68
Жишээ 5.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлага.....	69
Жишээ 6.	Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлага.....	69
Жишээ 7.	Мөрдөгч, мөрдөх албаны дарга нартай хийсэн ярилцлага .....	70
Жишээ 8.	Шүүхийн шинжилгээгээр нотлогдсон хэрэг.....	99

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Эрүүгийн хуулийн 10.1. Хүнийг алах гэмт хэрэг дэх нотлох баримтын харьцаа .....	55
График 2.	Хүнийг алах гэмт хэргийг шийдвэрлэхдээ шүүхээс шинжлэн судалсан нотлох баримт.....	55
График 3.	Эрүүгийн хуулийн 17.1. Хулгайлах гэмт хэргийн нотлох баримтын харьцаа .....	57
График 4.	Шүүх хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэхдээ шинжлэн судалсан нотлох баримт.....	57
График 5.	Эрүүгийн хуулийн 20.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ.....	59
График 6.	Шүүхүүд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг шийдвэрлэхдээ шинжлэн судалсан нотлох баримт .....	59
График 7.	ШШҮХ-гийн шинжээчийн нотолсон хэргийн судалгаа.....	72
График 8.	ШШҮХ-гийн шинжээчийн нотолсон хэргийн судалгаа (Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгтэй харьцуулсан байдлаар) .....	73
График 9.	ШШҮХ-гийн алба хаагчдын мэргэшлийн судалгаа .....	78
График 10.	Гарын мөрийн шинжилгээ хийсэн судалгаа .....	79
График 11.	Мөр судлалын шинжилгээ хийсэн судалгаа.....	80
График 12.	Бичиг баримтын шинжилгээ хийсэн судалгаа.....	81
График 13.	Галт зэвсгийн шинжилгээ хийсэн судалгаа.....	81
График 14.	Авто техникийн шинжилгээ хийсэн судалгаа.....	82



---

График 15. Гэрэл зураг, дүр зураг-дүрс бичлэгийн шинжилгээ хийсэн судалгаа .....	83
График 16. ШШҮХ-гийн криминалистикийн шинжээчийн оролцсон ажиллагааны судалгаа .....	84
График 17. ШШҮХ-гийн криминалистикийн шинжээчийн хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн мөрний судалгаа.....	84
График 18. ШШҮХ-гийн нотолсон хэргийн судалгаа.....	85
График 19. ШШҮХ-гийн боловсруулсан гэрэл зургийн судалгаа.....	85
График 20. Криминалистикийн шинжилгээний газрын хийсэн шинжилгээний талаарх дэлгэрэнгүй судалгаа.....	85
График 21. Криминалистикийн шинжилгээний газрын хийсэн шинжилгээний судалгаа .....	86
График 22. Химийн шинжилгээ хийсэн судалгаа.....	87
График 23. Биологийн шинжилгээ хийсэн судалгаа .....	88
График 24. Физикийн шинжилгээ хийсэн судалгаа .....	89
График 25. Бактериологийн шинжилгээ хийсэн судалгаа .....	90
График 26. ДНХ-гийн шинжилгээ хийсэн судалгаа.....	91

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүний эрхэд суурилсан, зохист процессын дагуу явуулах эрх зүйн үндсийг тогтоохыг зорьсон бөгөөд энэ хүрээнд “байцаалт”-д тулгуурласан нотолгооноос татгалзаж, шинэлэг арга барил, техник технологийн дэвшлийг ашиглах замаар хөдөлшгүй нотлоход чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж буй билээ. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3 дугаар зүйлийн 2-т “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцох боловч уг мэдүүлэг дангаараа түүнийг яллах үндэслэл болохгүй” хэмээн заасан нь тун чухал ололт юм. Энэ нь эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэхэд онцгой үүрэгтэй. Тиймээс Нээлттэй Нийгэм Форум Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн энэхүү чухал алхам практикт хэрхэн хэрэгжиж байгааг судлах зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Бид хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор Б.Батзориг, хууль зүйн магистр Б.Эрдэнэбат, хууль зүйн магистр Ц.Шийтэрчулуун, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ахлах шинжээч, цагдаагийн хошууч Г.Ганхүлэг нарын хийсэн “Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал” судалгааг Танд хүргэж байгаадаа баяртай байна. Энэ судалгаа нь гэмт хэргийг нотлох ажиллагааны өнөөгийн практик, нөхцөл байдал, эрх зүйн орчин болон нотолгоонд ашиглаж буй арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдал, бусад улсын нотлох ажиллагааны онцлог, эрх зүйн зохицуулалт, хуульч, хууль сахиулагч бэлтгэх сургалтад хэрэглэгдэж буй нотлох ажиллагаатай холбоотой ном, сурах бичиг, сургалтын хөтөлбөр, арга зүйд дүн шинжилгээ хийж, холбогдох санал зөвлөмжийг боловсруулснаараа ач холбогдолтой.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжиж ажилласаар ирсэн бөгөөд энэ хүрээнд 10 гаруй судалгаа олны хүртээл болсныг энэ дашрамд дурдахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНАГУ	Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс
ДЯЯ	Дотоод явдлын яам
ДХГ	Дотоодыг хамгаалах газар
ДХИС	Дотоод хэргийн Их сургууль
ИЗИС-ийн ХЗС	Их засаг их сургуулийн Хууль зүйн сургууль
МГДША	Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа
МШТ	Мөрдөн шалгах туршилт
МУИС-ийн ХЗС	Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТОА	Таньж олуулах ажиллагаа
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУУЗН	Олон улсын улаан загалмайн нийгэмлэг
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын их хурал
УЦСЕГ	Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар
ХГҮ	Хэргийн газрын үзлэг
НЦУГ	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ШША	Шүүх шинжилгээний алба
ХУИС	Хүмүүнлэгийн ухааны их сургууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭП	Эрүүгийн процесс
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

## **ТАЛАРХАЛ**

Судалгаа хийхэд туслалцаа үзүүлсэн Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэн, Цагдаагийн байгууллага, Нээлттэй Нийгэм Форум (ННФ) ТББ-ын хамт олонд талархлаа илэрхийлье.

## СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Шинжлэх ухааны танин мэдэхүй нь юмс, үзэгдэл, тэдгээрийн харилцан холбоо, хамаарлын талаарх нэгэнт шалгагдсан тов тодорхой мэдлэгийг эзэмших үйл явц<sup>1</sup> ба түүнд ямар нэг хязгаар гэж байхгүй бол гэмт хэргийг танин мэдэх үйл явц нь тодорхой хэмжээ хязгаартай.<sup>2</sup> Шинжлэх ухаан нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аргаар танин мэдэх гэж буй зүйлийн мөн чанарын зүй тогтлыг илрүүлэн гаргаж тодорхой хүмүүсийн, эсхүл хүн төрөлхтний өмнө үүнийхээ үнэн бодитойг баталдаг бөгөөд энэ нь хүн төрөлхтний сайн сайхны төлөө чиглэгдсэн байдаг.

Эрх зүйн зөрчлийн нотолгоо нь (эрүүгийн процессын эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, олон улсын эрх зүйн гэх мэт) танин мэдэхүйн үйл явцын хамгийн ээдрээ төвөгтэй асуудлын нэг төдийгүй ертөнцийг танин мэдэх үйл ажиллагааны нэг хэсэг болж, түүний ерөнхий шинжийг илэрхийлэхийн зэрэгцээ хуульд заасан нөхцөлөөс хамаарч өөрийн гэсэн онцлогтой. Тиймээс үүнийг хуулиар нэг мөр зохицуулах, улам боловсронгуй болгож байхыг нийгэм шаарддаг.<sup>3</sup>

Улсын Их Хурлаас “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”<sup>4</sup>, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”<sup>5</sup> зэрэг хөтөлбөр, төлөвлөгөөг үе шаттайгаар батлан хэрэгжүүлж байна. Уг шинэтгэлийн бодлогын хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад чиглэсэн хэд хэдэн чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ гэх)-ийг баталсан явдал юм.<sup>6</sup>

ЭХХШТХ нь өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиас хэлбэр, агуулга, зарчмын хувьд ихээхэн ялгаатай. Тухайлбал, “байцаалт”-д тулгуурласан нотолгооноос техник хэрэгсэл, арга зүйд тулгуурласан нотолгооны

<sup>1</sup> С.Жанцан, “Хууль зүйн сэтгэл судлал”, УБ., 2001, 109 дэх тал.

<sup>2</sup> “Уголовный процесс” под ред. В.А.Божьева, М., 1989, стр. 96

<sup>3</sup> Б.Батзориг, “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол”, УБ., 2002, 63 дахь тал.

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоол, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”.

<sup>5</sup> Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>6</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

процесст шилжих алхам хийгдсэн. Эрх зүйн энэ өөрчлөлт нь мөрдөгчдийг нотолгооны шинэлэг арга барил, техник хэрэгсэл ашиглан болж өнгөрсөн үйл явдлыг хөдөлшгүйгээр нотолж, хэргийг түргэн шуурхай илрүүлэх боломж бүрдүүлсэн бөгөөд энэ нь шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх гол хүчин зүйл болно.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

Гэмт хэргийг нотлох ажиллагааны өнөөгийн практик, нөхцөл байдал, эрх зүйн орчин болон нотолгоонд ашиглаж буй арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх замаар цаашид анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино. Судалгааны ажлын зорилгод нийцүүлэн дараах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Гэмт хэргийг нотлох ажиллагааны эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх;
2. Бусад улсын нотлох ажиллагааны онцлог, техник хэрэгсэл ашиглахтай холбоотой эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх;
3. Гэмт хэргийг нотлох ажиллагааны өнөөгийн практик, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
4. Хуулийн сургуулийн болон Дотоод хэргийн Их сургуулийн сонсогч, оюутанд зориулсан нотлох ажиллагааны талаарх сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурах бичгүүдэд дүн шинжилгээ хийх;
5. Шүүхийн өмнөх шатны буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатан дахь нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны арга зүй, техник хэрэгсэл ашиглалтын байдалд үнэлэлт өгч судаллаа.

## **СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Судалгаанд нотлох ажиллагаатай холбоотой тоон мэдээлэл, ганцаарчилсан болон фокус - бүлгийн ярилцлагаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мөн шүүхийн шийдвэр судлах, гадаад орны хууль тогтоомжийг харьцуулан судлах зэрэг арга зүйг ашигласан болно. Энэхүү судалгаанд:

- Гэмт хэргийн нотлох ажиллагааны эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Авлигын эсрэг болон Цагдаагийн албаны тухай хуулиуд, мөн 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг судалгаанд хамрууллаа.
- Гадаад орны эрх зүйн харьцуулсан судалгаанд дараах хуулиудыг ашиглалаа. Үүнд:
  - Эрүүгийн процессын загвар хууль;
  - ОХУ-ын Эрүүгийн процессын хууль;
  - БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль;
  - БНСУ-ын Эрүүгийн процессын хууль;
  - АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны хууль;
  - Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн нотлох ажиллагааны онцлог, техник хэрэгсэл ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийв.
- Улаанбаатар хот, Төв, Өвөрхангай, Дархан-Уул, Ховд, Өмнөговь, Хэнтий аймгуудын 73 мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, ахлах мөрдөгч, мөрдөн байцаах болон эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, 10 шинжээч, ахлах шинжээч, 30 өмгөөлөгч, 21 прокурор, 5 шүүгчтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийлээ.
- Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Төв, Өмнөговь аймгуудын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2018-2020 онд хянан шийдвэрлэгдсэн 120 хэргийн шийтгэх тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.<sup>7</sup> Монгол Улсад түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг буюу хулгайлах гэмт хэрэг, хэргийн нөхцөл байдлыг тогтооход мөрдөгч, шинжээчийн ур чадвар, хэргийн газрын үзлэг, эд мөрийн баримт шаарддаг гэмт хэрэг болох хүнийг алах гэмт хэрэг, мөрдөгчөөс нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ур чадвар шаарддаг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг сонгон авсан болно.
- МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн Их сургууль, Их Засаг Олон улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Билэг дээд сургуулийн сонсогч, оюутнуудад зааж буй нотлох ажиллагааны талаарх хичээлийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурах бичигт дүн шинжилгээ хийв.

<sup>7</sup> Цахим эх сурвалж: shuukh.mn

- Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэн болон шинжилгээ, туршилт хийж гүйцэтгэдэг бусад байгууллагын үйл ажиллагааг мөн харьцуулан судаллаа.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2020 оны 6-9 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд шаардлагатай нэмэлт тодруулах мэдээллийг 10 дугаар сард цуглууллаа. Судалгааны зарим дүнд үндэслэн “Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаа дахь техник хэрэгслийн ашиглалтад хийсэн дүн шинжилгээ” сэдэвт илтгэлийг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Дотоод хэргийн Их сургууль, Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэн хамтран зохион байгуулсан “Шинжлэн магадлахуйн орчин үеийн асуудал - 2020” эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлээ. Тус хуралд Дотоод хэргийн Их сургуулийн криминалистикийн судлаач багш нар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, нийслэл, орон нутгийн шинжээч нар оролцсон юм.



# Нэг. ҮНДЭСНИЙ БОЛОН ГАДААД УЛСЫН НОТОЛГООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 1.1. Нотлох ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын онцлог

Хэргийг нотлох ажиллагаа гэдэг нь хянан шийдвэрлэж буй хэрэгт хамааралтай болж өнгөрсөн үйл явдлыг нотлох баримтад тулгуурлан хуульд заасан үндэслэл, журмын дагуу сэргээн, бодит үнэнийг тогтоох танин мэдэхүйн үйл явц.<sup>8</sup>

Гэмт хэрэг, түүнтэй холбогдон бий болох нөхцөл байдлыг нотолж тогтоох үйл явц нь нарийн төвөгтэй ажиллагаа юм. Энэхүү нөхцөл байдлын ул мөр буюу мэдээлэл нь хүний мэдрэхүйн эрхтэн, сэтгэхүйгээр дамжиж ой ухаанд эсхүл эд зүйл, бичиг баримтад болон материаллаг ертөнцөд ямар нэг хэлбэрээр тусаж үлддэг.

Гэмт хэргийн нотолгоо нь эрүүгийн эрх зүйн зохицуулах зүйлийн хүрээнд судлах зүйл нь хамаардаг тул эрх зүйн нотолгооны хамгийн эмзэг асуудал юм. “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн олон улсын зарчим болон Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй нотолгоо явуулах шаардлагатай.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг тогтоохдоо эрүүгийн хэрэг үүсгэх болон сэргээх үндэслэл шалтгааныг олж тогтоох, үүний дараа үнэхээр эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, хэрэгт холбогдогч гэм буруутай эсэх, гэмт хэрэг үйлдсэн арга хэлбэр болон бусад үйлдэл, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор уршиг, хэрэгт холбогдогчийн хувийн байдал зэргийг ЭХХШтХ-д заасны дагуу бүрэн шалгаж нотолсны эцэст хуулийн дагуу тодорхой шийдвэр гаргадаг.

Нотлох баримтаар тогтоогдсон бодит үнэнд үндэслэж гаргасан шийдвэрт маш хянуур болгоомжтой хандахгүй бол бусдыг хилсээр шийтгэх аюултай. Ялангуяа цаазаар авах ял шийтгэсэн тохиолдолд нөхөж баршгүй хор уршигтай билээ. Ийм алдааг засах аргагүй. Гэвч харамсалтай нь, дэлхийн түүхэнд ийм алдаа байнга

<sup>8</sup> Б.Батзориг, Б.Туяа, “Нотолгооны онол, арга зүй”, Сургалтын гарын авлага, УБ., 2008.

гарсаар ирсэн. Америкийн судлаач Х.Бедау, М.Рейдлет нарын судалгаанаас үзэхэд “1987 онд хүнийг цаазаар авах 349 буруу тогтоол гарснаас 23-ыг нь биелүүлсэн” байна. 1970-1980 оны хооронд үйлдэгдсэн хүн амь, хүчингийн 50 гаруй хэрэгт жинхэнэ хэрэгтэн болох Чикатило, Михасевич нар баригдахаас өмнө хоёр хүнийг буруутгасан шүүхийн тогтоол гарсан байжээ.<sup>9</sup> Манай улсын хувьд цаазын ялаас татгалзсан хэдий ч буруу шийдвэрийн улмаас бүх насаараа хоригдох эрсдэл байгааг мартаж учиргүй.

Нөгөө талаар, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутайг нотолж чадахгүй байх, ингэснээр тухайн этгээд эрэмшиж дахин гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг. Өөрөөр хэлбэл, дахин гэмт хэрэг үйлдэх хамгийн тааламжтай нөхцөл бол анхных нь хэрэг илрэхгүй үлдэж, уг үйлдсэн хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх явдал юм.<sup>10</sup> Тухайлбал, Хэнтий аймгийн Сүмбэр суманд хоёр хүн сэжигтэй байдлаар нас барахад цагдаагийн байгууллага гэм буруутай этгээдийг нотолж чадахгүй байсаар дахин нэг хүний амь насыг гэмт этгээдээр бүрэлгүүлэх боломж олгосон байдаг.<sup>11</sup>

Дээр дурдсан баримтууд нь тусгай мэдлэг эзэмшсэн албан тушаалтан хатуу тогтоосон хэм хэмжээ бүхий хууль тогтоомжийн хүрээнд нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх зэрэг цогц ажиллагаа явуулах шаардлагатай байдгийн баталгаа юм. Зарим улс Үндсэн хуульдаа нотлох ажиллагааны эрх зүйн баталгааг тунхагласан байдаг.<sup>12</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг мөн”, “... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно<sup>13</sup> гэж тодорхойлсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ЭХХША)-ны зорилт нь “гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино”. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхдээ бүх үйл ажиллагаа нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдах учиртай. Иймд

<sup>9</sup> “Уголовное право”, под ред. И.Я.Гуценко, М., 1999, стр. 354.

<sup>10</sup> Д.Дашдэмбэрэл, “Гэмт хэргийг илрүүлэх арга зүйн зарим асуудал”, УБ., 1992, 5 дахь тал.

<sup>11</sup> “Халуун мөр”, ред. Д.Алтангэрэл, УБ., 1996.

<sup>12</sup> ОХУ-ын Үндсэн хуулийн 50-р зүйлийн 2 дахь хэсэг “Холбооны хууль зөрчиж олж авсан нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй”.

<sup>13</sup> Төрийн мэдээлэл, 1992, №1.

эрүүгийн процесст оролцогчид хууль ёсыг сахин биелүүлэх үүрэгтэй ба энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зарчмын илрэл юм.

Манай улсад ЭХХША-г “хууль ёсны байх” зарчимд нийцүүлэн явуулах нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг улсын хувьд онцгой ач холбогдолтой. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хууль (ЭХ) болон ЭХХШТХ-ийн хэрэглээ, хүний эрх, эрх чөлөөг хангаж буй байдал, яллах болон цагаатгах нотлох баримтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулсан эсэх, хууль ёсны байх зарчмыг хэрхэн хангаж байгаад хяналт тавих чиг үүрэг бүхий прокурорын байгууллагын тогтолцоо ажилладаг. Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг гагцхүү шүүх хуульд заасан журмыг баримтлан хөдөлбөргүй нотолсны үндсэн дээр эцэслэн шийдвэрлэнэ. Шүүх нь ЭХХША-ны зорилтыг хангахад эцсийн шийдвэр гаргадаг хуулийн дагуу байгуулагдсан, хараат бус, гагцхүү хуульд захирагдах онцгой субъект юм.

Эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны явцад зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн төдийгүй түүнд татагдан оролцож буй бүх хүний эрх ашиг хөндөгддөг. Иргэний эрх, эрх чөлөө, халдашгүй дархан байдалд зөвхөн Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн, ЭХХШТХ-д заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлалт тогтооно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд заасанчлан төр Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, зөрчсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх үүргээ хэрэгжүүлэхийн тулд асуудлыг хөдөлбөргүй тогтоох шаардлагатай бөгөөд энэхүү ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хэмжээгээр хязгаарлалт тогтоодог, ингэхдээ хуулийг ягштал баримтлах ёстой. Хууль зөрчиж нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь ноцтой гэмт хэрэгт тооцогддог.

Нотлох ажиллагааны эрх зүйн орчныг дараах байдлаар системчилж болно. Үүнд:

1. Үндсэн эх сурвалж: Монгол Улсын Үндсэн хууль
2. Гол эх сурвалж: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль
3. Бусад эх сурвалж: Шүүхийн шинжилгээний тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль гэх мэт.

## 1.2. Монгол Улс дахь нотлох ажиллагааны эрх зүйн орчин

Хууль бол ярьдаггүй шүүх, шүүх бол ярьдаг хууль гэсэн үзэл баримтлал нь процессын хуулийн амин сүнс мөн. Монгол Улсад "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим"<sup>14</sup> бөгөөд шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн нотлох ажиллагааг явуулах шаардлагатай. Монгол Улсын Үндсэн хуульд "Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх"<sup>15</sup>, "хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно"<sup>16</sup> хэмээн хуульчилсан. Үүнд нийцүүлэн эрх зүйн нийтлэг зарчмыг тодорхойлж, эрүүгийн процессын хэм хэмжээнд тусгасан байдаг. Эрх зүйн зохицуулалтын шинж байдлын онцлогоос хамаарч эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээ нь гол төлөв үүрэг хүлээлгэсэн, заавал биелэгдэх шинжтэй (императив) тул нотлох үйл ажиллагааг гагцхүү ЭХХШТХ-д заасны дагуу хэрэгжүүлдэг.

ЭХХША-ны явцад хүний эрхэд хязгаарлалт тогтоох, эрх, эрх чөлөөнд хуулийн дагуу "халдах" журмыг тусгайлан зохицуулдаг бөгөөд энэ ч утгаараа ЭХХШТХ-ийг төсөөтэй хэрэглэдэггүй. ЭХХШТХ-ийн 1.2 дугаар зүйлд "1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана; 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална" гэж туйлын тодорхой заасан байдаг нь үүний баталгаа юм.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудыг судалж үзэхэд императив шинжтэй хууль нь гагцхүү ЭХХШТХ юм. Тиймээс ЭХХШТХ-ийн заалт хоёрдмол утгагүй, ямар нэг эргэлзээ төрүүлэхээргүй, маш тодорхой байх ёстой. Эсрэг тохиолдолд гэмт этгээд, түүний өмгөөлөгч болон эрүүгийн хэрэгт ямар нэг хувийн сонирхолтой этгээд өөрийн талд ашигтайгаар хэрэглэх боломж бий болж улмаар ял завших, гэм буруугүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүрэх эрсдэлтэй.

ЭХХШТХ-ийн зохицуулалтыг эрх бүхий албан тушаалтнууд санаатай болон хайхрамж, болгоомжгүйгээр зөрчих тохиолдол олонтаа гардаг. Түүгээр ч үл барам хуулийн зохицуулалт гэмт хэрэг илрүүлэх, нотлоход саад хүндрэл

<sup>14</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйл (Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.)

<sup>15</sup> Мөн хуулийн 17-р зүйл (Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.)

<sup>16</sup> Мөн хуулийн 16.13-р зүйл (Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.)

учруулдаг гэж үзэх албан тушаалтнууд ч цөөнгүй бий. Тиймээс эрүүгийн хэргийг нотлохдоо хуулиас гадна урьдах тогтолцооноос улбаатай практик ажиллагаанд хэвшиж тогтсон “бичигдээгүй хууль”, “практик журам” гэгчийг баримтлах нь тун элбэг үзэгддэг.<sup>17</sup>

Эрүүгийн хэргийг нотлох ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийг удирдлага болгохын зэрэгцээ Эрүүгийн хууль, ЭХХШТХ, Прокурорын тухай, Шүүхийн тухай хуулиудыг хэрэглэж болохоор заасан билээ. Мөн Монгол Улсын дээд шүүхээс хууль тайлбарласан албан ёсны тайлбар нь эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд тооцогддог.

Өнөөгийн практикаас үзэхэд ЭХХШТХ-д заагаагүй тогтсон загварчлалаар эрүүгийн хэргийг шийдвэрлэж байгаа нь Үндсэн хуулийн үзэл санаанд харшилж, хууль зөрчихөд хүргэж байна. Түүнчлэн шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, ЭХХШТХ-ийн нэг мөр ойлголтгүйгээс бусдыг сохроор даган хэлбэрдэх явдлаас үүдэн гарсан бэрхшээл, хуучинсаг буруу арга барилаас үүдэн шинэ эрүүгийн процессын хуулийн ач холбогдлыг алдагдуулахад хүргэсэн. Иймд мөрдөгч, хуульч хуулийг зөв хэрэгжүүлж, хэрэглэх нь шударга ёсыг тогтоох, хуулийг дээдлэн хүндэтгэдэг үзлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь ЭХХШТХ-ийн нийгэмд гүйцэтгэх нэг үүрэг бөгөөд хууль ёсны байх зарчмын гол утга учир үүнд оршино.

Гол эх сурвалж болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд<sup>18</sup> нотлох ажиллагаатай (шүүхийн өмнөх шат) холбоотой харилцааг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

1. I бүлэг: Нотлох ажиллагааны зарчим
2. IV-VI бүлэг: Нотолгооны субъект
3. VII-IX бүлэг: Нотлох ажиллагаанд оролцогчид
4. XII-XV, XXI бүлэг: Нотлох ажиллагааны баталгаа
5. XVI бүлэг: Нотлох баримт
6. XX-XXVI, XXVIII бүлэг: Мөрдөн шалгах ажиллагаа
7. XXVI бүлэг: Мөрдөн шалгах бусад ажиллагаа
8. XXVII бүлэг: Шинжилгээ хийх зэрэг бүлгүүдэд нотлох баримт, нотлох ажиллагааны ойлголт, нотолгооны зүйл, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх үндэслэл журмыг заажээ.

---

<sup>17</sup> Б.Батзориг, “Эрүүгийн хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онол, практикийн асуудал” хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон диссертациас үзнэ үү.

<sup>18</sup> Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан.

ЭХХШТХ-д нотлох баримтыг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг хэлнэ” гэж тодорхойлсон. Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно. Мөн ЭХХШТХ-д заасан журмын дагуу гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно. Мөрдөгч ЭХХШТХ-д заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ.

Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглох ба ЭХХШТХ-д заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болдоггүй. Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана. ЭХХШТХ-д заасны дагуу оролцогчоос прокурор, мөрдөгчид гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтын олж авсан эх сурвалжийг зааж чадаагүй бол дангаараа нотлох баримт болохгүй. Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааны баримтыг нотлох баримтаар тооцохгүй.

Шүүх, прокурор, мөрдөгч нь ЭХХШТХ-д заасны дагуу тухайн гэмт хэрэгт хамааралтай нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэн уг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлдэг. Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй. Хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх хуралдаанаар шинжлэн судалж аль нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохыг шүүх шийдвэрлэнэ.

ЭХХШТХ-д шинээр орсон, өөрчлөн найруулсан зохицуулалтыг ЭБШХ-ийн холбогдох заалттай харьцуулсныг доорх хүснэгтээр харуулав.

## ХҮСНЭГТ 1. ЭХХШТХ, ЭБШХ-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ЭХХШТХ	ЭБШХ
<p>13.3 дугаар зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай хуульчилсан. Хамтран ажиллах этгээд нь:</p> <p>а. Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэдээлэл өгөх, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн бол;</p> <p>б. Эрүүгийн хуулийн 19.4 (Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах), 19.7 (Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх), 20.7 (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах), 29.9 (Террор үйлдэхэд бэлтгэх) дүгээр зүйлийн тайлбарт заасан ялаас чөлөөлөх үндэслэлтэй бол.</p>	<p>Зохицуулалт байхгүй.</p>
<p>Дээрх зохицуулалт нь хуульд шинээр орсон зохицуулалт бөгөөд гаднын орнуудад түгээмэл ашигладаг ба нийгмийн хор аюул ихтэй, ээдрээ төвөгтэй, шийдвэрлэлт удаантай, нуугдмал гэмт хэргийн талаар ач холбогдол бүхий зүйл мэдэж байгаа этгээдээс гэрчээр мэдүүлэг авч, холбогдох нотлох баримтыг цуглуулдаг байна. Ингэснээр тухайн гэмт хэргийг шийдвэрлэх боломжийг бий болгосон ач холбогдолтой зохицуулалт юм.</p>	
<p>16.1.3 дугаар зүйл. Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллага, гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.</p>	<p>Нотлох баримтын ойлголтыг өргөжүүлсэн.</p>
<p>Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болохоор заасан шинэлэг зохицуулалт болсон. Иймд төрийн байгууллагуудаас явуулж байгаа бодит үнэнийг тогтоох зорилготой хяналт шалгалтыг нэг стандартад оруулж нотлох баримт, нотлох ажиллагааны нэг стандарт бий болгосноор дээрх заалт бүрэн хэрэгжиж, нотлох ажиллагааны давхардал гарахгүй. Хяналт шалгалтын үр дүн нь бодит үнэнд нийцэж гарах эрх зүйн үндсийг тавьсан заалт болсон.</p>	

ЭХХШТХ	ЭБШХ
<p>16.8 дугаар зүйл. Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох</p> <p>Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан... мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар мөрдөгч нууц ажиллагааны магадалгаа үйлдэж, прокуророор баталгаажуулж хавтаст хэрэгт тусгана.</p>	<p>79.3. Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална.</p>
<p>Нууц мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулсан баримтат мэдээллийг хавтаст хэрэгт заавал тусгах, түүнийг нотлох баримтаар тооцох эрх зүйн зохицуулалт болж өгсөн.</p>	
<p>16.10 дугаар зүйл. Нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шийдвэрлэх</p> <p>Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт тусгаж хавсаргана.</p>	<p>Зохицуулалт байгаагүй боловч доорх оролцогчдод баримт сэлт гаргаж өгөх талаар зохицуулалт байсан. Үүнд:</p> <p>35.2. Сэжигтэн нь дор дурдсан эрх эдэлнэ:</p> <p>35.2.3. баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;</p> <p>36.3. Яллагдагч нь дор дурдсан эрх эдэлнэ:</p> <p>36.3.7. баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;</p> <p>42.3. Хохирогч, түүний төлөөлөгч нь дараах эрх эдэлнэ:</p> <p>42.3.2. баримт сэлт гаргаж өгөх.</p>
<p>Мөрдөгчөөс гадна дээрх оролцогчид тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг эрэн хайж түүнийгээ гаргаж өгснөөр тухайн зүйл нотлох баримтаар тооцогдох боломж бий болсон. Энэ нь яллагдагч өөрийгөө өмгөөлөхийн зэрэгцээ хэргийн бодит үнэнийг тогтооход эрх ашиг нь хөндөгдөн оролцож буй бүх оролцогч оролцох боломж бүрдсэн зохицуулалт юм.</p>	



ЭХХШТХ	ЭБШХ
<p>16.14 дүгээр зүйл. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх</p> <p>Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ.</p>	<p>93.3. Нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан соронзон болон дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ.</p>
<p>Техник технологийн үсрэнгүй хөгжлийн энэ үед мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж, түүний үр дүнг бэхжүүлэхдээ тухайн ажиллагааны агуулга, мөн чанарыг алдагдуулахгүй, тухайн байдлаар нь тусгаж буулгаж болох аливаа хэлбэрийг хэрэглэж болохоор нээлттэй хуульчилсан.</p>	
<p>25.5 дугаар зүйл. Мэдүүлэг авах тусгай журам</p> <p>Шүүх хуралдаанд гэрч, хохирогч, дүгнэлт гаргасан шинжээч биечлэн оролцож мэдүүлэг өгөх боломжгүй тухай мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл прокурор нь гэрч, хохирогч, шинжээчээс дуу-дүрсний бичлэг ашиглан мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгана. Энэ ажиллагаа нь хохирогч, гэрч, шинжээчийн шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх эрхийг хязгаарлахгүй.</p>	<p>270.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрч, хохирогчийн гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс ноцтой зөрсөн, түүнчлэн гэрч, хохирогч шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед тэдний гаргасан мэдүүлгийг уншиж сонсоно.</p>
<p>Уг зохицуулалт нь техник технологийн ололтыг шүүх хуралдааны явцад ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилготой зохицуулалт болсон. Цаашид одоогийн хэрэглээнд нь дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох хэрэгцээ байна гэж үзэж байна. Гэрч, шинжээч нарын хувьд нэгэнт шүүх хуралдаанд оролцуулах шаардлагатай гэж талууд үзсэн тохиолдолд мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгээс илүү нарийвчлан асуулт асуух зорилгоор хүсэлт гаргадаг. Асуух асуулт нь шүүхийн шатны мэтгэлцэгч нарын тактик байдаг тул урьдчилан мэдэгдэх боломжгүй. Ийм байхад мөрдөгч гэрч, шинжээчээс дуу дүрсний бичлэг ашиглан урьдчилан мэдүүлэг авах нь учир дутагдалтай. Иймд дуу-дүрсний бичлэг ашиглан, зайнаас уг оролцогчдыг оролцуулах нь талуудын тэгш эрхийг хангах, мэтгэлцэх нөхцөл бүрдүүлнэ. Уг оролцогчдын цаг, мөнгийг үрэхгүй байх, ингэснээр шүүхийн ажиллагаа хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай явагдах боломж бүрдэнэ.</p>	

ЭХХШТХ	ЭБШХ
<p>26 дугаар бүлэг. Мөрдөн шалгах бусад ажиллагаа</p> <p>Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох, ажиглалт явуулах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц ажиллагааны журам, нууц ажиллагааны магадалгаа</p>	<p>Зохицуулалт байгаагүй.</p>
<p>Гүйцэтгэх ажиллагаа буюу нууц заавар, журмаар зохицуулж явагддаг байсан ажиллагааг хуульчилж мөрдөн шалгах нууц ажиллагаа, түүнийг явуулах үндэслэл, журмыг зааж өгсөн нь хүний эрх, эрх чөлөөг хангах, нотлох ажиллагааны нийтлэг шаардлагад нийцүүлэх, ажиллагааны явцад цугларсан үйл баримтыг нотлох баримтаар тооцох, нотлох чадварыг нэмэгдүүлэх чухал нөхцөл болсон.</p>	
<p>27.11 дүгээр зүйл. Мөрдөгчийн магадалгаа</p> <p>Мөрдөгч энэ хуулийн 27.1 дүгээр зүйлд заасан шинжилгээг шинжээч томилж хийлгэх шаардлагагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоох боломжтой, эсхүл өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд тогтоох боломжтой гэж үзвэл магадалгаа гаргаж болно.</p>	<p>Зохицуулалт байгаагүй.</p>
<p>Аливаа тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд магадалгаа гаргах нь оновчтой, шинэлэг зохицуулалт бөгөөд практикт нэвтэрч эхэлж байгаа ба үр нөлөөтэй зохицуулалт болсон байна.</p>	
<p>28.2 дугаар зүйл. Дуу-дүрсний бичлэг хийх</p> <p>Мөрдөгч дараах мөрдөн шалгах ажиллагааг гэрэл зураг, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ: эзэмшигч, оршин суугч нь эзгүй байгаа орон байр, бусад газарт нэвтрэн орж явуулах, хэргийн газрын үзлэг хийх, эд зүйлийг түр хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөндлөнгийн гэрчтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаанд хөндлөнгийн гэрч оролцох боломжгүй бол.</p>	<p>28.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:</p> <p>28.2.3 хэргийн газарт үзлэг хийх, зураглал үйлдэх, дууны болон дүрс бичлэг хийх</p>
<p>Мөрдөн шалгах зарим ажиллагааг тэмдэглэл үйлдэхээс гадна заавал дуу-дүрсний бичлэгээр давхар бэхжүүлэхээр хуульчилсан нь техник, технологийн ололт, давуу талыг өргөн ашиглах, прокурор, шүүх техникээр баталгаажсан, хөдөлшгүй баримтад тулгуурлаж шийдвэрээ гаргах боломжтой болсон.</p>	

ЭХХШТХ	ЭБШХ
<p>35.17 дугаар зүйл. Мэдүүлэг уншиж сонсгох</p> <p>Гэрчийн урьд өгсөн мэдүүлгийн тэмдэглэлийг уншиж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг талуудын хүсэлтээр шүүх хуралдаанд сонсгож, үзүүлж болно. Шүүх нь талууд, оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу хамгаалагдсан гэрчийг, эсхүл сэтгэл санааны дарамт, нөлөөллөөс хамгаалах зорилгоор гэрчийг шүүхэд ирүүлэхгүйгээр дуу-дүрсний төхөөрөмж ашиглан шүүх хуралдаанд оролцуулж, мэдүүлэг авч, асуулт тавьж, хариулт авч болно. Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах зорилгоор талууд, оролцогчийн санал, хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл, эсхүл шүүх өөрийн санаачилгаар шүүх хуралдаан явуулахад зориулан тусгайлан тоногдсон өрөөнөөс дуу-дүрсний дамжуулах хэрэгсэл ашиглан шүүх хуралдааны танхимд гэрчийн мэдүүлэг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.</p> <p>Гэрч нас барсан, эсхүл биечлэн мэдүүлэг өгөх чадваргүй болсон нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол гэрчийн яриаг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг сонсож, түүний гар бичмэлийг шинжлэн судална.</p>	<p>Зохицуулалт байгаагүй.</p>
<p>Гэрчийн аюулгүй байдлыг хангах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэтгэл санааны дарамт, нөлөөллөөс хамгаалах, гэрчийн мэдүүлэгт хөндлөнгийн нөлөөлөл орохгүй байхад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон.</p>	
<p>16.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх</p> <p>Энэ зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй гэж заасан.</p>	<p>79.4. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.</p>

ЭХХШТХ	ЭБШХ
<p>Уг зүйл ангийн гарчиг нь “нотлох баримтыг” гэж өргөн хүрээг хамрахаар заасан боловч агуулга нь “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй” гэж явцууруулж зохицуулсан байна. Нотлох баримт гэдэг нь өргөн утгатай ойлголт бөгөөд мэдүүлэг нь зөвхөн нэг төрлийн аргаар цуглуулсан нотлох баримт юм. Гэтэл эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлгийг газар дээр шалгах ажиллагаа явуулах, хүний биед нэгжлэг хийх, хүний биед үзлэг хийх зэрэг ажиллагаа явуулж болзошгүй. Хэдий тийм боловч хуулийн зохицуулалтаараа эдгээр ажиллагааны үр дүнд цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг нотлох баримтаас хасах зохицуулалт байхгүй байна. Мөн Эрүүгийн хуулийн “Эрүү шүүлт тулгах” гэсэн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол...” гэж тодорхойлсон байна. Иймд эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж авсан мэдүүлэг болон бусад баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй байх өөрчлөлтийг ЭХХШТХ-д нэмж оруулах зайлшгүй шаардлагатай. Энэ нь Монгол Улсын олон улсын гэрээнд ч мөн нийцэх юм.</p>	

ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 3-т прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно гэж хуульчилсан нь эрүүгийн процессоос өмнө болон зэрэгцэн хийгдсэн төрийн бусад байгууллагын холбогдох хууль тогтоомжийн дагуу цуглуулсан баримт, мэдээллийг хэрэгт шууд нотлох баримтаар тооцох хууль зүйн боломж олгосон. ЭХХШТХ батлагдахаас өмнө цагдаа, хяналт шалгалтын байгууллагуудын техник хэрэгсэл ашиглаж бэхжүүлсэн хяналтын болон урьдчилан сэргийлэх бичлэг, мэдээллийг эрүүгийн хэргийн нотлох баримт болгохын тулд бүх ажиллагааг эхнээс нь хийх, үзлэг, хураан авах ажиллагаа хийх, байцаалт авах зэргээр процессын хувьд давхардал, хүнд суртал үүсгэж байсан. Гэвч шинээр зохицуулалт бий болсон ч “баримт, мэдээллийг эрүүгийн хэрэгт хэрхэн нотлох баримт болгох журам байхгүй” гэдэг үндэслэлээр төдийлөн үр дүнтэй хэрэглэхгүй байгаа нь судалгаанд хамрагдсан оролцогчдын мэдээллээс харагдаж байна.

ЭХХШТХ батлагдсанаас хойш гурван жил хагасын хугацаанд 2019 оны 10 дугаар сарын 18, 2019 оны 12 дугаар сарын 10, 2020 оны 1 дүгээр сарын 10, 2020 оны 5 дугаар сарын 1-нд тус тус өөрчлөлт оржээ. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаатай холбоотой зарчмын өөрчлөлт ороогүй. Харин мөн хуулийн 24.5 дугаар зүйлд заасан “Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах”, 26.1 дүгээр зүйлд заасан “Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах” ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхой болгож нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

**Бусад эх сурвалж.** Нотолгооны эрх зүйн зохицуулалт нь ЭХХШТХ-аас гадна Цагдаагийн албаны тухай, Авлигын эсрэг хуулиудаар зохицуулагдаж байна. Харин Тагнуулын байгууллагын тухай хуульд ийм зохицуулалт байхгүй. ЭХХШТХ-ийн 1.2 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөвхөн ЭХХШТХ-ийн дагуу явахаар хуульчилсан. Энэ нь ЭХХШТХ-д заагаагүй бол өөр бусад хуулиас иш татаж хэрэглэхгүй байх тухай зохицуулалт юм. Харин Цагдаагийн албаны тухай хуулийн 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 36, 37, 38, 39, 40, 46 дугаар зүйлүүд, Авлигын эсрэг хуулийн 24 дүгээр зүйлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хийгддэг ажиллагаануудыг давхардуулан (үзлэг, хураан авах, битүүмжлэх) болон илүү нарийвчлан (хүн, хуулийн этгээдийн бичиг баримт шалгах, тээврийн хэрэгсэл шалгах гэх мэт) мөн хуулиар зохицуулаагүй харилцаа (тайлбар авах, шаардлага тавих, түр саатуулах, орон байранд нэвтрэн орох гэх мэт)-г тус тус зохицуулсан байна. Энэ нь хэргийн нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал бий болгоход нөлөөлж байгааг судалгаанд хамрагдсан мөрдөгчид хүлээн зөвшөөрч байв. Түүнчлэн тэд эдгээр үйл ажиллагааг хооронд нь хэрхэн уялдуулах, зааг ялгааг нь хэрхэн ойлгох талаар тодорхой мэдлэг байхгүй, өмнөх уламжлалт аргаараа нотлох баримт цуглуулж, бэхжүүлдэг байна.

## ЖИШЭЭ 1. МӨРДӨГЧТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

1. Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу тайлбар аваад тээврийн хэрэгсэл шалгаж түүнд тулгуурлан бусад нотлох баримт цуглуулж, бэхжүүлсэн тохиолдолд прокурор, дарга нар нотлох баримтаар хүлээн зөвшөөрдөггүй. Дахин ЭХХШТХ-ийн дагуу бүгдийг давтаж хийх хэрэг гардаг нь цаг хугацаа их зарцуулж, ажлын хиймэл ачаалал үүсгэдэг.
2. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх гэхээр машинаа онгойлгож өгдөггүй, багаажийг эвдээд үзэх гэхээр хууль зөрчсөн гээд арга хэмжээ авхуулна, прокуророос зөвшөөрөл авна гэвэл хэдэн өдрийн ажил болно. Чухал нотлох баримт тэнд байгаад үрэгдчихвэл яах бол гэдэгт прокурор огт санаа зовдоггүй. Гэтэл хохирогч ажлаа хийсэнгүй гээд хэл ам хийдэг. Иймэрхүү байдлаар бидний ажиллах боломж шинэ хуулиар их хумигдсан.

Эрүүгийн процессын чухал эх сурвалж нь Шүүхийн шинжилгээний тухай хууль юм. Уг хуулиар нь шүүхийн шинжилгээ хийх үндэслэл журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.<sup>19</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4-т зааснаар шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа энэ хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримталдаг.

### Дүгнэлт

Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зохицуулалт нь нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэдэг. Энэ нь хуулийн дагуу байх нь процессын шийдвэрийн гол үндэслэл билээ.

ЭХХШТХ-д нотлох баримтын шинэ төрлүүд, цуглуулах, бэхжүүлэх шинэ төрлийн аргууд бий болсон, техник хэрэгсэл ашиглах боломж илүү бүрдсэн, зарим

<sup>19</sup> Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт.

төрлийн мөрдөн шалгах ажиллагааг заавал дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх зохицуулалтыг тусгасан зэрэг дэвшил гарсан. Мөн төрийн байгууллагын гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болохоор зохицуулсан нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг бууруулах, цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх чухал зохицуулалт юм.

Эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх явцад дараах нэмэлт, өөрчлөлтийг ЭХХШТХ-д оруулах нь зүйтэй гэж дүгнэж байна. Үүнд:

1. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулах шаардлагатай нь судалгаагаар тогтоогдож байна. Тиймээс Цагдаагийн албаны тухай, Авлигын эсрэг хуулиудад тусгагдсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны зохицуулалтыг ЭХХШТХ-д тусгах, тэдгээр хуулиас холбогдох зохицуулалтыг хасах.
2. Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгийг нотлох баримт болгохгүй байх заалт хуульчлагдсан. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцахгүй байх талаар Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зохицуулалтууд тусгагдсан. Хэдий тийм ч мэдүүлэг авахаас өөр бусад аргаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлсэн бол нотлох баримтаар тооцохгүй байх зохицуулалтыг орхигдуулжээ. Иймд ЭХХШТХ-ийн 16.12 дугаар зүйлийн 1-д заасан “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэснийг “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь тогтоогдвол дээрх баримтат мэдээллийг ЭХХШТХ-ийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

### 1.3. Гадаад орны нотлох ажиллагааны эрх зүйн орчин

Эрх зүйн бүлүүдийн нотлох ажиллагаа нь баримталж буй зарчим, шүүгч, бусад оролцогчийн эрх зүйн байдал, шүүн таслах ажиллагааны онцлогоос хамааран өөр өөр байдаг. Англи-Саксоны эрх зүйн бүлд хамаарах улсуудад хэрэглэгдэж байсан яллах, Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах улсуудад хэрэглэгдэж байсан эрэн сурвалжлах гэсэн хоёр загвар байсан бол орчин үед эдгээрийн онцлог шинжүүдийг хадгалсан холимог загварыг улс орнууд хууль тогтоомждоо тусгах нь түгээмэл байна.<sup>20</sup>

#### **Иргэний нэхэмжлэлд үндэслэсэн, яллах загвар (*the accusatorial model*)**

Боолын нийгмийн зохион байгуулалттай улсуудад хохирогч этгээдийн гомдолд тулгуурлан нотлох ажиллагааг явуулдаг байв. Энэ нь хувийн нэхэмжлэлд үндэслэсэн Эрүүгийн байцаан шийтгэх (ЭБШ) ажиллагаа бөгөөд хохирогч эрхээ хамгаалахын тулд хувийн журмаар эрүүгийн хэргийг мөрддөг онцлогтой.<sup>21</sup>

Энэхүү загварын гол онцлог нь:

1. Нотлох баримт цуглуулж шүүхэд гаргаж өгөх үүргийг талууд хүлээнэ.
2. Шүүх идэвхгүй, төвийг сахигчийн байр суурьтай байна.
3. Нэхэмжлэгч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь шүүх хуралдааны явцад адил тэгш байр суурьтай байна.
4. Ээдрээ төвөгтэй хэргийг нотолж тогтооход эрүү шүүлт хэрэглэдэг. Яллагаанд тулгуурласан байцаан шийтгэх ажиллагаа нь “Гомдол гаргахгүй бол шүүхгүй” мөн “Хохирогч байхгүй бол шүүгч байхгүй” гэсэн зарчимтай. Өөрөөр хэлбэл, нотлох ажиллагаа ихэвчлэн эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүдийн хүсэл эрмэлзэлд түшиглэдэг. Хохирогч нь гомдол гаргахгүй бол Эрүүгийн процесс эхлэхгүй.

Шүүгч нь мөрдөн шалгах ажиллагааны явцад идэвхгүй, төвийг сахисан байр суурьтай байдаг бөгөөд тэрээр зөвхөн шүүн таслах ажлыг хариуцаж, шүүх ажиллагаанд оролцож буй этгээдийн мэдүүлгийг сонсож, талуудын гаргаж өгсөн нотлох баримтыг хянаж тунгаах замаар хэргийн бодит байдлыг тогтоон шийдвэр гаргадаг.

**Эрэн сурвалжлах загвар (*the inquisitorial model*).** Мөрдөн шалгах байгууллага хохирогч гомдол гаргасан эсэхээс үл хамааран эрүүгийн хэргийг

---

<sup>20</sup> Karen Muller, “Effect of the accusatorial system”, 2006, p. 13.

<sup>21</sup> Б.Бат-Эрдэнэ, “Монгол Улсын ЭБШ эрх зүй” (Ерөнхий анги), УБ., 2006, 40-41 дэх тал.



шалгадаг. Яллагдагч, шүүгдэгчийн эрх нь тодорхойгүй бөгөөд шүүгдэгчийн хэргээ хүлээсэн мэдүүлэг нь нотлох баримтын гол тулгуур гэж үздэг чиглэл юм”.<sup>22</sup>

Эрэн сурвалжлах загварын онцлог нь:

1. Мөрдөн байцаах, шүүн таслах үүргийг шүүх хариуцна.
2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутай гэж үзэж байцаах (*presumption of guilt*) зарчмыг баримталж, эрүү шүүлт хэрэглэдэг.
3. Хуулиар тогтоосон журмаар нотлох ажиллагаа явагдана. Мөн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох эсэх, нотлох баримтын нотлох чадвар ямар байхыг хуульд урьдчилан тогтоосон байдаг. Шүүгч өөрийн дураар журам тогтоодоггүй.<sup>23</sup>

Эрэн сурвалжлах загварын гол онцлог нь албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд гэмт хэргийн талаарх гомдол, нэхэмжлэл гаргасан эсэхийг үл харгалзан санаачилгаараа хэрэг үүсгэн нотлох баримт цуглуулж, бэхжүүлдэг.

ЭХХША-ны оролцогчийн эрх, үүрэг харилцан адилгүй. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь ЭХХША-ны явцад зөвхөн байцаагдах үүрэгтэй. Хохирогч нь хэдийгээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй эрх, үүргийн хувьд ялгаатай байдаг боловч бодит байдалд зөвхөн гомдол гаргагч төдий л байж, өнөөгийн ЭХХША-ны оролцогчийн эрх, үүргийг эдэлдэггүй. Мөрдөн шалгах байгууллага, албан тушаалтнууд илүү эрх мэдэлтэй байдаг. Шүүгч нь шүүн таслах, гомдлыг хянан шалгах, мөрдөн шалгах бүрэн эрхийг бүгдийг нь хэрэгжүүлж болдог.<sup>24</sup> Хэргийг шалгах ажиллагааны явцад шүүгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гадна хохирогч болон гэрчийг ч эрүүдэн шүүж болдог байна. Шүүхээс өмнөх шат буюу мөрдөн байцаалтын ажиллагаа нь хаалттай явагдана.

**Холимог хэлбэрийн байцаан шийтгэх ажиллагааны загвар.** Холимог загвар нь яллах болон эрэн сурвалжлах загварын онцлогуудыг багтаадаг. Энэхүү “холимог” загварыг доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Уг хэв маяг нь нэг талаас, шүүн таслах ажиллагааг амаар, ил тод, нээлттэй байх, мэтгэлцэх байдлаар явуулах ардчилсан зарчмуудыг тусгасан. Нөгөө талаас, мөрдөн байцаалтын шатанд яллагдагч, түүний өмгөөлөгчийн эрхийг зарим талаар хязгаарладаг,

<sup>22</sup> Б.Бат-Эрдэнэ, “Монгол Улсын ЭБШ эрх зүй” (Ерөнхий анги), УБ., 2006, 41 дэх тал.

<sup>23</sup> Prof. Madhav Prasad Acharya, “Inquisitorial Models of Justice”, Kathmandu School of Law, Article reprinted from KSL Journal (Vol. 1).

<sup>24</sup> Prof. Madhav Prasad Acharya, “Inquisitorial Models of Justice”, Kathmandu School of Law, Article reprinted from KSL Journal (Vol. 1).

хэрэг бүртгэгч, мөрдөгч хэргийг мөрдөн шалгахын зэрэгцээ хэргийн талаар тодорхой шийдвэр гаргадаг, хэргийн бодит үнэнийг тогтоох зарчмын хүрээнд ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгчид цагаатгах болон яллах, нотлох баримтын аль алиныг нь цуглуулдаг хувилбар юм” гэж тодорхойлсон байдаг.<sup>25</sup>

Холимог загварын онцлог нь:

1. Нотлох үүргийг мөрдөгч хүлээдэг.
2. Мөрдөн байцаах, шүүн таслах чиг үүргийг өөр өөр субъектэд хариуцуулсан.
3. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг урьдаас гэмт хэрэг үйлдсэн, гэм буруугүй гэж үзэж байцаан шийтгэх ажиллагаа явуулах зарчмыг (*doctrine of the presumption of innocence*) хэрэгжүүлнэ.
4. Нотлох баримтыг шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлдэг.

Холимог хэлбэрийн байцаан шийтгэх ажиллагааг шүүхээс өмнөх мөрдөн байцаах үе шат болон шүүх хуралдааны үе шат гэж хоёр хуваадаг. Мөрдөн шалгах байгууллага нь шүүхээс хараат байж, мөрдөн байцаах шатанд шийдвэрлэх асуудал нь шүүхээс хамааралгүй байдаг.<sup>26</sup>

Холимог загварын ЭХХША дахь мөрдөн байцаалтын шатанд эрэн сурвалжлах загварын онцлог нэлээд туссан байдаг. Холимог загварын мөрдөн байцаалтын шатанд хохирогч гомдол гаргасан эсэхээс үл хамааран байцаан шийтгэх ажиллагаа явагдах боломжтой. Хохирогчийн гомдлоор үүсдэг хэрэг байдаг ч гэсэн мөрдөн шалгах байгууллага нь гэмт хэрэг үйлдэгдсэнийг олж мэдвэл гомдол гаргаагүй байсан ч эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтыг заавал явуулна. Мөрдөн байцаах ажиллагаа нь эрэн сурвалжлах загварын адил хаалттай явагддаг.

Бид дээрх загварын онцлогийг тусгасан Эрүүгийн процессын дараах хуулиудад дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль
- ОХУ-ын Эрүүгийн процессын хууль
- БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль
- БНСУ-ын Эрүүгийн процессын хууль

---

<sup>25</sup> Б.Бат-Эрдэнэ, “Монгол Улсын ЭБШ эрх зүй” (Ерөнхий анги), УБ., 2006, 41 дэх тал.

<sup>26</sup> Жиу Бао Фэн, Жан Шиу Жүн, “Эрүүгийн заргын хуулийн онол”, Өвөр Монголын өөртөө засах орны Их сургуулийн хэвлэлийн хороо, Хөх хот, 2000, 9 дэх тал.

- АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны журам
- Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн нотлох ажиллагааны онцлог, техник хэрэгсэл ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалт.

### 1.3.1. Эрүүгийн процессын загвар хууль

Уг хууль 17 хэсэг, 346 зүйл, 420 тайлбартай. Тухайн хуулийн гол зорилго нь социалист тогтолцооны дараах болон шилжилтийн үеийг даван туулж буй улс, орнуудад эрүүгийн процессын хуулиа шинээр гаргах, шинэчлэн өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэхүйц үзэл баримтлал, суурь зарчмыг тодорхойлж, үлгэрчилсэн хуулийн хэв маяг, эх сурвалжийг гаргахад чиглэгдсэн. Тус загвар хуульд өндөр хөгжилтэй орон болон аль нэг систем, тогтолцооны шинжийг чухалчлан тусгаагүй, харин дундын буюу хосолсон зохицуулалт бүхий дэлхий нийтийн орчин үеийн түгээмэл хандлагыг тусгаснаараа ач холбогдолтой баримт бичиг болсон<sup>27</sup> хэмээн судлаачид үздэг.

## ХҮСНЭГТ 2. ЭХХШТХ, ДЭЛХИЙН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЗАГВАР ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ЭХХШТХ	Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.	Нотлох баримт <sup>28</sup> гэдэгт мөрдөн шалгалтын явцад үнэнийг тогтоож байгаа асуудал фактыг бий болгож, эсхүл баталгаажуулж, үгүйсгэж байгаа бүх арга хэрэгслийг хэлнэ.

Загвар хуульд нотлох баримтын хүлээн зөвшөөрөхүйц, эргэлзээгүй байдлыг хангах, шууд хамааралгүй буюу давхардсан, эсвэл дамжмал хамаарал бүхий баримт мэдээллийг нотлох баримтаас хасах, харилцан яриаг нотлох баримтад тооцохгүй байх зэрэг нөхцөлүүдийг нарийвчлан зааж, тайлбартайгаар тодорхойлжээ. Тодруулбал, нотлох баримтаас хасах тохиолдлуудыг манай улсын ЭХХШТХ-тай адил тодорхойлсон ч Эрүүгийн процесс (ЭП)-ын загвар хуулийн 234 дүгээр зүйлд “Олон улсын улаан загалмайн нийгэмлэг (ОУУЗН)-т шүүхэд гаргаж өгөхөөс татгалзах онцгой эрх олгогдсон аливаа мэдээ, баримт сэлт, бусад нотлох баримт”-ыг нотлох баримтаас хасдаг байна. Мэдүүлэг авахдаа

<sup>27</sup> Д.Баярсайхан, “Гадаад орнуудын эрүүгийн процесс”, УБ., 2015, 19 дэх тал.

<sup>28</sup> Evidence

дүрс бичлэг заавал ашиглах, мэдүүлгийн маягт бөглүүлэх, асууж ярилцах, тодруулан байцаалт авах зэрэг олон аргыг хуульчилжээ.

Энэ хуульд манай улсын Эрүүгийн процессын хуульд (ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйл) заасантай адил нотлох баримтуудыг тодорхой дурдаагүй ч хуульд заасан үндэслэлээр бэхжүүлсэн мөрдөн шалгах ажиллагаанаас гадна (238 дугаар зүйл) гэмт хэргийн газрын шинжилгээний тэмдэглэл, хувь хүн болон хувь хүний эзэмшлийн газарт хийсэн нэгжлэгийн тэмдэглэл, эд зүйлс, баримт бичгийг хураан авсан тэмдэглэл, биеийн байцаалт, техникийн бичлэг, ном, бичлэг болон бусад баримтыг нотлох баримтаар тооцохоор хуульчилсан. Мөн тухайн хуульд эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих байдлыг хуульчлаагүй нь нотлох ажиллагааг ямар хэмжээнд явуулах талаар бүрэн дүүрэн буюу орон зай, цаг хугацааны хамаарлын тухай ойлголт тусгагдаагүй байна.

Уг хуулийн 102 дугаар зүйлд зааснаар цагдаа, прокурор гэмт хэргийг мөрдөн шалгах явцад авч хэрэгжүүлэх бүхий л ажиллагааны тэмдэглэлийг хөтөлнө. Хэрэв ажиллагаа явуулж байхад тэмдэглэл бичих боломжгүй бол ажиллагаа дууссаны дараа нэн даруй хөтлөхөөр тусгажээ. Шүүх дээр нэмэлт нотлох баримт гаргах нөхцөл, боломжийг хуульчилж, яллах нотлох баримт бүхий хавтаст хэргийг шүүхэд шилжүүлэхийг хязгаарлаж, шүүхэд шилжүүлэхийн өмнөх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг заавал хийх, шүүх хуралдааныг шударгаар, эрх тэгш байдлыг хангаж явуулах зэрэг нийтлэг агуулгыг тусгасан байна.

Загвар ЭП-ын хуулийн 128 дугаар зүйлд прокурорын зөвшөөрлөөр компьютерын тодорхой мэдээлэл, цахилгаан холбооны мэдээллийн хадгалалтыг цахим хэрэгслээр дамжуулан хянах ажиллагааг илээр явуулж болдог байна. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, нотлох баримтыг бэхжүүлэх асуудлыг тус хуулийн 130 дугаар зүйлд зааснаар “Компьютерын мэдээлэлд нэвтрэх, мэдээллийг хуулбарлан авах, хадгалах, хадгалагдсан компьютерын холбогдох мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах, нэвтэрсэн компьютероос тухайн мэдээллийг устгах, эсхүл нэвтрэх боломжийг хязгаарлах” ажиллагааг илээр явуулахаар зохицуулжээ.

Мөрдөн шалгах нууц ажиллагаагаар болон техник хэрэгсэл ашиглан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар тус хуулийн 5 дугаар хэсэгт илүү нарийвчлан тусгасан. Монгол Улсын ЭХХШТХ-д нууц мөрдөн шалгах ажиллагаагаар нотлох баримт бэхжүүлэх ажиллагааг харьцангуй ерөнхий тусгасан бол загвар хуульд тухайн ажиллагааны явцад техник хэрэгсэл ашигласан, тухайн нотлох баримтыг нотлох баримтаар үнэлээгүй тохиолдолд хэрхэн устгах зохицуулалтыг тусгаснаараа онцлогтой.

### 1.3.2. ОХУ-ын Эрүүгийн процессын хууль

Энэ хуулийг 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ОХУ-ын Төрийн дум баталж, 2001 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 267 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. ОХУ-ын Эрүүгийн процессын хууль нь 6 анги, 19 бүлэг, 57 хэсэг, 475 зүйлтэй ба нотлох баримт, нотлох ажиллагааны талаар 3 дугаар анги, 10, 11 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй хуульчилсан байна.

Эрүүгийн процессын хуулийн нотлох баримтын талаарх зохицуулалт нь Монгол Улсын ЭХХШТХ-тай төстэй. Хууль, журам зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг яллагдагчийг буруутгах үндэслэл гэж үздэггүй, нотлох баримтаар тооцдоггүй байна. Нотлох ажиллагаа нь цуглуулах, шалгах, үнэлэх гэсэн гурван хэсгээс бүрдэх ба тодруулбал хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчээс мөрдөн шалгах ажиллагааны явцад болон бусад ажиллагааны хүрээнд цуглуулдаг байна.

#### ХҮСНЭГТ 3. ЭХХШТХ, ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ЭХХШТХ	ОХУ-ын Эрүүгийн процессын хууль
<p><b>Нотлох баримт</b></p>	<p><b>Нотлох баримт</b></p>
<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.</p>	<p>Нотлох баримт гэж хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүхээс тус хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэргийг нотлох, эсвэл үгүйсгэх нөхцөл бүрдүүлсэн, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулсан бүхий л мэдээллийг хэлнэ.</p>
<p>Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.</p>	<p>Нотлох баримтаар сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, гэрч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мэргэжилтний дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн тэмдэглэл, бусад бичиг баримтыг ойлгоно.</p>

ЭХХШТХ	ОХУ-ын Эрүүгийн процессын хууль
Нотлогдвол зохих байдал	Нотлогдвол зохих байдал
<ol style="list-style-type: none"> <li>1. Гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал);</li> <li>2. Гэмт хэргийг хэн үйлдсэн;</li> <li>3. Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;</li> <li>4. Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;</li> <li>5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;</li> <li>6. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон бусад байдал);</li> <li>2. Гэмт хэргийг хэн үйлдсэн, сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, үйлдсэн этгээдийн хувийн байдал;</li> <li>3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;</li> <li>4. Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал;</li> <li>5. Яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал, Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл байдал;</li> <li>6. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн замаар олсон хөрөнгө орлого гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг болон зохион байгуулалттай гэмт бүлэг, зэвсэгт бүлэг, хэт даврагсад ба терроризмыг санхүүжүүлэх зориулалттай хөрөнгө хураах нөхцөл байдал;</li> <li>7. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.<sup>29</sup></li> </ol>

Хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгч нь эрүүгийн хэрэгт цугларсан нотлох баримтыг шалгаж, эх сурвалжийг тодруулан нотлох баримтаар тооцох, үгүйсгэх нөхцөл байдлыг тодруулах үүрэгтэй. Нотлох баримт нэг бүрийг үнэлэхдээ эрүүгийн хэрэгт хамааралтай эсэх, хуулийн дагуу цуглуулсан нь найдвартай эсэх, хүлээн зөвшөөрч болох эсэх, баталгаатай эсэх талаас нь үнэлж, нотлох баримт бүхэлдээ эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэх талаас нь нэгтгэн дүгнэдэг.<sup>30</sup> Нотлох баримтын талаарх зохицуулалтын онцлогоос дурдвал, мэдүүлэг авах ажиллагааны явцад зөвхөн “Хөтөлсөн асуулт асуух”-ыг хуулиар хориглодог ба хуульд заасан бүхий л төрлийн аргаар нотлох баримт бэхжүүлэх ажиллагааг явуулж болдог.

<sup>29</sup> “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001, N 174-ФЗ (ред. от 31.07.2020).

<sup>30</sup> Д.Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүй”, УБ., 2014, 232-252 дахь тал.

Мөн энэ хуулийн 164.1 дүгээр зүйлд зааснаар цахим мэдээллийг хадгалж байгаа эх үүсвэрээс уг мэдээллийг техник, хэрэгсэл ашиглан хуулбарлаж авах боломжтой. Энэ талаар ямар төхөөрөмжөөс уг мэдээллийг ямар техник хэрэгсэл ашиглан хуулбарласан болон уг ажиллагааны дэс дараалал, гарсан үр дүн, хэрэглэсэн техник, хэрэгсэл зэргийг дэлгэрэнгүй дурдан, хуулбарлан авсан мэдээллийг тэмдэглэлд тусган, хавсаргах талаар хуульчилжээ.

Эдийн засгийн эсрэг гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх явцад цуглуулсан эд зүйл, баримт бичиг, цахим мэдээллийг эд мөрийн баримтаар тооцох ёстой. Эд зүйлийн овор хэмжээ болон бусад нөхцөл байдлын улмаас үзлэг хийх боломжгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөгч хүсэлт гарган үзлэг хийх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болдог байна. Хэрэв тухайн мэдээлэлд шинжээч томилж эд мөрийн баримтаар тооцох шаардлагатай бол шинжээчийн дүгнэлтийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор эд мөрийн баримтаар тооцох тогтоол гаргасан байхыг хуульчлан тусгасан. Мөн уг цахим нотлох баримтыг хадгалахдаа аюулгүй байдлыг хангах талаар зохицуулжээ. Түүнчлэн хураан авсан эд зүйл, баримт бичиг, бусад цахим мэдээллийг дээр дурдсан хугацаанаас хойш тав хоногийн дотор хууль ёсны эзэмшигчид нь эргүүлэн олгодог байна.

Дээр дурдсан ажиллагаа болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуульчилсан хугацаа нь хэрэг шалгах ажиллагааг удаашруулахаас сэргийлэх, нотлох баримтаар тооцох эсэх асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чиглэсэн зохицуулалт болсон. Өмгөөлөгч бичиг баримт, эд зүйлс, бусад баримт мэдээллийг хүлээн авах, өөрсдийнх нь зөвшөөрлөөр тайлбар авах, төр, олон нийтийн байгууллагаас мэдээлэл гаргуулан авахаар хүсэлт гаргах эрхтэй. Мөн хүний биед үзлэг хийх (магадалгаа)-дээ тухайн хүний бие дэх онцлог шинж, гэмт хэргийн ул мөр, гэмтэл шарх, согтуурал, мансуурлын зэргийг тогтоох зэрэг хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооход шинжээч томилох шаардлагагүй бол мөрдөгч үзлэг (магадалгаа) хийдэг байна.

### 1.3.3. БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль

Хятадын эрүүгийн процесс нь Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд бага судлагдсан бөгөөд одоо үйлчилж буй Эрүүгийн заргын хуулийг 1979 онд баталж, 1980 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш гурван удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. БНХАУ-ын ЭП-ын хууль нь 2 хэсэг, 5 анги, 17 бүлэг, 285 зүйлтэй ба нотлох баримтын талаар 5 дугаар бүлэгт “Гэрч баримт” нэртэйгээр хуульчлагдсан байдаг.

ХҮСНЭГТ 4. ЭХХШТХ, БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ЭХХШТХ	БНХАУ-ын Эрүүгийн процессын хууль
<p><b>Нотлох баримт</b></p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.</p>	<p><b>Нотлох баримт</b></p> <p>Гэрч баримт (нотлох баримт) гэж хэргийн үнэн байдлыг гэрчилсэн бодит явдал бүхнийг хэлнэ.</p>
<p>Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадалгаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.</p>	<p>Гэрчийн баримт (нотлох баримт)-д Бодисын гэрч, Бичгийн гэрч, Гэрчлэгчийн гэрч үг, Хорлогдогчийн тоочилт (Задлан шинжилгээний дүгнэлт), Ял хийснээр сэжиглэгдэгч, заалдагдагчийн өчиглөл ба зөвтгөл, Шалган тогтоолтын дүн, Хайн шалгалт, байцаалтын тэмдэглэл, Дуу, дүрс шингээлтийн материал<sup>31</sup> зэргийг үзнэ.</p>

Аливаа хэргийг таслан шийдэхдээ зөвхөн гэрч, баримтыг мөрдөн шалгаж ажиллагаа явуулах ба аман өчгийг хөнгөнөөр итгэж болохгүй хэмээн зохицуулжээ. Мөн нотлох баримтыг бүрэн дүүрэн байдал хангасан зөвхөн заалдагдагчийн өчиг байгаад өөр гэрч баримт байхгүй бол заалдагдагчийг ялтайгаар магадлах буюу эрүү шийтгэлээр шийтгэж болохгүй<sup>32</sup> гэж хуульчилсан байна. БНХАУ-ын ЭП-ын хуулиар нотлох баримтыг цуглуулахдаа эрүүгийн хэрэгт хамааралтай эсэх, хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой эсэх, хуулийн дагуу цуглуулсан эсэхийг тус тус шалгадаг байна. Уг хуульд зааснаар нотлох баримт цуглуулах нь төрийн албан тушаалтны ажил бөгөөд өмгөөлөгч нь тухайн гэрчийн зөвшөөрлөөр болон төрийн байгууллага, албан тушаалтны зөвшөөрлөөр нотлох баримт цуглуулан прокурорт хүргүүлэх эрхтэй.

Гэмт хэргийг илрүүлж, гэмт этгээдийг олж тогтооход чиглэсэн цагдаагийн процесс ажиллагаа бусад орныхоос өвөрмөц юм. Гэмт хэрэг үйлдэж байгаад баригдсан, ил тодорхой мэдээллээр шалгагдаж нотлогдсон этгээдийг цагдаагийн

<sup>31</sup> Б.Батзориг, Э.Зууннасан, “БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль”, УБ., 2006.

<sup>32</sup> Б.Батзориг, Э.Зууннасан, “БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль” УБ., 2006, 34 дэх тал.



алба хаагч саатуулан хорьж, 12 цагийн дотор мэдүүлэг авч, шуурхай байцаалт, шалгалт (хойшлуулшгүй ажиллагаа) явуулдаг байна. Цагдаа нь өөрийн эрх хэмжээнд тухайн этгээдийг 24 цаг хүртэл саатуулж, хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд шаардлагатай бол 3-30 хоног хүртэл сунгаж, мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулж болдог байна.<sup>33</sup>

БНХАУ-ын Эрүүгийн заргын хуулийн нотлох ажиллагааны эрх зүйн зохицуулалтад нотлох ажиллагааны аргууд бүрэн хуульчлагдсан ч манай улсынхтай харьцуулахад хэт ерөнхий тусгажээ. Үүнийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага бүр эдгээр ажиллагааг явуулах нарийвчилсан журамтай байдгаар тайлбарлаж болно. Хятадын эрүүгийн процесст баривчлагдсан буюу албадан саатуулагдсан этгээдийг сэжигтэн гэж тооцдог ба сэжигтэн, яллагдагч нь мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхгүйн дээр баривчлагдсан үеэс шууд өмгөөлөгч авах боломж хязгаарлагдмал байдаг.<sup>34</sup>

Мөн БНХАУ-ын судлаач, эрдэмтдийн үзэж байгаагаар уг ЭП-ын хуульд хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулах мөрдөн шалгах ажиллагаа, байцаалт (шинжээч томилох, шинжилгээ хийлгэх), шалган тогтоолт (мэргэжилтэн оролцуулах) зэрэг ажиллагааг хуульчилсан боловч шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдлыг, мөн яллагдагч шинжээчид асуулт тавих, тайлбар хийх, шинжээчээс татгалзах, уг шинжилгээнд оролцох зэрэг эрхийг бүрэн хуульчлаагүй, мөн хэргийг шалгаж байгаа байгууллагаас нөлөөлөл үзүүлдэг тул бүрэн дүүрэн, үндэслэлтэй дүгнэлт гаргаж чаддаггүй гэж дүгнэжээ.<sup>35</sup> Ялангуяа шүүх-сэтгэц, эмгэг судлалын шинжилгээний явцад нэмэлт, давтан шинжилгээгээр зөрүүтэй дүгнэлтүүд гарч, хэргийг шийдвэрлэхэд саад учруулдаг талаар дурджээ.

#### 1.3.4. БНСУ-ын Эрүүгийн процессын хууль

Энэ хууль 1954 оны 2 дугаар сард батлагдаж, 1954 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 12 удаагийн нэмэлт, өөрчлөлт оржээ. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль нь 2 хэсэг, 2 бүлэг, 3 дэд бүлэг, 493 зүйл ангитай.

---

<sup>33</sup> Пан Дунмэй, Гао Минсюань, "Становление и развитие китайского уголовного законодательства", Вестник, Санкт-Петербургского университета, 2018.

<sup>34</sup> Сун Цяоцяо, "Функциональная характеристика досудебного и судебного производства в уголовном процессе Китая", Санкт-Петербургский государственный университет, Выпускная работа магистратуры, Санкт-Петербург, 2017.

<sup>35</sup> Юань И., "Проблемы рассмотрения доказательств по новому УПК КНР", Зарубежные научные школы, 2018.

ХҮСНЭГТ 5. ЭХХШТХ, БНСУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ЭХХШТХ	БНСУ-ын Эрүүгийн процессын хууль
Нотлох баримт	Нотлох баримт
<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.</p>	<p>Нотлох баримт эрүүгийн хэрэгт шууд хамааралтай, процессын журмаар нотлогдсон баримт сэлтийг хэлнэ.</p>

Уг хуулийн 2 дугаар дэд бүлгийн 307 дугаар зүйлд “Нотлох баримтгүй бол шүүх хурал байхгүй” гэдэг зарчим буюу болж өнгөрсөн үйл баримт, фактыг судалж тодруулахдаа нотлох баримтад суурилна. Эрүүгийн хэргийн фактуудыг үндэслэлтэй эргэлзээг арилтал баталж нотолно. Мөн эцсийн шийдвэр гаргах шүүгч нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ гэж хуульчилжээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх сэжиг байгаа тохиолдолд прокурор гэмт этгээд, гэмт хэргийн баримт, нотлох баримтыг хайх, шалгах, олж авах мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг байна. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүхийн цагдаагийн ажилтны хүсэлтээр прокурор эрх бүхий дүүргийн шүүхийн шүүгчид хүсэлт гарган олгогдсон зөвшөөрлийн дагуу нотлох баримтыг хайх, шалгах, олох ажиллагааг шүүхийн цагдаагийн ажилтанд олгож болно.

Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад цугларсан бичиг баримт (бичмэл нотлох баримт)-аас гадна өөр бусад баримтыг (тухайлбал, гар зураг, фото зураг, дүрс, дууны бичлэг, компьютерын диск болон бусад мэдээлэл хадгалах зориулалттай эд зүйлсийг) нотлох баримтад тооцдог байна. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа сэжигтний мэдүүлэг өгч байгааг дүрс бичлэгээр бичиж болох талаар, хэрэв бичлэг хийх бол энэ тухай сэжигтэнд урьдчилан мэдэгдэж, байцаалтын бүх явцыг эхнээс нь дуустал, объектив нөхцөл байдлыг бичдэг ажээ. Бичлэг дууссаны дараа дүрс бичлэг бичигдсэн хэрэгслийг сэжигтэн, эсвэл түүний өмгөөлөгчийг байлцуулан битүүмжилж, сэжигтнээр гарын үсэг зуруулах, эсвэл тамгыг нь даруулан лацаддаг байна. Хэрэв сэжигтэн, эсвэл түүний өмгөөлөгч хүсэлт гаргавал дүрс бичлэгийг үзүүлж, бичлэгийн агуулгын талаар ямар нэг эсэргүүцэл гарвал уг эсэргүүцлийн гол утга санааг бичлэгт хавсаргадаг.

Шүүх хуралдаанд сэжигтний мэдүүлгийн бичлэг нь хууль ёсны дагуу, хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн арга, хэрэгслээр, итгэж болохуйц нөхцөл байдалд

хийгдсэн, шүүгдэгч өгсөн мэдүүлгээ тэр хэвээр нь хүлээн зөвшөөрч байгаа бол уг бичлэгийг нотлох баримтаар тооцдог байна.

Гэрчийг байцаах онцлогуудаас дурдвал, албаны нууцтай холбоотой мэдээллийн талаар байцаах гэж байгаа, энэ талаар тухайн гэрч мэдэгдсэн бол холбогдох олон нийтийн байгууллага, удирдах байгууллагаас зөвшөөрөл авч мэдүүлэг авдаг. Мөн хуульч, патентын хуульч, нотариатч, мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн татварын нягтлан бодогч, эмч, уламжлалтын эмч, шүдний эмч, эм зүйч, эх баригч эмч, сувилагч, шашны албан тушаалтан, эсвэл ийм мэргэжилтэй байсан этгээд мэргэжлийн шугамаар олж авсан, мэдсэн болон бусад этгээдийн нууцтай холбоотой асуудлаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй. Энэ талаар хамаарах этгээд мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн, эсвэл олон нийтийн эрх ашигт чухал шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэдүүлэг авч болдог байна. Гэрчээс мэдүүлэг авахдаа дуудан ирүүлсэн тал (прокурор, өмгөөлөгч, яллагдагч) эхэлж мэдүүлэг авсны дараа нөгөө тал нь мэдүүлэг, байцаалт авдаг.

Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, прокурорын хүсэлтээр хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны явцад мэдүүлэг өгч байгаа хүний амь нас, бие махбод болон оюуны санааны байдал, бусад шалтгааны улмаас шаардлагатай тохиолдолд тавгүй байдалд орно гэж үзсэн, эсвэл хохирогч 13-аас доош настай, зөв, бурууг ялгах, шийдвэр гаргах бие, оюун санааны чадваргүй тохиолдолд түүний дотнын хүнийг мэдүүлэг авах ажиллагааны явцад хамт байлцуулдаг.

Шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгааллын хуульд заасан хэргийн хохирогч, бэлгийн зүй бус харьцааны хэргийн улмаас хамгаалагдсан хохирогч, эсвэл тухайн хэргийн нийгмийн аюул, гэрчийн нас, бие, оюун санааны байдал, яллагдагчтай харилцах харилцаа, бусад нөхцөл зэргийг харгалзан яллагдагч болон бусадтай нүүрэлдэн мэдүүлэг өгөхөөс үүдэх сэтгэл зүйн дарамтын улмаас сэтгэл санаа нь гүн цочролд орох болзошгүй оролцогчдоос мэдүүлэг авахдаа шүүх прокурор, яллагдагч эсвэл түүний өмгөөлөгчийн саналыг үндэслэн видео болон бусад цахим хэрэгслээр тусгаарлах байрнаас мэдүүлэг авч болдог байна.

Прокурор, яллагдагч, өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хурлын явцыг шууд бичиж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж, шаардлагатай тохиолдолд бичлэгийн тэмдэглэл үйлддэг. Эдгээр бичлэг, тэмдэглэлийг хурлын тэмдэглэлээс ангид хадгалдаг бөгөөд прокурор, яллагдагч, өмгөөлөгч уг бичлэг, тэмдэглэлийг өөрийн зардлаар хуулбарлан авна.

Уг процессын хуулиар мөрдөн шалгах, арга ажиллагааны нөхцөл, хэлбэрүүдийг нарийвчлан хуульчилж, албадлагын ажиллагаанд шүүхийн хяналт, зөвшөөрлийн системийг нэвтрүүлсэн, шүүхийн өмнөх шатанд эрүүгийн хэргийн нотлох ажиллагааг хэрэгжүүлэхэд өмгөөлөгч зохих үүрэгтэй оролцох явдлыг чухал хүчин зүйл болгосон ажээ.

### 1.3.5. АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны хууль

Энэхүү эрх зүйн акт 7 бүлэг, 132 зүйл, хавсралт хэсгээс бүрдэх ба тодорхой төрлийн ажиллагаа явуулах үндэслэл нь Нийтийн хангамжийн тухай, Галт зэвсгийн тухай, Сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодисыг хууль бус хэрэглэхтэй тэмцэх тухай, Гаалийн тухай, Иргэний нисэхийн тухай, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Атомын энергийн газрын хуулиуд болон Биеийн тамир, спортын тухай (Согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавих гэх мэт), Нум сумны тухай, Эрүүгийн хууль сахиулах тухай, Ан амьтан хууль бусаар агнахаас сэргийлэх тухай, Бугын тухай, Далайн хавыг хамгаалах тухай, Баджер (тарвагатай төстэй мэрэгч амьтан) хамгаалах тухай, Байгаль, хөдөөг хамгаалах тухай, Терроризмтой тэмцэх тухай, Эрүүгийн болон нийгмийн хэв журам сахиулах тухай зэрэг хуулийг баримтлан явуулдаг байна.

Нотлох баримтын тухай холбооны хууль нь нотлох баримтын талаарх ойлголтуудыг нэгтгэх, нотлох баримттай холбогдсон харилцааг зохицуулан шүүхийн шатанд иргэдийн төлөөлөгчдийн шийдвэр гаргахад нэгдсэн чиглэл өгөх зорилготой. Уг хууль бусад орны Эрүүгийн процессын хуулиудаас онцлог бөгөөд нотлох ажиллагааны зорилго, нотлох баримт цуглуулах төрөл, арга, хэрэгсэл, нотлох баримтыг шалгаж үнэлэх тухай цогц ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

**ХҮСНЭГТ 6. ЭХХШТХ, АНУ-ЫН НОТЛОХ БАРИМТЫН ТУХАЙ  
ХОЛБООНЫ ЖУРМЫН ХАРЬЦУУЛАЛТ**

<b>ЭХХШТХ</b>	<b>АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны журам</b>
<p><b>Нотлох баримт</b></p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.</p>	<p><b>Нотлох баримт</b></p> <p>Эрүүгийн хэрэгт шууд хамааралтай, процессын журмаар нотлогдсон баримт сэлтийг хэлнэ.</p>
<p><b>Нотлох баримтын ангилал</b></p> <p>Хуулиар ангилаагүй.</p>	<p><b>Нотлох баримтын ангилал</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүхийн өмнөх шатны;</li> <li>2. Шүүхийн шатны;</li> <li>3. Цуу үгэн нотлох баримт;</li> <li>4. Маргаангүй нотлох баримт;</li> <li>5. Туслах чанарын нотлох баримт;</li> <li>6. Нэмэлт нотлох баримт;</li> <li>7. Баталсан нотлох баримт;</li> <li>8. Үгүйсгэсэн нотлох баримт;</li> <li>9. Урьдчилсан нотлох баримт;</li> <li>10. Таамагласан нотлох баримт;</li> <li>11. Баталгаатай нотлох баримт;</li> <li>12. Итгэл төрүүлж болохуйц нотлох баримт.</li> </ol>

Бусад улс орны процессын хуульд байхгүй нотлох баримтын нэг төрөл буюу цуу үгэн нотлох баримт (цуу үгэнд үндэслэж мэдүүлэх)-ыг энэ хуулийн наймдугаар бүлэгт тусгасан. Энэ нь мэдүүлэг өгч байгаа этгээд гомдол гаргасан баримтын үнэн зөвийг батлах зорилгоор сураг ажиг бүхий мэдээллийг батлахаар өгч байгаа мэдүүлгийг хэлнэ хэмээн зохицуулжээ. Энэ журам өөрийн гэсэн онцлогтой бөгөөд гэмт этгээдийг баривчилсан, эсвэл баривчилсны дараа, эсвэл харилцаа холбооны хэрэгсэлд хяналт тавьж байхад, эсвэл нэгжлэг хийж байхад гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн талаар ярьсан яриаг сонссон цагдаагийн алба хаагчийн мэдүүлэг ордог байна. ОХУ-ын эрдэмтэн К.Ф.Гуценко “Энэ төрлийн зохицуулалтыг бусад орны эрүүгийн процессын ажиллагаанд хуульчилсан нь огт байдаггүй. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх бүхий л боломжийг үр дүнтэй ашиглахаар иргэдэд төрийн байгууллагатай хамтран ажиллах боломж бүрдүүлсэн зохицуулалт юм” гэж тайлбарлажээ. Уг журмын дагуу нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө шүүх дүрс бичлэг хийх камерын өмнө хохирогч, бусад тал оролцох эрхтэйг сануулан хэлэлцүүлэг явуулах бөгөөд хэлэлцүүлгийн дараа шүүхээс өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд хүсэлт, холбогдох баримт бичиг, хэлэлцүүлгийн бичлэгийг битүүмжлэн хадгалдаг байна.

### 1.3.6. Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хууль

Англид прокурорын институт байхгүй учир гэмт хэрэгтэй тэмцэх Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нэлээд өргөн хүрээнд хийгддэг ба төрийн нэрийн өмнөөс яллах ажиллагааг өмгөөлөгч, эсвэл тусгайлсан чиг үүрэг бүхий яллах алба хийдэг байна. Уг яллах алба нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааг үүсгэх, яллах нотлох баримтыг олж бэхжүүлэх, цагдаагийн илрүүлж мөрдсөн хэргийн нотлох баримтыг шалгах, яллах ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Уг ажиллагааг явуулах үндсэн эх сурвалж нь Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хууль байдаг ба нотолгооны стандарт, журмууд тэнд тусжээ. Уг хуулиар гэмт хэргийн талаарх баримт сэлтийг шалгаж цуглуулснаар нотлох баримт болохгүй, нарийвчилсан зохицуулалт бүхий зарчим, стандарт, шалгуурыг хангаж байж нотлох баримтаар үнэлэгддэг.

Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хуульд:

1. *Журам А.* Хүн ба тээврийн хэрэгслийг зогсоох болон нэгжлэг хийхтэй холбоотой цагдаагийн алба хаагчийн эрх;
2. *Журам В.* Хүний бие, орон байр, тасалгаанд нэгжлэг хийх, эдгээр ажиллагаагаар олдсон эд зүйлсийг хураах журам;
3. *Журам С.* Баривчлан саатуулах үйл ажиллагаа, бүртгэл хийх ба ярилцлага явуулах журам;
4. *Журам D.* Цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлэх таниулах буюу таньж олуулах ажиллагааны журам;
5. *Журам E.* Сэжигтэнтэй хийх ярилцлагыг бичих үед дагаж мөрдөх журам;
6. *Журам F.* Сэжигтэнтэй хийх дуут дүрс бичлэгийн журам;
7. *Журам G.* Цагдаагийн алба хаагчид хуулиар олгогдсон баривчлах эрхийн талаарх журам.

Англи Улс нь ярилцлага явуулах, байцаалт авах, гэрчийг нүүрэлдүүлэх, гэрэл зураг үзүүлэх, сануулга өгсний дагуу бичгээр мэдүүлэг гаргах, хураан авах болон хураагдсан эд зүйлийг хадгалах, нэгжлэг хийх, дотуур нэгжлэг хийх, хар тамхи хэрэглэсэн эсэхийг шалгах, эрүүл мэндийн байдлыг шалгах (ярилцлага хийснээр баривчлагдсан хүний бие, сэтгэцийн эрүүл мэндэд аюултай хор уршиг учруулах), таниулах буюу таньж олуулах ажиллагаа явуулах, хурууны хээ, хөлийн (гутлын) мөрөөр таниулах ажиллагаа явуулах (таниулах ажиллагааны

явцад тухайн хүний бие махбодын онцлогоос шалтгаалсан шинж тэмдгийг тодорхойлох зорилгоор), гэрэл зураг авах, үзлэг хийх, хүний биеэс дээж, хэв, хэлбэр авах зэрэг мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг.

Эдгээр ажиллагааг явуулахдаа Цагдаагийн алба хаагчийн хийх үйлдэл бүрийг, нотлох баримтыг хэрхэн бэхжүүлэхийг нэг бүрчлэн нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, ямар хэргийн холбогдолтой (тухайн хуулиудыг дээр дурдсан) этгээдийг хэрхэн зогсоох, хэрэв нүүрэндээ баг зүүсэн бол түүнийг хэрхэн авхуулах, биед нь үзлэг хийх, тэмдэглэл хийх шаардлагатай эсэх, хэрэв шаардлагатай бол ямар ажиллагааг тэмдэглэх зэргийг нэг бүрчлэн тусгажээ. Тодруулбал, Журам А буюу Хүн ба тээврийн хэрэгслийг зогсоох болон нэгжлэг хийхтэй холбоотой цагдаагийн алба хаагчийн эрх хэсэгт ерөнхий ойлголт, хүн ба тээврийн хэрэгслийг зогсоон нэгжлэг хийхтэй холбоотой үндсэн зарчмууд, зогсоох болон нэгжлэг хийх эрхийг тайлбарлах, үзлэг, нэгжлэг хийх үндэслэл, эрүүгийн ба нийгмийн хэв журам сахиулах тухай 1994 оны хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн үзлэг, нэгжлэг явуулах эрх олгох, нүүрний хаалт, багаа авахыг шаардах эрх, терроризмтой тэмцэх тухай 2000 оны хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу нэгжлэг хийх эрх (зөвшөөрөл) олгох, нэгжлэг хийх газар, нэгжлэг хийх журам, нэгжлэг хийхээс өмнө авах арга хэмжээ, тэмдэглэл хөтлөх шаардлага, хуулиар тусгайлан олгосон эрхийн бус (зөвшөөрөлгүй) тохиолдолд ямар тэмдэглэл хөтлөх, зогсоох, нэгжлэг хийх эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах, зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнууд тэмдэглэл үйлдэх зэрэг байдлаар нарийвчлан зохицуулсан. Уг журам дараах гурван хавсралттай ба хавсралт тус бүрт цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх ажиллагаа, нотлох баримттай харьцах үйл ажиллагааг нарийвчлан тусгасан байна.

Мөн уг журмын хавсралтуудад:

*Хавсралт А.* Зогсоон шалгах ба нэгжлэг явуулах эрхийн товчоон;

*Хавсралт В.* Цагдаагийн алба хаагч өөрөө хүний яс үндсийг тодорхойлох ангилал;

*Хавсралт С.* Олон нийтэд туслах цагдаагийн алба хаагчийн нэгжлэг хийх, хураан авах эрхийн товчоон болон нарийвчилсан дэд хэсэг болох:

1. Шалгуулагч этгээдээс зөвшөөрөл авахгүйгээр зогсоон шалгах ба нэгжих эрх;
2. Шалгуулагч этгээдийн зөвшөөрөлтэйгөөр хураан авах, нэгжлэг хийх эрх;

3. Шалгуулагч этгээдийн зөвшөөрөл шаардахгүйгээр хураан авах, нэгжлэг хийх эрх;
4. Шалгуулагч этгээдээс зөвшөөрөл хүсэхгүйгээр хураан авах нарийвчилсан журмыг хуульчлан зохицуулжээ.

Цагдаагийн алба хаагч нь электрон хэлбэрээр хадгалагдаж байгаа баримтыг нотлох баримт болно гэж үзвэл тухайн баримтыг харах боломжтой хэлбэрээр, эсхүл харах боломжтой байдлаар (тухайлбал гаргацтай, унших боломжтой байдлаар) авах бололцоог хангуулж хураан авах талаар тусгасан байна.

### **Дүгнэлт**

1. Гадаад орнуудын ЭП-ын хуулиуд эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран нотлох баримт, нотлогдвол зохих байдлыг өөр өөрөөр хуульчилсан ч гэмт хэргийг нотлох ажиллагаа, тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалт хоорондоо төстэй байна.
2. Гадаадын зарим улсын нотлох ажиллагааны эрх зүйн орчинд тулгамдсан асуудлууд байгаа ч тогтмол дүн шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулдаг байна. Тодруулбал, ОХУ-ын ЭП-ын хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 267 удаа буюу жилд дунджаар 14-15 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Ийм жишгээр ЭХХШТХ-ийн холбогдох заалтуудыг тухай бүр шинэчлэн, боловсронгуй болгох шаардлагатай.
3. Судалгаагаар зарим улсын ЭП-ын хуульд нотлох ажиллагаанд тодорхой төрлийн техник, хэрэгсэл ашиглах талаар нарийвчлан тусгасан байна. Тодруулбал, цахим мэдээллийг хадгалж байгаа эх үүсвэрээс нотлох баримтыг бэхжүүлэх, уг ажиллагааны дэс дараалал, гарсан үр дүн, хэрэглэсэн техник хэрэгсэл зэргийг тэмдэглэлд тусган бэхжүүлэх талаарх зохицуулалтыг хуульчилжээ. Үүнтэй адил ЭХХШТХ-д цахим нотлох баримтын талаар тодорхой зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.
4. Олон улсад хүний эрх, эрх чөлөөг хангах жишиг болдог улсуудын хувьд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааг дэс дараатайгаар, нэг бүрчлэн нарийвчлан зохицуулжээ (Хавсралт 1). ЭХХШТХ-д нотлох ажиллагаатай холбоотой харилцааг илүү нарийвчлан хуульчлах, эсхүл Нотлох баримтын тухай бие даасан хуультай болох нь зүйтэй.



5. Эрүүгийн процессын хууль нь нийт гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд ижил үйлчилдэг. Харин хуулийн этгээд, өсвөр насны хүмүүсийн хэрэг шалгахад тусгай журам үйлчилдэг. Бусад орны туршлагаас харахад тодорхой төрлийн гэмт хэрэг шалгах ажиллагааг тусгайлан хуульчилсан байгааг бид судалж нэвтрүүлэх боломжтой. Тухайлбал авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг шалган шийдвэрлэх тусгай журмыг хуульчлан тогтоож болох юм.
6. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ) болон түүнтэй адил хүчин чадалтай бусад улсын хуулиудыг судалж үзэхэд ихэнх хуулийн заалтууд нь ялангуяа хоёрдмол утгаар ойлгож болохоор зүйлүүдийг дор бүр нь тайлбарласан байдаг нь манай өнөөгийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгоход ихээхэн тустай болов уу.

# **Хоёр. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ, БЭХЖҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ АРГА ЗҮЙ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН АШИГЛААЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

## **2.1. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онцлог**

**Нотлох баримт цуглуулах ажиллагааны ойлголт.** Нотлох баримт цуглуулах ажиллагаа гэдэг нь талууд эсхүл хуулиар эрх олгосон албан тушаалтнуудаас хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт (мэдээлэл, нотлох баримтын эх сурвалж)-ыг хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр эрж хайх, олж илрүүлэх идэвхтэй үйл ажиллагаа юм. Талууд эсхүл эрх бүхий албан тушаалтан хуулиар тогтоосон журмаар прокурорын зөвшөөрөлтэйгөөр эсхүл бие даан нотлох баримт цуглуулдаг. Нотлох баримт цуглуулахдаа иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюултай, эсхүл тэдний нэр төрийг гутаасан ажиллагаа явуулах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглодог.

- 1. Прокурорын зөвшөөрөлтэйгөөр нотлох баримт цуглуулах.** Талууд эсхүл эрх бүхий албан тушаалтнууд тухайн ажиллагаа явуулах хуулиар тогтоосон үндэслэлээ прокурорт хүргүүлэн зөвшөөрөл авна. Уг зөвшөөрлийн дагуу тухайн ажиллагааг хэрэгжүүлэх албан тушаалтнаар дамжуулан нотлох баримт цуглуулдаг.
- 2. Бие даан нотлох баримт цуглуулах.** Талууд иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй, иргэдийн зан заншлын болон ёс суртахууны хэм хэмжээг гажуудуулалгүйгээр, хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй аргаар шаардлагатай баримт, мэдээлэл олж цуглуулна. Үүнд иргэн, хуулийн этгээдээс тодруулга, тайлбар авах, үзлэг хийх, шаардлагатай туршилтыг явуулах зэрэг ажиллагаа орно.

Прокурорын зөвшөөрөлтэйгөөр, дор дурдсан аргаар нотлох баримт цуглуулж болно. Үүнд:

- Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх;
- Нэгжлэг хийх;

- Эд зүйл, баримт бичиг хураан авах;
- Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох;
- Харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох;
- Харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- Харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- Харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- Харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах;
- Хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах;
- Оршуулсан цогцсыг гарган шинжлэх;
- Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;
- Хяналттай хүргэлт;
- Хяналтын худалдан авалт;
- Мөрдөн шалгах нууц туршилт;
- Нууц ажиглалт;
- Таньж олуулах ажиллагааг нууцаар хийх.

Нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны ойлголт. Нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагаа гэдэг нь хуульд заасан албан тушаалтан дангаараа буюу бусдын тусламжтайгаар цуглуулсан нотлох баримтуудыг хуульд заасан журмын дагуу бэхжүүлэх идэвхтэй ажиллагааг хэлнэ.

Нотлох баримтыг дараах аргаар бэхжүүлнэ. Үүнд:

1. Тэмдэглэл хөтлөх;
2. Бичлэг хийх (дуу, дүрс, дуу-дүрс), гэрэл зураг авах;
3. Зурж, тэмдэглэх (тодорхой эд зүйл болон байгаль орчныг байгаа байдлаар нь буюу тоймлон харж зурах);
4. Схем, зураглал үйлдэх (тухайн зүйлийг тодорхой дүрс, тэмдэгтээр орлуулан зурж тэмдэглэх);
5. График, шугам зураг үйлдэх (нотлох баримтыг техникийн маш нарийн үзүүлэлтээр нь зурж тэмдэглэх);

6. Эд зүйлийг бүхлээр нь бэхжүүлж авах (нотлох баримтыг байгаа байдлаар тухайлбал, унадаг дугуйг тэр хэвээр нь хураан авч бэхжүүлэх);
7. Тодорхой эд зүйлийн хэсэг буюу ул мөрийг буулгаж авах (тухайн эд ангийн тодорхой нэг хэсгийг авах тухайлбал, ачааны машины дугуйг салган авах);
8. Хүний нүүрний гадаад төрхөөс загвар авч бэхжүүлэх (хүний нүүр, бусад эд эрхтнийг бүхлээр нь буюу тодорхой хэсгээр нь тусгай хэв загвар авдаг бодисоор бэхжүүлж авах);
9. Нөхцөл байдлыг буюу бэхжүүлэн авсан зүйлийг сэргээн босгож бэхжүүлэх (дээр дурдсан аргаар бэхжүүлж авсан хэв загварыг буцаан сэргээж бодит байдлаар нь тогтоох, хүний хэлсэн мэдүүлэг, бусад нотлох баримтын дагуу ямар нэг орчин, эд зүйлийг сэргээн босгож бэхжүүлэн авах);
10. Харьцуулан шинжлэхээр хэв загвар авах.

**Нотлох баримтыг бэхжүүлэхэд шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг ашиглах нь.** Нотлох баримтыг бэхжүүлэхдээ шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг ашиглах нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Тухайн ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийн үйл хөдлөл, үг яриаг маш нарийн, нэг бүрчлэн тусгах боломжтой.
2. Тухайн ажиллагааг шуурхай явуулах урьдчилсан нөхцөл бүрдүүлдэг.
3. Оролцогчдоос гаргах хууль бус үйл ажиллагааг таслан зогсоодог.
4. Процессын хүндрэл гарах явдлыг таслан зогсоодог. Тухайлбал, мэдүүлэг өгөгч этгээд мэдүүлгээсээ буцах, нотолгоонд оролцогч этгээдүүд цуглуулсан нотлох баримтын ач холбогдлыг бууруулах төрөл бүрийн оролдлого гаргах зэргээс урьдчилан сэргийлдэг.
5. Эрүүл мэндийн хувьд тэмдэглэлтэй танилцах, удаан хугацаагаар ярилцах боломжгүй тохиолдолд нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүй байх гэх мэт болно.

Нотлох баримтыг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлж байгаа тохиолдолд дараах шаардлагыг хангана. Үүнд:

1. Техник хэрэгсэл ашиглаж байгаа талаар оролцогчдод мэдэгдэнэ.
2. Тухайн техник, хэрэгслийг ажиллуулахдаа шаардлагатай мэргэжилтнийг урьж оролцуулна.
3. Бичлэг хийхдээ хэсэгчилж хийхгүй, аль болох бүтэн хийнэ.

4. Хэрэглэсэн техник хэрэгсэл, дүрс, дууг буулгасан хальс болон бусад зүйлийн марк, загварыг тэмдэглэлд тодорхойлон бичсэн байх ёстой.
5. Ажиллагаа эхэлсэн, дууссан буюу завсарласан цаг, минутыг тусгана. Эдгээрийг хэлж бичүүлэх нь үр дүнтэй.

**Нотлох баримтыг бэхжүүлэх журам ба түүнийг зөрчсөнөөс үүсэх хууль зүйн үр дагавар.** Эрх бүхий ажилтнууд нотлох баримтыг бэхжүүлэхдээ дараах нийтлэг журмыг баримтална.Үүнд:

1. Нотлох баримт цуглуулах талаар явуулж байгаа үйл явцыг нарийвчлан, дэс дараалан, нэг бүрчлэн бичнэ.
2. Тухайн ажиллагааг хэд дэх удаагаа явуулж байгааг тэмдэглэлд тусгана.
3. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлж байгаа албан тушаалтан, оролцогчдын нэр, шаардлагатай хаяг болон бусад мэдээллийг тусгаж, тэдгээрт эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн эсэхийг тусгана.
4. Нотлох баримт цуглуулахдаа дүрс, дууны, дуу-дүрсний бичлэг хийсэн, гэрэл зураг авсан, схем, гар зураг үйлдсэн эсэхийг тусгана.
5. Нотлох баримт цуглуулах талаар явуулж байгаа ажиллагаа эхэлсэн, дууссан огноо тавина.
6. Тэмдэглэлд оруулсан завсар, өөрчлөлтийг тайлбарлана.
7. Нотлох баримт бэхжүүлж дууссаны дараа тэмдэглэлийг оролцогчдод уншиж өгсөн, уншуулсан эсэхийг, тэдний гаргасан санал хүсэлтийг тэмдэглэлд тусгаж гарын үсэг зуруулна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай байвал түүний нүүр болгон дээр гарын үсэг зуруулна.
8. Тэмдэглэлийг тухайн ажиллагааны явцад, эсвэл ажиллагаа дууссаны дараа бичнэ.

Нотлох ажиллагаа нь мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс эзэмшсэн мэргэжил, дадал, дадлага болон ур чадварын хүрээнд аливаа баримтат мэдээлэл, түүнийг агуулж буй эх сурвалжийн онцлогийг тодорхойлж, улмаар цуглуулж, бэхжүүлэх, шалгаж, үнэлэх, процессын шийдвэрт ашиглаж буй үйл ажиллагаа юм.

### 2.1.1. Гэмт хэргийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

“Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал” судалгааны ажлын ярилцлагаар “ЭХХШТХ-аар хэргийг мөрдөн шалгах, нотлох ажиллагаанд ямар нэгэн хүндрэл учирч байна уу?” гэсэн асуултад хариулт авсан

болно. Судалгаанд оролцогчид мөрдөн шалгах ажиллагаа, нотлох ажиллагаанд техник хэрэгсэл ашиглахад учирч буй бэрхшээл гэхээсээ илүү “зохиомол ажлын ачаалал нэмэгдсэн, олон шат дамжлагатай болсон, хуулиар олгосон эрх хэмжээ багассан, ихэссэн, хуулийг янз бүрээр ойлгон хэрэглэж байгаа” гэх мэтээр шүүх, прокурорын хүнд суртал, мөрдөгч, прокурор, шүүгчдийн ажлын мэдлэг, ур чадварын асуудлаар саналаа хэлж байв. Харин мөрдөн шалгах ажиллагааны арга барил, нотлох ажиллагааны талаар хөндөж ярих нь бага байлаа. Үүний шалтгааныг эрх зүйн зохицуулалтын хувьд чанарын өөрчлөлт гараагүй гэдгээр тайлбарлаж байв.

## ЖИШЭЭ 2. МӨРДӨГЧ, ПРОКУРОР, ШҮҮГЧ, ӨМГӨӨЛӨГЧТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

1. Прокурор заадаг, тушаадаг болсон, зарим нь бараг хуулиас давсан зүйл ярьснаа зөв гээд байдаг. Нотлох баримт яаж цуглуулдаг арга тактик, техник хэрэгслийн талаар мэдлэггүй. Өөрсдөөр нь хийлгэж үзмээр санагддаг.

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас*

2. ЭХХШТХ нотлох ажиллагааны зохицуулалтын хувьд харьцангуй боловсронгуй болсон гэж хэлж болно. Хуулийг нэг мөр хэрэгжүүлэхийн тулд улам боловсронгуй болгож, хийх зүйлийг нь нэгд нэгэнгүй нарийвчлан зааж өгсөн тохиолдолд бүрэн утгаараа хэрэгжих байх.

3. Одоо бол хуулийг өөр өөрийнхөөрөө тайлбарлаж хэрэглээд, дураараа болсон.

*Прокурортой хийсэн ярилцлагаас*

4. Нотлох ажиллагаатай холбоотой хуулийн хэрэглээ харилцан адилгүй байна. Шинэ хуулийн үзэл санаа шинэлэг зохицуулалтыг ашиглахгүй хуучин арга барилаараа ажиллаад байгаа нь ажиглагддаг.

*Шүүгчтэй хийсэн ярилцлагаас*

5. Нотлох ажиллагааны зохицуулалт сайжирсан. Хаа хаанаа хуулийг нэг мөр ойлгохгүй, хуучнаараа яваад байна. Илт мэдрэгдэж байгаа зүйл нь прокурорын эрх мэдэл нэмэгдсэн, мөрдөгчид даалгавар гүйцэтгэгч шиг болж, өмнөх шигээ хэрэг нотлох гэж зүтгэж ажилладаг нь бага болсон.

*Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас*

ЭХХШТХ-д нотлох баримт цуглуулах, бэхжүүлэхэд техник хэрэгсэл өргөн ашиглах, өмгөөлөгчийн зүгээс баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгах, үнэлэхтэй холбоотой олон шинэлэг зохицуулалт орсон боловч эрүүгийн процессын явцад эдгээр зохицуулалт төдийлөн ашиглагдахгүй, практик хэрэглээ нь үр дүн муутай байна. Жишээ нь, ЭХХШТХ-ийн 16.10 дугаар зүйл буюу “Нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шийдвэрлэх” гэсэн зүйлийн 1-д “хоширогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргаж

өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт тусгаж хавсаргана” гэж заасан. Тухайн зүйлийн гарчгаас харахад нотлох баримт гаргаж өгч байгаа үйлдэл байх боловч нотлох баримтыг үнэлэх эрх бүхий албан тушаалтнууд тухайн гаргаж өгсөн эд зүйл, бусад баримтыг шууд нотлох баримтаар тооцдоггүй ба заавал мөрдөн шалгах ажиллагаа явуулж цуглуулж, бэхжүүлсэн тохиолдолд нотлох баримтаар тооцдог байна.

### 2.1.2. Эрүүгийн хуулийн 10.1. Хүнийг алах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон ЭХ-ийн 10.1 дүгээр зүйл Хүнийг алах 10 гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүх ямар нотлох баримтуудыг ашиглаж байгаад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

**Өмнөговь аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 68 мэдүүлэг, хохирогчийн 19 мэдүүлэг, яллагдагчийн 15 мэдүүлэг, хэргийн газрын 10 үзлэг, 11 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 8 үзлэг, шинжээчийн 33 дүгнэлт, мэдүүлэг, эд зүйл хураан авах 5 ажиллагаа болон 5 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа болон таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилт;

**Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 69 мэдүүлэг, хохирогчийн 10 мэдүүлэг, яллагдагчийн 9 мэдүүлэг, хэргийн газрын 10 үзлэг, 13 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 8 үзлэг, шинжээчийн 31 дүгнэлт, мэдүүлэг, эд зүйл хураан авах 3 ажиллагаа болон 3 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа болон таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилт;

**Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 97 мэдүүлэг, хохирогчийн 17 мэдүүлэг, яллагдагчийн 15 мэдүүлэг, хэргийн газрын 11 үзлэг, 22 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 31 үзлэг, шинжээчийн 62 дүгнэлт, мэдүүлэг, эд зүйл хураан авах 6 ажиллагаа болон 10 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа болон таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилт;

**Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 71 мэдүүлэг, хохирогчийн 22 мэдүүлэг, яллагдагчийн 16 мэдүүлэг, хэргийн газрын 9 үзлэг, 15 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 16 үзлэг, шинжээчийн 39 дүгнэлт, мэдүүлэг, эд зүйл хураан авах 3 ажиллагаа болон 4 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа болон таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилтаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг шинжлэн судалж шийдвэр гаргажээ.



ГРАФИК 1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 10.1. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГ ДЭХ НОТЛОХ БАРИМТЫН ХАРЬЦАА





ГРАФИК 2. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХДЭЭ ШҮҮХЭЭС ШИНЖЛЭН СУДАЛСАН НОТЛОХ БАРИМТ



Дээрх судалгаанаас харахад шүүх хүнийг алах гэмт хэргийг нотлоход мэдүүлгэн нотлох баримт, хураан авах ажиллагаагаар цуглуулсан нотлох баримтад илүү ач холбогдол өгсөн байна.

### 2.1.3. Эрүүгийн хуулийн 17.1. Хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон ЭХ-ийн 17.1 дүгээр зүйл Хулгайлах 10 гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүх ямар нотлох баримтуудыг ашиглаж байгаад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

**Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 26 мэдүүлэг, хохирогчийн 21 мэдүүлэг, яллагдагчийн 20 мэдүүлэг, хэргийн газрын 11 үзлэг, 9 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 8 үзлэг, шинжээчийн 8 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 9 баримт болон 2 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа, таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилт;

**Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 44 мэдүүлэг, хохирогчийн 19 мэдүүлэг, яллагдагчийн 16 мэдүүлэг, хэргийн газрын 11 үзлэг, 22 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 8 үзлэг, шинжээчийн 24 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 12 баримт болон 4 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа, таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилт;

**Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 15 мэдүүлэг, хохирогчийн 12 мэдүүлэг, яллагдагчийн 12 мэдүүлэг, хэргийн газрын 7 үзлэг, 7 гэрэл зургийн үзүүлэлт, схем, 5 үзлэг, шинжээчийн 12 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 8 баримт болон 3 мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа, таньж олуулах ажиллагаа, мөрдөн шалгах туршилтаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг шинжлэн судалж, шийдвэр гаргажээ.

ГРАФИК 3. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 17.1. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТЫН ХАРЬЦАА





ГРАФИК 4. ШҮҮХ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХДЭЭ ШИНЖЛЭН СУДАЛСАН НОТЛОХ БАРИМТ



Дээрх судалгаанаас харахад шүүх хулгайлах гэмт хэргийг нотлоход мэдүүлгэн нотлох баримт, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан нотлох баримтад илүү ач холбогдол өгчээ.

#### 2.1.4. Эрүүгийн хуулийн 20.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигласан нотлох баримт

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон ЭХ-ийн 20.7 дугаар зүйл Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 10 гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүх ямар нотлох баримтуудыг ашиглаж байгаад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

**Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 14 мэдүүлэг, яллагдагчийн 20 мэдүүлэг, хэргийн газрын 11 үзлэг, 15 гэрэл зургийн үзүүлэлт, схем, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэх багаж ашиглан шалгасан 12 ажиллагаа, эд зүйл хураан авах 13 ажиллагаа, 6 үзлэг, шинжээчийн 35 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 30 баримт, хүний биеэс биологийн дээж авах 10 ажиллагаа;

**Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 27 мэдүүлэг, яллагдагчийн 23 мэдүүлэг, хэргийн газрын 7 үзлэг, 26 гэрэл зургийн үзүүлэлт, схем, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэх багаж ашиглан шалгасан 17 ажиллагаа, эд зүйл хураан авах 39 ажиллагаа, 32 үзлэг, шинжээчийн 40 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 10 баримт, хүний биеэс биологийн дээж авах 5 ажиллагаа;

**Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх:** Гэрчийн 13 мэдүүлэг, яллагдагчийн 21 мэдүүлэг, хэргийн газрын 12 үзлэг, 28 гэрэл зургийн үзүүлэлт, схем, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэх багаж ашиглан шалгасан 13 ажиллагаа, эд зүйл хураан авах 7 ажиллагаа, 14 үзлэг, шинжээчийн 34 дүгнэлт, мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан 19 баримт, хүний биеэс биологийн дээж авах 10 ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг шинжлэн судалж шийдвэрээ гаргасан байна.

ГРАФИК 5. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 20.7. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ





ГРАФИК 6. ШҮҮХҮҮД МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХДЭЭ ШИНЖЛЭН СУДАЛСАН НОТЛОХ БАРИМТ



Дээрх судалгаанаас харахад шүүх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг нотлоход бүхий л төрлийн нотлох баримтыг жигд шинжлэн судалсан байна.

### **Дүгнэлт**

1. Хэргийн зүйлээс үл хамаарч мэдүүлгэн нотлох баримтыг давамгайл ашигласаар байна.
2. Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгэн нотлох баримтын эзлэх хувь 35-56 байгаа нь аливаа хэрэг дээрх энэ төрлийн нотлох баримтын ач холбогдол өндөр байгааг харуулж байна.
3. Мөрдөн шалгах тодорхой ажиллагаа буюу төрөл бүрийн үзлэг, мэдүүлгийг газар дээр нь шалгах, таньж олуулах, мөрдөн шалгах туршилт, нэгжлэг зэрэг тодорхой ажиллагаанууд 8-15 хувийг эзэлж байгаа нь харьцангуй бага хувь юм.
4. ЭХХШТХ-д шинээр орсон магадалгаа гаргах, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагааг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж буулгасан талаарх нотлох баримтууд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байгаа нь тухайн төрлийн ажиллагааг хийж хэвших шаардлагатай болохыг харуулж байна.
5. Шинэ төрлийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгт олон төрлийн нотлох баримтыг жигд ашиглаж байна. Шинэ төрлийн болон зохион байгуулалттай гэмт хэргийг нотлох ажиллагаанд дэвшил гарч байгаа боловч орон нутагт энэ төрлийн гэмт хэрэг гарсан даруй нотлох ажиллагааг шууд хэрэгжүүлэх чадавх сул байна.

## **2.2. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд мөрдөгчийн ашиглаж байгаа техник, хэрэгсэлд хийсэн дүн шинжилгээ**

Мөрдөгч нь хэргийн газрын үзлэг хийхдээ тогтоосон орон байр, бусад газраас гадна хэргийн газрын хамгаалалтын бүсэд байгаа хүн, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, цогцос зэргийг хамруулан хамгаалалтын бүсийг тогтоож хамгаалалтад авах, хамгаалалтыг цуцлах, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, эзэмшигч, оршин суугч, шаардлагатай бол бусад хүнд хэргийн газрын хамгаалалтын бүсийн талаар мэдэгдэх, эсхүл бусдад ойлгогдохуйц тэмдэг тавих, хэргийн газарт байсан, орж ирсэн хүнийг үзлэг дуустал тухайн газраас явах, бусадтай болон бие биетэйгээ харилцахыг хориглох, ажиллагаанд саад учруулахгүй байхыг шаардана. Түүнчлэн хэргийн газрын хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх, эсхүл гарахад хязгаарлалт тогтоох, бүсээс гарахыг шаардах, албадан гаргах, хэргийн газар, хамгаалалтын бүсэд байгаа хүний бичиг баримтыг шалгах, хүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэн цуглуулж, бэхжүүлэх, аливаа зүйлийг бүхлээр нь, эсхүл хэсэгчлэн хураан авах, битүүмжлэх, хадгалах, хэргийн газарт байгаа хүний бие, эд зүйл, мал, амьтан, цогцсоос хэв загвар, дээж авах, хэргийн ул мөр бүхий түгжээтэй зүйлийг нээхийг шаардах, нээж шалгана. Мөн хэргийн газар, түүний дотор байгаа зүйлийн байр байдлыг бэхжүүлэхийн тулд дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, төр, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл алдагдах, эд хөрөнгө устах, үрэгдэхээс хамгаалах арга хэмжээ авах, шаардлагатай бол хэргийн газарт байгаа хохирогч, бусад хүнд эрүүл мэнд, сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авахаар тус тус хуульд заасан байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад шаардлагатай гэж мөрдөгч үзвэл мэргэжилтнийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулдаг. Практикт нийслэлийн хувьд дүүргийн цагдаагийн газрын мөрдөгчид (мөрдөн байцаах тасаг, хэрэг бүртгэх тасаг), хөдөө орон нутагт зөвхөн мөрдөн байцаах тасгийн мөрдөгчид хэргийн газарт үзлэг хийдэг. Онц ноцтой, ээдрээ төвөгтэй хэргийн газрын үзлэгийг ахлах мөрдөгчид, эсвэл Нийслэлийн цагдаагийн удирдах газар (НЦУГ)-аас тусгайлсан үзлэг хийх бүрэлдэхүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (ШШҮХ)-гийн багтай хамтран хийдэг ажээ. Үзлэг хийж, нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ нотлох баримт, ул мөр, эд мөрийн баримтыг олж бэхжүүлэх, гэрэл зураг авах, дуу-дүрсний

бичлэг хийх, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах ажиллагааг жижүүрийн шинжээчийн хамт хийдэг.

Аймаг, нийслэл, дүүргийн криминалистикийн шинжилгээний тасгууд нь хэргийн газрын үзлэгт мөр илрүүлэх, мөр бэхжүүлэх, хэмжих, гарын хээний дардас авах хэрэгсэл, хэв хуулбар авах хэрэглэгдэхүүн, мөр тусгаарлах болон мөр битүүмжлэх хэрэгсэл бүхий иж бүрэн цүнх (Хавсралт 2) ашиглаж байна. Тухайн цүнхтэй адил цүнх цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах тасагт байдаг ч ашигладаггүй, тасгийн дарга нарын өрөөнд хадгалагддаг. Хэргийн газрын үзлэгийн цүнх нь мөр илрүүлж бэхжүүлэх наад захын шаардлагыг хангадаг боловч гэмт хэргийн газрын үзлэгт ашиглахад учир дутагдалтай, шаардлагыг бүрэн хангадаггүй гэж үзжээ.

Мөрдөгчдийн нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд ашиглаж байгаа техник хэрэгсэл нь ахуйн нийтлэг хэрэгцээнд ашигладаг эд зүйл байгаагаас шалтгаалж бичил ул мөр, хүний нүдэнд үл үзэгдэх, устаж үгүй болох эрсдэлтэй мөрийг илрүүлж бэхжүүлэхэд техник хэрэгслийн хувьд болон ур чадварын хувьд дутагдалтай байдаг байна.

Судалгаанаас үзэхэд мөрдөгчид нотлох баримтыг бэхжүүлэхэд дуу-дүрсний бичлэг, гэрэл зургийн аппаратыг түгээмэл ашигладаг ажээ. Нотлох баримтын шаардлага хангах дуу-дүрсний бичлэг хийх төхөөрөмж, гэрэл зургийн аппаратыг олон мөрдөгч дундаа ашигладгаас шалтгаалж гол төлөв өөрийн гар утсаар орлуулж байна. Энэ нь нотлох баримт устах, алдагдах эрсдэл дагуулахын зэрэгцээ, нотлох баримтын шаардлага хангах эсэхэд эргэлзээ төрүүлдэг.

Дараагийн түгээмэл хэрэглэдэг техник хэрэгсэл нь суурин компьютер, принтер бөгөөд эдгээр нь нотлох баримт бэхжүүлэх техник хэрэгсэл мөн боловч тэмдэглэл үйлдэхэд л голчлон ашигладаг. Цөөн тохиолдолд байршлыг нарийвчлан тогтоох GPS ашиглаж байна. Дийлэнх мөрдөгч эдгээрээс өөр техник хэрэгсэл ашигладаггүй гэсэн нь техник хэрэгслийн ололт дэвшлийг өргөнөөр ашиглаж чадахгүй байгааг харуулж байна. Мөрдөгчөөр ажиллаж байгаа ажилтнуудын нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглах бакалаврын түвшний ур чадвар ч харилцан адилгүй байна.



## ХҮСНЭГТ 7. ИХ, ДЭЭД СУРГУУЛИАС ХАМГИЙН ТҮГЭЭМЭЛ АШИГЛАЖ СУРДАГ НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛЖ, БЭХЖҮҮЛЭХ АРГА

Дотоод хэргийн Их сургууль төгсөгчид			
Сайн эзэмшсэн техник, хэрэгсэл	Гэрэл зургийн аппарат	Камер	Хувилах, хэвлэх техник
Бүрэн эзэмшээгүй техник хэрэгсэл	Ул мөрнөөс хэв, хээ буулгах	Гар зураг, схем үйлдэх	Бусад
Хууль зүйн бусад сургууль төгсөгчид			
Сайн эзэмшсэн техник, хэрэгсэл	Гэрэл зургийн аппарат	Камер	Хувилах, хэвлэх техник
Бүрэн эзэмшээгүй техник хэрэгсэл	Бусад ур чадварыг ажиллангаа эзэмшдэг.		

Дээрх хүснэгтээс харахад, хүн болгоны хувийн хэрэгцээнд ашигладаг техник хэрэгслийг сайн ашиглаж сурсан гэснийг сургалтаар олгодог ур чадвар гэж дүгнэхэд учир дутагдалтай. Дотоод хэргийн Их сургуулиас олгож буй гэмт хэрэг илрүүлэхэд нарийн мэргэжлийн техник хэрэгсэл ашиглах ур чадвар хангалтгүй байгаа бол хуулийн бусад их, дээд сургууль төгсөж, мөрдөгчөөр ажиллаж байгаа албан тушаалтны хувьд энэ чадварыг сургуулиас бус аль нэг байгууллагад ажиллах явцдаа эзэмшиж байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдоос сургуульд эзэмшсэн мэдлэг нотлох ажиллагаанд бүрэн ашиглагддаг эсэхийг тодруулахад “50:50 хувьтай” гэх хариулт өгсөн болно. Үүнийг сургалтын чанар, үр нөлөө, практик-онолын уялдаа холбоо хангалтгүй гэдгээр тайлбарлаж болох юм. Дотоод хэргийн Их сургууль энэ жил анх удаа тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч төгсгөж байгаа бөгөөд практик дадлага туршлага багатай гэж үзсэн учир судалгаанд хамруулаагүй.

### ЖИШЭЭ 3. ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГАТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Дотоод хэргийн Их сургууль энэ жил тусгай мэдлэгтэй мөрдөгч буюу мөрдөгч-шинжээчийг анх удаа төгсгөсөн. Бүх аймгийн дарга нар тэр төгсөлтөөс хүн авах гэж их л юм болж байна. Бараг бүгдээрээ төв газар ажиллахаар томилогдож байх шиг байна. Бидэнд ийм л мөрдөгчид илүү хэрэгтэй байна.

Мөрдөгч-шинжээчийн эрэлт хэрэгцээ аймаг, дүүрэгт байгаа ба тухайн мөрдөгчид хэрхэн ажиллах арга, аргачлалыг бүрэн боловсруулбал тэд “практик” арга барилд дасалгүй, хэрэг нотлох ажиллагаанд шинэ хандлага, шинэ арга барил нэвтрүүлэхэд маш их ач холбогдолтой гэж бид дүгнэж байна.

ЭХХШТХ-д тодорхой төрлийн нотлох баримт цуглуулах шинэлэг зохицуулалт тусгагдсан. Тодруулбал:

ЭХХШТХ-ийн 25.7 дугаар зүйл. Таньж олуулах

Уг зүйлийн 9 дэх хэсэгт энэ зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулах боломжгүй дараах тохиолдолд гэрэл зураг, эсхүл дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэг ашиглан таньж олуулж болно. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт таньж олох хүнийг түүнтэй гаднах байдлаараа адил төстэй хоёроос дээш хүний хамт таньж олуулах гэж байгаа хүнд харуулна. Таньж олуулахын өмнө таньж олох хүнийг бусад хүний дунд дуртай байрлалаа эзлэхийг хэлж, тэмдэглэлд тусгана. Мөн зүйлийн 8 дахь хэсэгт тусгайлан хүмүүс бэлдэхгүйгээр олон хүн цугларсан газар таньж олох хүн байгаа эсэхийг гэрч, хохирогч, яллагдагчид харуулж таньж олуулж болно гэж заасан. Уг зохицуулалт нь ЭХХШТХ-д шинээр орсон бөгөөд камерын хяналт ихэссэн өнөө үед таньж олуулах ажиллагаанд өргөн ашиглаж болох, уг ажиллагааг хөнгөвчлөх эерэг үр дүнтэй зохицуулалт юм. Гэвч уг шинэлэг зохицуулалтыг ашиглахгүй, ашиглахыг эрмэлзэхгүй байгаа нь судалгаанд оролцогчдын ярилцлагаас харагдаж байна.

Мөн хуулийн 32.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хавтаст хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах тухай оролцогчийн хүсэлтийг мөрдөгч хангах арга хэмжээ авна” гэж заасан боловч оролцогч болон өмгөөлөгчдөд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг танилцуулахгүй байх тохиолдол түгээмэл байдаг. Энэ нь талуудын тэгш мэтгэлцэх, мэтгэлцэхийн тулд тэгш мэдээлэлтэй байх эрхийг зөрчиж байгаа явдал юм. Мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангана” гэж заасан боловч хуулбарлах, хувилах гэдэг ойлголтыг мөрдөн байцаах алба болон прокурор, шүүхийн шатанд өөр өөрийнхөөрөө тайлбарлан хуулбарлаж, хувилж авах боломжоор харилцан адилгүй хангаж

байна. Жишээ нь, шүүхийн шатанд хэргийн материалтай танилцаж техник хэрэгсэл ашиглан хуулбарлан авах боломж олгодог бол мөрдөн шалгах шатанд мөрдөгч, прокурорын хувьд янз бүрээр ойлгон тайлбарлаж, ихэнх тохиолдолд техник хэрэгсэл ашиглаж хуулбарлаж авах боломж олгодоггүй.

ЭХХШТХ-ийн 16.14 дүгээр зүйлд “Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ” гэж техник, хэрэгслийн ололт дэвшлийг өргөн ашиглаж болохоор нээлттэй зохицуулсан боловч уламжлалт хуучны арга, техник хэрэгсэл ашигласаар байгаа нь алба хаагчдын хэрэглэж байгаа техник хэрэгслийн хангамж муу, хоцрогдсонтой холбоотой. Мөн удирдах байгууллага, алба хаагчдын зүгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулах шинэ арга зүйг нэвтрүүлэх, шинэ техник хэрэгсэл ашиглуулах сэдэл, дадал өгөх ажиллагаа хангалтгүй байна.

Мөрдөгчдийн хувьд нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглахад учирдаг бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Техник хэрэгслийн хангалт, хүрэлцээ муу.
- Техник хэрэгсэл ашиглах чадвар хангалтгүй.
- Хэрэг илрүүлэх, нотлох ажиллагааны талаарх мэдээлэл өгөх, техник хэрэгсэл ашиглах сургалт бусад сургалтаас бага хийгддэг.
- Будагч, илрүүлэх бодисын хангалт бага учир дадлага хийх боломжгүй.
- Шинэ техник хэрэгсэл ирэхэд ашиглах зааварчилгаа өгдөггүй учир амархан эвдэрдэг.
- Техник, технологи ашиглаж нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх аргачилсан заавар байдаггүй.
- Олон хүн дамжуулж ашигладаг учир эвдэрвэл хариуцлага тооцдог.
- Техник хэрэгсэл ашигласан тохиолдолд зураг угаах, засварлах гэх мэт зардлыг өөрөөсөө гаргадаг.

Дээрх нөхцөл байдлаас харахад нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга тактик, ашиглах техник хэрэгсэлтэй холбоотой асуудал нь эрх зүйн зохицуулалтаас илүү байгууллагын дотоод зохион байгуулалтын арга барилаас хамааралтай байгаа бөгөөд үүнийг *JCI* байгууллагаас хийсэн судалгааны дүгнэлт давхар баталж байна.

Уг байгууллагаас 2019 онд Мөрдөн байцаах албаны ажилтны сэтгэл ханамж, манлайллын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, “Алба хаагчдын ажлаас гаралтын түвшин”-ийг тодорхойлоход тэдний 70 хувь нь ажлаас гарах (албан хаагчдад боломж олдсон тохиолдолд ажлаа солих) сонирхолтой<sup>36</sup> байсан байна. Энэ нь ажлын ачаалал их, удирдлагын зохион байгуулалт, шинээр хэрэгжиж байгаа эрүүгийн багц хуулийн талаарх ойлголт нэг мөр биш, хангалтгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүндрэлтэй, мөн мөрдөн шалгах ажиллагааны тодорхой хэмжээний зардлыг өөрөөсөө гаргадаг, техник хэрэгсэл, бичиг хэргийн хангамж муу зэрэгтэй шууд холбоотой гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан мөрдөгчид “Мөрдөгч мэргэших, шинэ техник хэрэгсэл ашиглах, ур чадвар, арга зүйгээ сайжруулахад дараах хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна. Үүнд, ажлын ачаалал их, мөрдөн шалгах чиг үүргээс гадна цагдаагийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг (эргүүл, хамгаалалтад гарах, хурал зөвлөгөөнд оролцох гэх мэт), удирдлага, хяналт шалгалтын тогтолцоо нь давхардсан (тасгийн даргын, хэлтэс, газар, Мөрдөн байцаах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Цагдаагийн ерөнхий газар), албандаа итгэх итгэл үнэмшил муу, шилжилт хөдөлгөөн их, цалин, хангамж муу” гэхчлэн хариулжээ.

Мөрдөх арга барил хоцрогдсон гэдгийг “Мөрдөх албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Шилдэг мөрдөгч” тэмцээний зохион байгуулалтаас харж болно” хэмээн олон жил ажилласан мөрдөгчид хэлж байв. Уг тэмцээнд мөрдөгчийн эрх зүйн болон гадаад хэлний мэдлэг, сэтгэн бодох, бие бялдрын тэсвэр, морь, мотоцикл унах чадвар, мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах чадвар зэргийг шалгаж байна. Эдгээр шалгуур нь нийтлэг чадвар болохоос орчин цагийн мөрдөгчид эзэмшсэн байх мэдлэг, ур чадварыг бүрэн тодорхойлж чадахгүй. Энэ байдлаас дүгнэхэд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж байгаа Мөрдөн байцаах алба нь мөрдөгчдөд мөрдөн шалгах ажиллагаа явуулах шинэ арга зүйг эзэмшүүлэх, шинэ техник хэрэгсэл ашиглуулах сэдэл, дадал өгөх ажлыг хангалтгүй хийж байна гэж үзэхээр байна.

<sup>36</sup> JCI capital байгууллагаас 2019 онд хийсэн “Мөрдөн байцаах албаны ажилтны сэтгэл ханамж, манлайллын нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний тайлан”.

Дээр дурдсанчлан, хэрэг мөрдөн шалгахад учирдаг олон бэрхшээлийг хуульд нялзаах хандлага давамгайлсан нь ярилцлагын судалгааны явцад харагдаж байв. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нотлох ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хангаж байгаагийн гол баталгаа бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг билээ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн эсэх талаар гаргасан гомдол, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлтийг хэлэлцэхээр заасан. Судалгаанд хамрагдсан прокурор, өмгөөлөгч, ялангуяа өмгөөлөгчдийн зүгээс “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийж эхлээд хоёр жил гаруй болж байгаа ч практикт байгууллагуудад бодит байдлаар хэрэгжиж чадахгүй байна” гэж дүгнэсэн. Ер нь урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдлын талаар судалгаанд оролцогчид тодорхой ойлголтгүй байв.

Шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцүүлэхэд шүүхээс талуудын мэтгэлцэх зарчмыг бүрэн хангадаггүй бөгөөд өмгөөлөх талын зүгээс хүсэлт гаргаж хэлэлцүүлэг явуулахад зарим прокурор, шүүгчийн зүгээс хэргийг санаатайгаар удаашруулах зорилгоор хүсэлт гаргалаа гэж илэрхий хувийн байдлаар хандах тохиолдол түгээмэл байдаг байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр Монголын Криминологичдын холбооноос хийсэн бодлогын судалгааны дүгнэлт нь манай судалгааны дүнтэй ижил гарч байх тул энэхүү тайланд дэлгэрүүлэн бичсэнгүй.<sup>37</sup>

---

<sup>37</sup> [http://forum.mn/res\\_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf?fbclid=IwAR2h0MI\\_hQgjGvowQ4nenD7Dzj33tH1pkTNVj50drLN6Cu5liAOncrOd2f4](http://forum.mn/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf?fbclid=IwAR2h0MI_hQgjGvowQ4nenD7Dzj33tH1pkTNVj50drLN6Cu5liAOncrOd2f4)

#### ЖИШЭЭ 4. МӨРДӨГЧ, ПРОКУРОР, ШҮҮГЧТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Шинэ төрлийн болон зохион байгуулалттай гэмт хэрэг шалгах шаардлага гарвал шууд гардаад шалгах боломж муу, техник хэрэгсэл хангалтгүй байдаг тул төвөөс хүн дуудах буюу чиглэл авч ажилладаг. Тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөх талаар мэргэшүүлдэг боловч боловсон хүчин тогтвортой бус, орон тоо хангалтгүй байдаг.

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас*

Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгт хяналт тавих бол прокурорын зааврын дагуу ажиллана. Шаардлагатай бол мэргэжлийн хүмүүсээс тодруулна.

*Прокурортой хийсэн ярилцлагаас*

Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх шаардлага гарахад нотлох баримт шинжлэн судлахад шаардлагатай ном, материал хомс.

*Шүүгчтэй хийсэн ярилцлагаас*

Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэг буюу хүний наймаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, мөнгө угаах, кибер гэмт хэрэг, байгаль орчны эсрэг гэмт хэргийг мөрдөх ном, гарын авлага цөөнгүй гарсан. Тэрчлэн энэ чиглэлийн мэргэшүүлэх сургалт ихээр хийгддэг нь эдгээр гэмт хэргийг ЭХХШтХ-д заасан шинэ арга хэрэгслээр нотлох чадварыг нэмэгдүүлж байна. Гэсэн ч мэргэшүүлсэн албан хаагчид өөр тийшээ шилждэг, ном, гарын авлага нь нэг удаа тараагдаад дуусдаг, мөрдөх алба, прокурор болон шүүхийн байгууллагуудад хэрэгжсэн төслийн материал, сургалтын гарын авлага солилцох, хамтран сургалт зохион байгуулах, мэдээлэл солилцох нь сул байдаг байна. Энэ нь хуулийн болон тухайн гэмт хэргийг нотлох ажиллагааны талаар өөр өөр ойлголттой болоход голлон нөлөөлөх хүчин зүйл болж байна гэж судлаачдын баг дүгнэлээ. Үүнээс гадна нотлох ажиллагаанд техник хэрэгсэл ашиглахад мөрдөгч, өмгөөлөгчдийн дунд эсрэг тэсрэг хандлага ажиглагдлаа. Тухайлбал, мөрдөгчдийн хувьд техник, хэрэгсэл ашиглахад төвөгтэй байдаг гэсэн хандлага давамгайлж байна. Гэтэл өмгөөлөгчдийн хувьд нотлох ажиллагааны явцад техник хэрэгсэл ашиглах сонирхол өндөр байгаа бөгөөд энэ тухай хүсэлт тавьдаг ч зөвшөөрдөггүй байна.

## ЖИШЭЭ 5. МӨРДӨГЧТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Миний шалгасан эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт хяналт тавьж байсан прокуророос камерын бичлэгээр таньж олуулах ажиллагаа явуулах даалгавар ирсэн. Тухайн ажиллагааг явуулахад миний мэргэжил, арга зүйн туршлага дутсан тул тасгийнхаа туршлагатай гэсэн мөрдөгчдөөс асуухад зарим нь “Тийм юм гэж юу байдаг юм. Уламжлалт аргаар гурван хүний дунд зогсоож байгаад таньж олуулах ажиллагаа хий” гэж зөвлөсөн. Өөр нэг мөрдөгч “Тэгж байхаар тэр танина гэж байгаа хүнээсээ дахин мэдүүлэг авч байхдаа бичлэгээ үзүүлээд тэр хүнээ заалгачих, тэр нь амар” гэж зөвлөсөн.

## ЖИШЭЭ 6. ӨМГӨӨЛӨГЧТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

1. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны явцад дуу, дүрс болон дүрс-дууны бичлэг хийлгэх хүсэлт тавих боломжгүй бол өөрсдөө техник хэрэгслээр туслах гэхэд зөвшөөрдөггүй.
2. Салбартаа танигдсан шилдэг гэсэн мэргэжилтнүүдээр дүгнэлт хийлгэх саналыг хүлээн авдаггүй, тийм хүнээр дүгнэлт хийлгээд хэрэгт хавсаргадаг боловч хэрхэн нотлох баримт болгох зохицуулалт байхгүй учир төвөгтэй байдал үүсдэг.
3. Техник хэрэгсэл ашиглан хэргийн материалаас нотлох баримт хуулбарлан авах гэхэд мөрдөгч, прокурор зөвшөөрдөггүй бол шүүхийн шатанд зөвшөөрдөг.

Мөрдөгчдөд хэргийн газрын үзлэгийн цүнх, компьютер, принтер, дүрс бичлэгийн болон гэрэл зургийн аппарат, байршил тогтоох GPS, ул мөрнөөс хэв, хээ буулгах бодис, байцаалтын өрөө зэрэг техник хэрэгсэл ашиглаж байна. Эдгээрээс компьютер, принтер нь нотлох баримт бэхжүүлэх үндсэн арга болсон. Хэргийн газрын үзлэгийн цүнхний хүрэлцээ муу, түүнийг ашиглахад ихээхэн ур чадвар шаарддаг, олон иж бүрдэлтэй учир алга болдог гэсэн шалтгаанаар ихэвчлэн нэгжийн даргын өрөөнд эсхүл сейфэнд нь цоожтой байдаг байна. Гэрэл зургийн болон дүрс бичлэгийн аппарат нь олон мөрдөгч дундаа хэрэглэдэг, олдоц муу тул гар утсаараа зураг авахад хүрдэг. Ул мөрнөөс хэв,

хээ буулгах ажиллагааг мөрдөгчид дангаараа хийж гүйцэтгэх чадвар дутмаг тул жижүүрийн шинжээчийн тусламжийг авдаг ажээ.

Судалгаанд хамрагдсан хүмүүс мэдүүлэг авах өрөөг зөвхөн байцаалт явуулах зориулалтаар л ашиглаж байна. Тус өрөөг мэдүүлэг өгөгчийн хувийн зан авир, үнэн зөв мэдүүлэг өгч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх зэрэгт төдийлөн ашиглахгүй, энэ ажиллагааг гүйцэтгэх чадвар эзэмшээгүй тал ажиглагдлаа.

Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглахаас төвөгшөөх, улмаар “байцаалт”-д суурилсан нотлох ажиллагаа явуулахаас өөр аргагүй байдалд орж байна. Улмаар мэдүүлэгт бус бусад нотлох баримтад тулгуурлан нотлох ажиллагаа явуулахад чиглэсэн ЭХХШТХ-ийг хүндрэл учруулж байгаа гэх хандлага судалгаанд хамрагдсан мөрдөгчдөд нийтлэг ажиглагдлаа. Мөрдөгчдийн дунд байгаа энэхүү хандлага ЭХХШТХ-ийг мэдүүлэгт буюу “байцаалтад” суурилсан нотлох ажиллагаа руу шилжүүлсэн “эрүүгийн процессын ухралт” болж болзошгүй.

### **ЖИШЭЭ 7. МӨРДӨГЧ, МӨРДӨХ АЛБАНЫ ДАРГА НАРТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА**

Мэдүүлэг авах гэхэд гэрчүүд өмгөөлөгчтэй ирдэг болсон. Дуудахад ирдэггүй, тэднийг дуудан ирүүлэх гэхэд заавал прокуророос зөвшөөрөл авах шаардлага гардаг. Мэдүүлгээсээ олон дахин буцдаг, сэжиглэж байгаа хүнээ дуудаад мэдүүлэг авах боломжийг энэ хуулиар хаасан учир цагдаагийн байгууллагын ачаалал илт нэмэгдэж, ажил хийхэд хүндрэлтэй болсон. Иймд хуульд эдгээр бэрхшээлийг арилгахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

### **Дүгнэлт**

1. ЭХХШТХ хүчин төгөлдөр хэрэгжээд гурван жил болсон ч мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчид ЭХХШТХ-ийн үзэл баримтлал, шинэ төрлийн нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх аргуудын талаар нэгдсэн ойлголт байхгүй, шинэлэг зохицуулалтуудыг төдийлөн ашиглахгүй, уламжлалт хуучин арга, тактикаар нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх нь давамгай байна.



2. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын уг чиг үүргийг хэрэгжүүлэх алба хаагчид шинэчлэгдэж байгаа боловч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэн үнэлэхэд шинэлэг зохицуулалтыг ашиглахаасаа илүү уламжлалт аргуудыг ашиглах хандлага их байна. Энэ нь практик дээр гараад ахмад үеэсээ сурдаг, тэд шинэлэг арга, зохицуулалт гэхээсээ илүү уламжлалт аргаа зааж өгдөг, түүнийгээ илүүд үздэгтэй холбоотой.
3. Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчид хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх талаар учир дутагдалтай байна. Энэ нь хэргийн оролцогч, түүний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцаж, техник хэрэгсэл ашиглан хуулбарлан авах боломжийг мөрдөн байцаалтын шатанд олгодоггүй бол прокурорын шатанд харилцан адилгүй олгодог, шүүхийн шатанд чөлөөтэй олгодог байна.
4. Залуу алба хаагчдын хувьд шинэ төрлийн техник хэрэгслийг ашиглах чадвар өндөр боловч албан хэрэгцээнд ашиглах шинэ төрлийн техник хэрэгслийн хангамж хангалтгүй байдаг байна. Удирдах албан тушаалтнууд суурин компьютер, лазер принтер, зургийн аппаратыг мөрдөн шалгах ажиллагааны шинэ техник хэрэгсэл гэж үзэж байгаа нь судалгааны дүнгээс харагдсан.

## **2.3. Шүүхийн шинжилгээ хийхэд хэрэглэх арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдалд хийсэн дүн шинжилгээ**

### **2.3.1 Нотлох ажиллагаанд шүүх шинжилгээний байгууллага, шинжээчийн оролцоо**

Эрүүгийн хэргийг нотлох ажиллагааны явцад тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн, шинжээчийн туслалцаа болон дүгнэлт үнэн зөв, бодитой байхын тулд салбарын шинжлэх ухаан, онол, технологийн ололт, амжилтыг ашиглах шаардлагатай. Энэ нь хүний эрх бүрэн хангагдах шинжлэх ухааны үндэс болно. Манай улсын хувьд нотлох ажиллагааны арга, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаанд техник хэрэгсэл ашиглах хууль зүйн талаас илүү криминалистик, криминалистикийн тактик, арга зүй тал нь түлхүү хөгжсөн байдаг.

Эрх зүйн тогтолцооноос хамаарч криминалистикийн шинжлэх ухааныг зарим улс оронд өөрөөр нэрлэж хэвшжээ. Тухайлбал, Англи, Америкт *Criminal investigation* буюу Гэмт хэрэг мөрдөхүй, Япон болон зүүн өмнөд азийн орнуудад *Police science* буюу Цагдаагийн шинжлэх ухаан, Энэтхэг болон далайн зарим орнуудад *Forensic science* буюу Шүүх шинжлэх ухаан хэмээн нэрлэхийн сацуу

шинжлэх ухааны тогтолцоо, бүтэц, харьяалал нь ялгаатай байдаг<sup>38</sup> ч шүүх шинжилгээний үйл ажиллагаа нь нотлох ажиллагаанд голлох үүрэгтэй, гэмт хэрэг илрүүлэхэд багагүй хувь нэмэр оруулдаг.


ГРАФИК 7. ШШҮХ-гийн ШИНЖЭЭЧИЙН НОТОЛСОН ХЭРГИЙН СУДАЛГАА



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаас хойш ШШҮХ-гийн шинжээчдийн нотолсон хэргийн үзүүлэлт тогтмол байна (График 8). Эндээс гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд шинжээчийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сайжраагүй гэсэн дүгнэлт хийж болох юм. Нөгөө талаас, нотлох ажиллагаанд мэдүүлэгт суурилсан нотолгоо давамгайлсаар байгаа гэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг баталгаажуулж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөгчдийн нотлох ажиллагаанд мэдүүлгээс өөр нотлох баримт тухайлбал, шинжээчийн дүгнэлт, ур чадварыг ашиглах байдал нэмэгдсэнгүй. Мөн шинжээчдийн хувьд гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд оролцох оролцоо, хандлага хэвээрээ байгаагийн илэрхийлэл юм.

<sup>38</sup> Б.Лхагвасүрэн, Н.Баясгаланбат, “Криминалистик” Гарын авлага, УБ., 2013, 32 дахь тал.

ГРАФИК 8. ШШҮХ-гийн ШИНЖЭЭЧИЙН НОТЛОСОН ХЭРГИЙН СУДАЛГАА (БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДЛААР)



Нотлох ажиллагаа нь шинжлэх ухаан, технологийн арга барилаас илүү хүнээс хамаарах хүчин зүйл байсаар байгаатай өмгөөлөгчид санал нэгдэж байгаа бөгөөд нотлох ажиллагаанд оролцогчдын ойлголт, төсөөлөл өөр байна.

### ХҮСНЭГТ 8. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЛУУДЫН САНАЛ

Мөрдөгч	Өмгөөлөгч	Прокурор	Шүүгч
Монгол Улсад хийгдэж байгаа, шүүхийн шинжилгээ боломжийн байгаа гэж үзэж байгаа	Шүүхийн шинжилгээ боломжийн хийгддэг боловч тухайн дүгнэлтэд нөлөөлөл орж болзошгүй.	Шүүхийн шинжилгээ боломжийн хийгддэг.	Шинжээчдийн мэргэжлийн ур чадвар янз бүр байдаг.
Зардлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй.	Хэргийн газарт ажиллаж байгаа шинжээчдийн ашиглаж буй техник хэрэгсэл хуучирсан юм шиг харагддаг.	Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн хийдэггүй олон шинжилгээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар хийлгэхэд дүгнэлт нь шаардлага хангахгүй, нотлох баримтын хэмжээнд үнэлэхэд учир дутагдалтай байдаг.	Шинжээчид дүгнэлтээ хамгаалж шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх чадвар муутай.
Хэргийн газарт ажиллаж байгаа шинжээчдийн ашиглаж буй техник хэрэгсэл ул мөрийг бэхжүүлж авахад хангалттай байдаг ч шинжээчийн чадвараас шалтгаалдаг.	Үйлчлүүлэгч, ялангуяа хохирогч кинонд гардаг л зүйл хүсдэг.	Эд хөрөнгийн үнэлгээтэй холбоотой шинжилгээ хамгийн хэцүү байна. Зардлыг нь төлж чадахгүй болохоор дүгнэлт гаргуулан авч чадахгүй байгаагаас материал шийдвэрлэхэд хүндрэл учирдаг.	Өмгөөлөгчдийн шинжээчээс мэдүүлэг аваад хүчингүй болгуулах, эргэлзээ төрүүлэх чадвар сайжирч байгаа.

Прокуроруудын хувьд шүүх шинжилгээний байгууллагыг чадавхжуулах, хүчирхэг болгох тал дээр бүгд санал нэгтэй байснаас гадна шүүгчид шинжээчдийн мэдүүлэг өгөх чадварыг нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулж байлаа. Тусгай мэдлэгтэй шинжээчийн хувьд шүүх хуралд оролцож өмгөөлөгч, прокурорын элдэв “унагаах” асуултад хариулах чадвар сул байдаг. Энэ тохиолдолд ялангуяа хүнд ноцтой хэрэгт мэдүүлэг өгөх чадвартай шинжээчийг хамт томилж ажиллуулдаг гадаад орны туршлагыг анхаарах шаардлагатай. Мөн шинжээч бэлтгэхдээ энэ асуудлыг анхаарах нь зүйтэй.

### 2.3.2. Шүүхийн шинжилгээний байгууллагад хэрэглэх арга зүй, техник хэрэгслийн ашиглалтын байдалд хийсэн дүн шинжилгээ

Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд шинжлэх ухаан, техникийн буюу криминалистикийн арга, хэрэгслийг хэрэглэх шаардлага 1926, 1935 оны ЭБШХ-уудын үндсэн дээр гарч, тухайн үеийн Дотоодыг хамгаалах газар (ДХГ)-ын 1933 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 77, 1933 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 09 тоот тушаалууд, Дотоод явдлын яам (ДЯЯ)-ны 1942 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 09, 1947 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 827 тоот тушаалуудаар Дотоодыг хамгаалах газарт гэрэл зурагчин томилж лаборатори байгуулан,<sup>39</sup> үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, улсын цагдан сэргийлэх газрын шинжлэх ухаан, техникийн тусгай тасаг, хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулах болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх-нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан, 2009 оноос “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн” болгон өөрчилж, “Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлэн бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэсний дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

<sup>39</sup> Ч.Алтанхишиг, “Нэгэн жаран”, 2004, 12 дахь тал.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. *Криминалистикийн шинжилгээний газар.* Эрх бүхий байгууллагын шийдвэрээр мөр судлал, гарын мөр, галт зэвсэг, бичиг баримт, дүр зураг, дүрс бичлэг, компьютер судлал, дуу авиа, авто техникийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас гадна гарын мөр, галт зэвсгийн хонгио, хошуу, гутлын мөр, үнэт цаас, мөнгөн тэмдэгтийн сан бүрдүүлж адилтгалын шинжилгээнд ашигладаг. Мөн тус газрын шинжээчид онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх үүрэгтэй.
2. *Шүүх эмнэлгийн шинжилгээний газар.* Шүүх эмнэлгийн шинжилгээний газар нь хүний биед шинжилгээ хийх (гэмтлийн зэрэг тогтоох, нас, хүйс, бэлгийн бойжилт, эрүүл мэндийн байдлыг тодорхойлох), цогцост шинжилгээ хийх, цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэхээс гадна эд эсийн болон хэргийн материалд шинжилгээ хийдэг. Хүний үхлийн шалтгааныг нарийн тогтоохын тулд цогцсоос авсан эдийн дээж болон хэргийн газраас цуглуулсан эрхтний дээжид эмгэг өөрчлөлт, өвчин байгаа эсэхийг тодорхойлох шинжилгээг эд эсийн шинжилгээний лабораторид мөн хийдэг.
3. *Тусгай шинжилгээний газар.* Тус газар нь хими, физик, биологи, ДНХ, бактериологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас гадна онц ноцтой, хүнд гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээ оролцуулж ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх үүрэгтэй. Мөн ДНХ-ийн мэдээллийн төрөлжсөн сан бүрдүүлж ажилладаг. Хими, Физик, Биологи, ДНХ-ийн шинжилгээний лабораториуд нь Стандартчилал, хэмжил зүйн газраар магадлан итгэмжлэгдсэн.
4. *Эдийн засгийн шинжилгээний хэлтэс.* Тус хэлтэс нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд холбогдох өмчийн болон татварын хэрэг, маргааныг шийдвэрлэх зорилгоор эдийн засгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг.
5. *Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс.* Шинжилгээ хийлгэх шийдвэр, шинжилгээний объектыг эрх бүхий этгээдээс хүлээн авах, бүртгэх, шинжилгээг зохих шинжээчид даалгах, шинжилгээний явцад дээж, загвар авах болон дүгнэлт, объектыг шинжээчээс хүлээн авч эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх, хүргүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Шинжилгээний объектын бүрэн бүтэн байдал, шинжилгээ хийх хугацаанд хяналт тавьж, шаардлагатай нэмэлт материал ирүүлэх, шинжилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг эрх бүхий этгээдэд уламжлан шийдвэрлүүлж, шинжилгээтэй холбоотой аливаа

асуудлаар хууль, хяналтын байгууллагуудад шаардлагатай мэдээлэл, лавлагаа өгч ажилладаг. Түүнчлэн байгууллагын архив, шүүх эмнэлгийн дүн бүртгэл, статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцсын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

6. *Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар.* Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээ оролцуулж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, криминалистикийн зарим төрлийн шинжилгээ хийж дүгнэлт, магадалгаа гаргах, гарын хээний болон хонгио, хошууны нэгдсэн санг баяжуулах, ашиглах үндсэн чиг үүрэгтэй.
7. *Аймгийн шүүхийн шинжилгээний албад.* Монгол Улсын 21 аймгийн шүүхийн шинжилгээний албад нь тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээ оролцуулж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр криминалистик, шүүх эмнэлэг, хими, биологийн шинжилгээ хийж дүгнэлт, магадалгаа гаргах, гарын хээний болон хонгио, хошууны нэгдсэн санг баяжуулах, ашиглах үндсэн чиг үүрэгтэй.

Гадаад улсын тодруулбал, ОХУ, БНХАУ, АНУ, Нидерланд, Шинэ Зеланд, Ирланд, Хонконг, Словени, Унгар, Казахстан, Гүрж, Солонгос, Япон зэрэг 41 улсын цагдаагийн байгууллагууд хэргийн газрын үзлэг хийх, ул мөр илрүүлэх бүтэцтэй<sup>40</sup> ба шүүхийн шинжилгээний байгууллага нь зөвхөн шинжилгээ хийдэг байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн дараах төрлийн шинжилгээ хийж байна. Үүнд:

- Хувцас, даавуун эдлэлд үүссэн гэмтэл, цоож болон багаж хэрэгслийн мөр, гутлын болон тээврийн хэрэгслийн мөр, хэсгээс бүхэл тогтоох зэрэг Мөр судлалын шинжилгээ;
- Гарын үсэг, гар бичмэл, үнэт цаас, мөнгөн тэмдэгт, паспорт зэрэг нууцлалтай баримтыг хуурамчаар үйлдсэн, засварласан эсэхийг тогтоох, тамга, тэмдэгт хийх шинжилгээ, бичиглэл болон тамга, тэмдгийн дараалал тогтоох зэрэг Бичиг баримтын шинжилгээ;
- Галт зэвсгийн зориулалт, ажиллагаа, сумны марк, ажиллагаа, хонгионы


<sup>40</sup> Т.Очирбат, “Монгол Улсын шүүх шинжилгээний байгууллага ба гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагууд” сэдэвт судалгааны дэд тайлан, УБ., 2014.

- харьцуулалт, хошууны харьцуулалт хийх зэрэг Галт зэвсгийн шинжилгээ;
- Гарын мөрийг санд харьцуулах шинжилгээ, гарын хээний дардсыг санд харьцуулах шинжилгээ, объектоос мөр илрүүлж, харьцуулах зэрэг Гарын хээний шинжилгээ;
  - Авто техникийн эд ангиудын гэмтлийн шалтгаан тогтоох, авто техникийн эд ангиудыг харьцуулах зэрэг Авто техникийн шинжилгээ;
  - Дүрс бичлэг, дуу бичлэг болон дүр зургийн шинжилгээнүүд зэрэг Дүр зураг, дүрс, дуу бичлэгийн шинжилгээ;
  - Шингэн цусны бүлэг тогтоох, хатсан цус, эд эрхтэн, үс, шүлсний бүлэг тогтоох, эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээ, эр бэлгийн эс илэрсэн тохиолдолд түүний бүлгийн харьяалал тогтоох зэрэг Биологийн шинжилгээ;
  - Эцэг тогтоох шинжилгээ, эд мөрийн баримт, эд эрхтэн, булцуутай үсэнд хийх шинжилгээ, муудсан, шатсан эд эрхтэн, ясанд хийх ДНХ шинжилгээ зэрэг ДНХ-ийн шинжилгээ;
  - БЗХӨ-ийг илрүүлэх (граммын арга+тестээр), БЗХӨ-ийг молекул биологийн аргаар илрүүлэх шинжилгээ, өсгөвөрлөх аргаар халдварын үүсгэгч тодорхойлох шинжилгээ зэрэг Бактериологийн шинжилгээ;
  - Буудлагын мөр, зай, буудлагын тоо болон чиглэл тогтоох, алт, мөнгөний сорьц тодорхойлох, бодисын найрлага тогтоох зэрэг Физикийн шинжилгээ;
  - Биологийн дээжид спирт тодорхойлох шинжилгээ, спирт агуулсан согтууруулах ундааны шинжилгээ, үл мэдэгдэх бодисын найрлага тогтоох, эд эрхтэнд эмийн бодис тодорхойлох, эд, эрхтэнд метилийн спирт, хлорт нэгдэл, этиленгликоль, цууны хүчил тодорхойлох, цус, шээсэнд мансууруулах бодис тодорхойлох зэрэг Химийн шинжилгээнүүд;
  - Хүний биед хийх шинжилгээ, хүний биед нэмэлт шинжилгээ хийхээр бол цогцос шинжлэх, хэргийн материалаар бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх, шарил шинжлэх гэх мэт Шүүх эмнэлгийн шинжилгээ зэргийг тогтоосон хугацаанд (Хавсралт 3) хийж гүйцэтгэдэг.

Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирлын 2013 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн а/751 тоот тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд одоо ажиллаж буй - 493, ШШҮХ-д - 207, аймгийн ШША-нд - 198, Нийслэлийн ШША-нд - 88, үүнээс криминалистикийн шинжээч 177, шинжээч эмч 77, лабораторийн шинжээч 16, эдийн засгийн шинжээч 7, бусад 216, доктор 4, магистр 401, бакалавр 307, бусад 141 алба хаагч ажиллаж байна. ШШҮХ-д хийх шинжилгээний цар хүрээ, ажлын ачааллыг улс, нийслэлийн хүн амын

өсөлттэй уялдуулахын тулд орон тоог 450 алба хаагчаар нэмэх шаардлагатай<sup>41</sup> байгаа ажээ.

ГРАФИК 9. ШШҮХ-гийн АЛБА ХААГЧДЫН МЭРГЭШЛИЙН СУДАЛГАА



Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь дараах чиглэлийн шинжилгээний лабораториудтай. Үүнд:

1. Криминалистикийн чиглэлээр:
  - Гарын мөрийн шинжилгээний лаборатори;
  - Мөр судлалын шинжилгээний лаборатори;
  - Бичиг баримтын шинжилгээний лаборатори;
  - Галт зэвсгийн шинжилгээний лаборатори;
  - Авто техникийн шинжилгээний лаборатори;
  - Гэрэл зураг, дүр зураг-дүрс бичлэгийн шинжилгээний лаборатори.
2. Тусгай шинжилгээний чиглэлээр:
  - Химийн шинжилгээний лаборатори;
  - Биологийн шинжилгээний лаборатори;
  - Физикийн шинжилгээний лаборатори,
  - Бактериологийн шинжилгээний лаборатори;
  - ДНХ-ийн шинжилгээний лаборатори.

<sup>41</sup> Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал 2019 оны 10 дугаар сард “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлага, <https://unuudur.mn>




Шүүх эмнэлгийн чиглэлээр:

- Гистологийн шинжилгээний лаборатори зэрэг нийт 12 лабораторитой эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийн ажиллаж байгаа бөгөөд дээрх шинжилгээний лабораториудад хэрэглэгддэг гол багаж, техник хэрэгслийг доор танилцууллаа.

*Гарын мөрийн шинжилгээний лаборатори.* Тус лабораторид 1995 онд “Папилон-5” системийг суурилуулж, хэргийн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөрүүдийг гарын дардаснуудтай автомат харьцуулалт хийж эхэлсэн ба 1999 онд Засгийн газраас “Гарын хээний нэгдсэн сан” байгуулах шийдвэр гарч, үүний дагуу ОХУ-ын мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулан “Папилон-7 АДИС” шинэ системийг суурилуулж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар гарын мөрийн шинжилгээний лабораторид 2008 онд “Папилон-7.7.4” системийг суурилуулсан бөгөөд аймаг, нийслэлийн шинжилгээний байгууллагад 2012 онд бүрэн суурилуулж, нэгдсэн систем байдлаар ашиглаж байна.

ГРАФИК 10. ГАРЫН МӨРИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА



*Мөр судлалын шинжилгээний лаборатори.* Тус лаборатори нь Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын даргын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 тоот тушаалаар Криминалистикийн шинжилгээний төвийн бүтцийг лабораторийн системд шилжүүлсэнтэй холбогдуулан бие даан ажиллах болсон. Мөр судлалын шинжилгээнд дараах техник хэрэгслийг ашиглаж байна.

**ХҮСНЭГТ 9. МӨР СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА**

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	AmScore	Хятад	2010, 2013	2010, 2013	Өсгөгч
2	XTL	Хятад	2006	2006	Өсгөгч
3	XZB	Хятад	2007	2007	Дижитал камертай өсгөгч

**ГРАФИК 11. МӨР СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА**




*Бичиг баримтын шинжилгээний лаборатори.* Тус лаборатори нь ЦЕГ-ын даргын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 тоот тушаалаар Криминалистикийн шинжилгээний төвийн бүтцийг лабораторийн системд шилжүүлсэнтэй холбогдон байгуулагдсан. Бичиг баримт болон гар бичмэл, тамга тэмдэгт дараах техник хэрэгслийг ашиглан шинжилгээ хийж байна.

**ХҮСНЭГТ 10. БИЧИГ БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА**

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	AmScore суурин болон зөөврийн	Хятад	2010, 2013	2010, 2013	Өсгөгч
2	“Porjectina Docucenter Expert”-PIA6000	Хятад	2008	2008	Тусгай төхөөрөмж
3	Nikon SM2800	Хятад	2007	2007	Өсгөгч

ГРАФИК 12. БИЧИГ БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА



Галт зэвсгийн шинжилгээний лаборатори. Тус лаборатори нь мөн 1998 оноос эхлэн лабораторийн системд орсон бөгөөд 2001 онд УИХ-аас баталсан Галт зэвсгийн тухай хуульд заасны дагуу Улсын галт зэвсгийн хонгио, хошууны нэгдсэн сан байгуулж, автомат харьцуулалтын “ССS-1.0” систем суурилуулан галт зэвсгийн бүртгэл, хонгионы мөрийг сан хэлбэрээр бүртгэж, бүх төрлийн галт зэвсэг, сум хэрэгсэл, буудлагын мөр, тэсэрч дэлбэрэх бодисын шинжилгээ хийж байна. Дээрх шинжилгээнүүдийг дараах техник хэрэгсэл ашиглан хийдэг.

ХҮСНЭГТ 11. ГАЛТ ЗЭВСГИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Арсенал	ОХУ	2008	2008	Автомат систем
2	Motic SMZ-140	Хятад	2006	2007	Өсгөгч

ГРАФИК 13. ГАЛТ ЗЭВСГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА




Авто техникийн шинжилгээний лаборатори. Монгол Улсын Их хурлын 2008 оны 35-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Тээврийн хэргийн шалтгаан”-ы төрөлжсөн лаборатори байгуулах арга хэмжээ тусгагдсаны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2013 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн а/214 тоот тушаалаар байгуулагдсан. Тус лаборатори нь зам тээврийн ослын хэргийн газрын нөхцөл байдлын шинжилгээ, авто техникийн эвдрэл гэмтлийг тогтоох шинжилгээ, авто техникийн мөр судлалын шинжилгээг тус тус хийдэг бөгөөд дараах техник хэрэгслийг ашиглаж байна.

**ХҮСНЭГТ 12. АВТО ТЕХНИКИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА**

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Launch	Хятад	2013	2013	Тэнхлэг тохиргооны багаж
2	Launch	Хятад	2013	2013	Дугуй задалж угсрах төхөөрөмж
3	Fox well GT30 mini	Хятад	2015	2015	Цахилгааны гэмтэл оношлох багаж
4	Bow monk series-2	Англи	2014	2014	Тормосын идэвхжилт хазайлт хэмжигч

**ГРАФИК 14. АВТО ТЕХНИКИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА**



Гэрэл зураг, дүр зураг-дүрс бичлэгийн шинжилгээний лаборатори. Дүр зургийн лаборатори нь мөн 1998 онд байгуулагдсан бөгөөд гэрэл зураг, гавлын ясаар хүнийг адилтгахаас гадна хохирогч, гэрчийн тодорхойлсон, мэдүүлсний дагуу сэжигтний ам зураг гаргах компьютерын *Mon face* харьцуулах систем суурилуулан ажиллаж байсан. Гэрэл зургийн лаборатори нь Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА-гийн тусламжаар байгуулагдсан бөгөөд шинжилгээний болон хэргийн газрын үзлэгийн гэрэл зургийн ажлыг гүйцэтгэдэг байна. Өнөөдрийн байдлаар тус лабораторид 2016 онд Япон Улсад үйлдвэрлэсэн, гэрэл зургийг чанарын өндөр түвшинд боловсруулдаг *Fujifilm Frontier LP7700* маркийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн дүр зураг, дүрс бичлэг, дуу авианы шинжилгээнд дуу авиа, дүрс бичлэг, компьютер техникийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, ОХУ, АНУ болон Европын зарим улс орны программ хангамж хэрэглэж байна.

ГРАФИК 15. ГЭРЭЛ ЗУРАГ, ДҮР ЗУРАГ-ДҮРС БИЧЛЭГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА




ГРАФИК 16. ШШҮХ-гийн КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИЙН ОРОЛЦСОН АЖИЛЛАГААНЫ СУДАЛГАА




ГРАФИК 17. ШШҮХ-гийн КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИЙН ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГЭЭР ИЛРҮҮЛСЭН МӨРНИЙ СУДАЛГАА




ГРАФИК 18. ШШҮХ-гийн НОТЛОСОН ХЭРГИЙН СУДАЛГАА




ГРАФИК 19. ШШҮХ-гийн БОЛОВСРУУЛСАН ГЭРЭЛ ЗУРГИЙН СУДАЛГАА






ГРАФИК 20. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА



ХҮСНЭГТ 13. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

№	Хийгдсэн шинжилгээ	2018	2019	2020 оны 6 дугаар сар
1	Гарын мөр	9564	7506	3633
2	Мөр судлал	1557	1748	844
3	Бичиг баримт	1013	1245	521
4	Галт зэвсэг	606	947	623
5	Тэсрэх төхөөрөмж	2	4	11
6	Дүр зураг	72	53	13
7	Дүрс бичлэг	251	244	135
8	Авто техник	166	174	90
9	Компьютер судлал	112	92	79
10	Дуу авиа	28	28	4
11	Материал судлал	33	65	3
12	Бусад шинжилгээ	17	15	9

ГРАФИК 21. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ СУДАЛГАА



Тусгай шинжилгээний газар. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тусгай шинжилгээний салбар нь анх 1974-1976 онд БНАГУ (хуучнаар)-ын техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хими, физик, биологийн гэсэн гурван лабораторитой байгуулагдсан. Тус газар нь хими, физик, биологи, ДНХ, бактериологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас гадна онц хүнд хэргийн газрын үзлэгт мэргэжилтээ оролцуулж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх үүрэгтэй. Мөн ДНХ-ийн мэдээллийн төрөлжсөн сан бүрдүүлэн ажилладаг.




Химийн шинжилгээний лаборатори. Тус лаборатори нь 1974 онд БНАГУ, БНСЧСУ (хуучнаар)-ын аппарат, техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар байгуулагдсан. Уг лабораторид Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг ЖАЙКА-гийн техникийн буцалтгүй тусламжаар хар тамхи, мансууруулах бодис шинжлэх “Хийн хроматограф”-ын аппаратыг 2004 оны 9 дүгээр сард суурилуулан ажиллагаанд оруулсан. 2018 онд тус лабораторид хүний биеийн био материалд буюу цус, шээс, үс, хумсанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох гурван төрлийн 6530 QTOF шингэний хроматограф-масс спектрометр, 1290 HPLC өндөр мэдрэмжит шингэний хроматограф, 5977 загварын хийн хроматограф, масс спектрометрийн аппарат суурилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

#### ХҮСНЭГТ 14. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	HBS-Q-TOF-LC/MS-650	АНУ	2017	2018	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох
2	7820AGC-5977B MSD	АНУ	2017	2018	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох
3	ELISA RT-2100C	Хятад	2019	2019	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох
4	UNICO7200	Хятад	2008	2008	Спиртийн зүйл тодорхойлох

#### ГРАФИК 22. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА




Биологийн шинжилгээний лаборатори. Тус лаборатори нь 1976 онд ЦЕГ-ын Шинжилгээний хүрээлэнд БНАГУ-ын тоног төхөөрөмж, техникийн тусламжтайгаар байгуулагдсан бөгөөд дараах техник хэрэгслийг ашиглан биологийн шинжилгээ хийж байна.

**ХҮСНЭГТ 15. БИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА**

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Nikon-ECLIPSE E200	Хятад	2018	2018	Өсгөгч
2	Micros MC-50	Австри	-	-	Өсгөгч
3	Biobase	Хятад	-	-	Дээж бэлтгэгч сэгсрэгч

**ГРАФИК 23. БИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА**




Физикийн шинжилгээний лаборатори. Тус лаборатори нь 1974 онд УЦСЕГ-ын Шинжлэх ухаан, техникийн хэлтэст БНАГУ-ын тоног төхөөрөмж, техникийн тусламжтайгаар байгуулагдсан бөгөөд дараах техник хэрэгсэл ашиглан физикийн шинжилгээ хийж байна.

**ХҮСНЭГТ 16. ФИЗИКИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА**

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Elva-X	Украин	2008	2008	XRF рентген багаж

ГРАФИК 24. ФИЗИКИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА




*Бактериологийн шинжилгээний лаборатори.* Тусгай шинжилгээний лабораторид хандах бактериологийн шинжилгээний тоо, объектын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаагаас хамаарч тус лаборатори нь Биологийн шинжилгээний лабораториос тусгаарлан байгуулагдаж бие даан ажиллаж байна. Уг лабораторид хохирогч болон сэжигтнээс цус, шээс, мазокын шинжилгээний дээж авч сүүлийн үеийн мэдрэг оношлуур тест, микроскоп, PCR-ын аргуудыг ашиглан бэлгийн замын халдварт өвчин үүсгэгчийг илрүүлэх бактериологийн шинжилгээ хийдэг.

ХҮСНЭГТ 17. БАКТЕРИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Elisa reader ADX-110	АНУ	2018	2018	Тусгай төхөөрөмж
2	CYAN CL002	Бельги	2019	2019	Тусгай төхөөрөмж
3	Thermostatic DH4000AB	Хятад	2007	2007	Тусгай төхөөрөмж
4	Thermostatic DH5000-II	Хятад	2011	2014	Тусгай төхөөрөмж
5	CYAN CL007N	Бельги	2019	2019	Тусгай төхөөрөмж

ГРАФИК 25. БАКТЕРИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА




ДНХ-гийн шинжилгээний лаборатори. Тус лаборатори нь 2001 онд БНСУ-ын Засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны “КОЙКА” байгууллагын тусламжаар ДНХ-ийн шинжилгээний тоног төхөөрөмжийг биологийн лабораторид суурилуулснаар байгуулагдсан. 2008 онд ABI PRISMR310, 2012 онд ЦЕГ-ын хөрөнгө оруулалтаар ABI PRISMR3130 генетик анализатор тус тус суурилуулж, Хууль зүйн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Б/01 тоот тушаалаар ДНХ-ийн шинжилгээний лаборатори бие даасан бүтэцтэйгээр байгуулагдан ажиллаж байна. ДНХ-ийн шинжилгээний лабораторид дараах гол техник хэрэгслийг ашигладаг.

ХҮСНЭГТ 18. ДНХ-гийн ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

№	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Himedia Prima-96	Энэтхэг	2019	2019	PCR машин
2	PCR system 9700	АНУ	2012	2012	Тусгай төхөөрөмж
3	Genetic Analyzer 3130	АНУ	2012	2012	Тусгай төхөөрөмж
4	Thermostat JISICO J-100S	Солонгос	2001	2001	Тусгай төхөөрөмж
5	HANIL HM-150-IV	Солонгос	2001	2001	Центрфуг

ГРАФИК 26. ДНХ-гийн ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГАА



### 2.3.3. Шүүхийн шинжилгээ хийж буй бусад байгууллагад хийх шинжилгээ

ЭХХШТХ-ийн 27.4 дүгээр зүйл болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх эрх зүйн зохицуулалттай бөгөөд одоогоор үүнээс өөр тусгайлсан эрх зүйн зохицуулалт хуульчлагдаагүй байна. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, цагдаагийн байгууллага дахь шинжилгээ хийх нэгж ээдрээ төвөгтэй хэрэг дээр дангаараа ажиллах боломж хязгаарлагдмал юм. Иймд бусад төрийн болон хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагад ханддаг. Эрүүгийн хэрэгт шүүхийн шинжилгээ дараах байгууллагуудад хийгдэж байна. Үүнд:

*Шинжлэх ухааны академи.* Тус академи нь 1921 онд “Судар бичгийн хүрээлэн” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд салбарын судалгаа шинжилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, салбарын шинжлэх ухааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ-судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх, шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс орны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт хийж, үндэслэл боловсруулах чиглэлээр үндсэн үйл ажиллагаа нь явагддаг. Өнөөдрийн байдлаар ШУА-ийн шууд харьяалалд эрдэм шинжилгээний 10 хүрээлэн, салбарын төрөлжсөн 2 академи байгаа ба холбогдох бүхий л төрлийн шинжилгээг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- *Хэл зохиолын хүрээлэн* нь хэл шинжлэлийн шинжилгээ буюу монгол хэлний бүтэц, тогтолцоо, хэл зүйн утга, нэр томъёоны шинжилгээ;

- *Геоэкологийн хүрээлэн* нь био экологи, хөрс, ус, цэвдэг судлалын шинжилгээ;
- *Математик, тоон технологийн хүрээлэн* нь математик, мэдээллийн технологи, симуляц тооцооллын салбарын шинжилгээ;
- *Хими, химийн технологийн хүрээлэн* нь Байгалийн нэгдлийн химийн лаборатори, Эрдсийн технологийн, Экологийн химийн, Органик бус химийн, Органик химийн, Нүүрсний хими технологийн, Материал судлал, технологийн болон Хүнсний химийн лабораториуддаа холбогдох шинжилгээ;
- *Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн* нь монгол орны ховор болон нэн ховор ургамал, ургамлын хими, биохимийн судалгаа, шинжилгээ;
- *Археологийн хүрээлэн* нь археологи, соёлын өвийн дурсгал, эд өлгийн шинжилгээ;
- *Биологийн хүрээлэн* нь Генетикийн, Молекул биологийн, Микробиологийн, Микробын нийлэгжилтийн, Ургамлын биотехнологийн, Хөхтний экологийн, Шувуу, шавж судлалын болон Гидробиологи, загас судлалын лабораториудтай;
- *Газар зүйн хүрээлэн* нь Хөрсний хими-агрохими, ус-физик шинжийн 40-өөд нэр төрлийн задлан шинжилгээг тус тус хийдэг байна.

*Геологийн төв лаборатори.* Тус лаборатори 1957 онд байгуулагдсан бөгөөд эрдсийн түүхий эд, байгаль орчны шинжилгээ, ур чадварын сорилт зохион байгуулдаг, аттестатчилсан, стандартчилсан загвар үйлдвэрлэлийн чиглэлээр үндэсний болон олон улсын хэмжээнд “Платинум” түвшинд итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллага юм. Тус лабораторид эрдсийн түүхий эдийн тоон ба хагас тоон шинжилгээ, бодисын найрлагын судалгаа, шинжилгээ, нүүрсний болон байгаль орчны судалгаа, шинжилгээ (цианид, мөнгөн ус, хүнд металл), лаборатори хоорондын гадаад хяналт, экспертиз шинжилгээг тус тус хийж гүйцэтгэдэг байна.

*Гамшиг судлалын хүрээлэн.* Гамшгаас хамгаалах чиглэлээр туршилт, шинжилгээ явуулах чиг үүрэгтэйгээр анх 1964 онд байгуулагдсан ба өнөөдрийн байдлаар дараах төрлийн лабораторийн туршилт, шинжилгээг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Гал түймрийн хэрэг, зөрчлийн үүсэл шалтгааныг тодорхойлох лабораторийн туршилт, шинжилгээ;

- Галын аюултай бодис, материалын ашиглалт, хадгалалт, барилга байгууламжийн хийц, бүтцийн галын аюулын үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн туршилт, шинжилгээ;
- Цацрагийн бохирдолт, тун, тунгийн чадлыг тодорхойлох, лабораторийн туршилт, шинжилгээ;
- Химийн хортой бодисын шинж чанар, үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн туршилт, шинжилгээ.

*Зоонозын өвчин судлалын үндэсний төв.* Тус төв нь 1928 онд “Тарваган тахал өвчнийг эсэргүүцэх лаборатори” нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд өнөөдөр Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон үйл ажиллагаагаа явуулж байна. Тус төвийн лавлагаа лаборатори дараах төрлийн шинжилгээг хийдэг. Үүнд:

- Зоонозын халдварт өвчний<sup>42</sup> хүний өвчлөлийн лабораторийн оношилгоо, шинжилгээ;
- Байгалийн голомт хяналтын шинжилгээ;
- Тархвар судлал хяналтын лабораторийн шинжилгээ.

*Гаалийн төв лаборатори.* Тус лаборатори нь “Гаалийн тухай хууль”-д заасны дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж илрүүлэх зорилго бүхий гаалийн хяналт, шалгалтын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гаалийн байгууллагын нэг юм. Тус лаборатори нь дараах нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийж байна. Үүнд:

- Хар тамхи, мансууруулах бодис;
- Төрөл бүрийн химийн бодис;
- Согтууруулах ундаа;
- Тамхи, тамхины төрлийн бүтээгдэхүүн;

---

<sup>42</sup> Шууд ба шууд бус хавьтлаар хүн ба амьтнаас хүний бие махбодод орж эрүүл мэндэд хор хөнөөл учруулан, улмаар үхэлд хүргэх аюултай олон төрлийн вирус, нянгийн гаралтай халдварт өвчнийг хэлнэ. Зоонозын 300 гаруй өвчин байдгаас 160 орчим нь хүнд халдварладаг байна.

- Нефтийн бүтээгдэхүүн;
- Ноос, ноолуур, малын гаралтай түүхий эд;
- Хайлууур жонш, эрдэс түүхий эд, хүдэр баяжмал;
- Нэхмэл болон сүлжмэл даавуу, утас ээрмэл.

*Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори.* Энэхүү лавлагаа лабораторийг 1972 онд байгуулан хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээг явуулж байна. Тус лабораторид дараах шинжилгээг хийдэг. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь ажлын байрны физик, хими, биологийн болон мэдрэл сэтгэхүй-физиологийн хүчин зүйлийн хэмжилт, шинжилгээ;
- Цацрагийн хяналтын лаборатори нь хүн ам болон цацрагтай ажиллагсдад шууд болон шууд бусаар нөлөөлж буй ионжуулагч цацрагийн хэм хэмжээний хэмжилт, шинжилгээ;
- Таримал ургамлын үр, хорио цээрийн лаборатори нь экспорт, импортын болон эх орны үйлдвэрийн бүх төрлийн ургамал, ургамлын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн, таримал ургамлын үрд ургамлын эрүүл ахуй, хорио цээр, тарих үрийн тариалалтын ба технологийн чанарын шинжилгээ;
- Нян судлалын лаборатори нь өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн<sup>43</sup>, түүхий эд болон ахуйн хэрэглээ, гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалтын явцад бий болсон эмгэг төрөгч бактериудыг хэмжих шинжилгээ;
- Хими хор судлалын лаборатори нь экспорт, импортын бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, цэвэр болон бохир ус, хөрс, архи, спирт, согтууруулах ундаа, гоо сайхан, ахуйн химийн бүтээгдэхүүн, сав, баглаа боодол, хүүхдийн тоглоом гэх мэт 73 нэр төрлийн бүтээгдэхүүнд хими, хор судлал, хүнд металлын шинжилгээг 1300 орчим үзүүлэлтээр;
- Эмийн хяналтын лаборатори нь эмийн хими, микробиологи, эм зүйн шинжилгээг тус тус хийдэг.

---

<sup>43</sup> Хүнсний тухай хуулийн 8.4 дүгээр зүйлд зааснаар Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жагсаалтад заасан хүнсийг хэлнэ.



*Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лаборатори.* Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, хоолны газрууд, эмнэлэг болон урьдчилан сэргийлэх байгууллагууд, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагууд, усан хангамж, хөрс, бохир усны объектууд, түүнчлэн үйлдвэр, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн эрүүл ахуйд хяналт тавих үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Үйлдвэрийн бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн, гоо сайхны болон ахуйн химийн бүтээгдэхүүн, эмнэлгийн дотоод халдварын шинжилгээ;
- Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн ундны болон ахуйн цэвэр ус, төв цэвэрлэх байгууламжийн бохир ус, хот орчмын булаг шанд, гүний худгийн ус, хөрс, ажлын байрны агаар зэрэгт нян судлал, хими, хор судлалын шинжилгээг тус тус хийдэг.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар нь явуулын лабораторитой ба тус лаборатори нь зургаан нэр төрлийн бүтээгдэхүүнд 28 төрлийн үзүүлэлтээр тухайн эгзэгтэй цэгт шинжилгээг 5-20 минутад хийж гүйцэтгэдэг. Явуулын лабораториор ажлын байрны агаарт химийн бодисууд, ундны болон ахуйн ус, савласан цэвэр ус, бохир усанд химийн шинжилгээ, хүнсний бүтээгдэхүүнд тэр дундаа хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, ундаа жүүсэнд газар дээр нь шинжилгээ хийж гүйцэтгэдэг байна.

*Уул уурхай, газрын тосны төв лаборатори.* Энэ лаборатори 2005 онд итгэмжлэгдсэн Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол Улсад мөрдөж буй стандартын дагуу чанарын өндөр түвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Тус лаборатори нь газрын тосны бүтээгдэхүүн, тос тосолгооны материалд иж бүрэн шинжилгээ хийх хүчин чадалтай.

*Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн.* Тус хүрээлэн 1961 онд “Хөдөө аж ахуйн хүрээлэн” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний төрөлжсөн байгууллага болж, эрдэм судлалын төвийн үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээлэн нь мал аж ахуй, мал эмнэлэг, ургамал, газар тариалан гэсэн гурван салбар, станц, тэдгээрт харьяалагдах 18 лабораторитой, мал аж ахуй, бэлчээр, тэжээлийн шинжилгээ хийдэг.

*Үндэсний аудитын газар.* Тус байгууллага нь 1922 онд байгуулагдсанаас хойш төрийн хяналт шалгалтын ажил явуулж байгаа бөгөөд хуульд заасан эрхийн дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх эрхтэй. Тус газар санхүүгийн тайлангийн аудит, нягтлах шинжилгээ хийдэг.

*Мэдээлэл шуурхай удирдлагын төв.* Тус төв нь 2010 онд байгуулагдсан ба иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, гамшиг осол, гал түймэр, эмнэлгийн яаралтай тусламжийн талаар мэдээлэл хүлээн авах, цагдаа, онцгой байдал, эмнэлгийн түргэн тусламжийн хөдөлгөөнт хэсэг, бүлгүүдийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулах, төрийн зохих байгууллагуудыг шуурхай мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус төвөөс галын шалтгаан, нөхцөлийг тогтоох шинжилгээ хийдэг.

*Дамно ХХК.* Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа есөн дүүрэг дэх Цагдаагийн газар, хэлтсүүдийн шалгаж байгаа эд хөрөнгө тогтоох үнэлгээг тендэрт шалгарсан хөрөнгийн үнэлгээний “ДАМНО” ХХК-аар хийлгэдэг. Уг компани нь 2006 онд байгуулагдан дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн үнэлгээ;
- Хохирлын үнэлгээ;
- Бизнес үнэлгээ хийж гүйцэтгэдэг.

*Ханлаб ХХК.* Тус компани нь эрдэс баялаг, байгаль орчны химийн шинжилгээ хийх зорилгоор 2012 онд байгуулагдсан үндэсний мэргэжлийн компани юм. Уг компанийн лабораторид дараах шинжилгээг хийдэг. Үүнд:

- Эрдсийн шинжилгээ;
- Байгаль орчны химийн шинжилгээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад байгууллагаар шинжилгээ хийлгэх талаар хуулийн болон хууль сахиулах байгууллагын (гэмт хэрэг мөрдөн шалгах үүрэг бүхий) 114 албан тушаалтныг хамруулан судалгаа явуулахад 88.2 хувь нь “Шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилж дүгнэлт гаргуулахад олон янзын бэрхшээл тулгардаг” гэж хариулсан юм. Тэдгээрийг багцалбал, 58.8 хувь нь шинжээчээр томилж ажиллуулах шаардлагатай мэргэжилтнийг олох, 70.5 хувь нь дүгнэлт гаргасан шинжээчийн зардлыг төлөх асуудал хүндрэлтэй байдаг гэж үзжээ.

Мөн хугацаа их шаарддаг, хүнд сурталтай, төлбөр шилжүүлсний дараа дүгнэлт гаргаж өгнө гэсэн шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулдаг, итгэхэд бэрх, бусдын нөлөөнд автах магадлалтай, хэргийн материал өгч явуулж болдоггүй, хэд хэдэн шинжээч томилогдон тохиолдолд нэг дор цуглуулахад хүнд гэх мэт асуудлыг онцлон дурдсан байна.

Харин шинжилгээний байгууллагаас гадуур ямар чиглэлийн шинжилгээ хийлгэх шаардлага зонхилж байгаа талаарх асуултад судалгаанд хамрагдагсдын 80 хувь нь инженерийн чиглэлийн; 50.5 хувь нь эдийн засгийн чиглэлийн; 22 хувь нь шүүх эмнэлгийн болон сэтгэцийн; 17.6 хувь нь биологийн; 15.2 хувь нь хөрс судлалын; 5.8 хувь нь криминалистикийн; 5.8 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлийн шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж хариулжээ.

Судалгааны дүнд бас нэг сонирхолтой тоо баримт харагдаж байгаа нь шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээчийн дүгнэлт нотлох баримтын хэмжээнд хэр зэрэг үнэлэгддэг тухай асуудал юм. Тэдний 12.9 хувь нь нотлох баримтаар үнэлэх боломжгүй байдаг гэсэн бол 55.2 хувь нь зарим үед нотлох баримтын хэмжээнд үнэлэгддэг гэсэн байна. Ямар учраас нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй байгаа талаар хариулахдаа судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь буюу 29.3 хувь нь дүгнэлт ойлгомжгүй байдаг; 27.5 хувь нь асуултад бүрэн хариулт өгдөггүй; 27.5 хувь нь шинжээчийн дүгнэлт бичиг тогтсон стандарт байдаггүй; 15.5 хувь нь шинжилгээ хийсэн арга, аргачлал тодорхойгүй гэсэн бол цөөнгүй хувь нь хөндлөнгийн нөлөөнд автах магадлал өндөр<sup>44</sup> гэж хариулжээ.

Монгол Улсад шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэх тухай хуульчлан заасан боловч түүнийг хэрхэн гүйцэтгэх тухай нарийн журам байдаггүй. Харин “АНУ-д хувийн шинжээчийн үйл ажиллагааг процессын хуулиар зөвшөөрсөн байдаг нь шинжилгээ хийх үйл ажиллагааны гол ялгаатай тал юм. Төрийн шинжилгээний байгууллагын шинжээч болон хувийн шинжээчид нь Шинжээчдийн хорооноос олгодог адил тэгш, тусгай зөвшөөрөл авсан байх журамтай байдаг. Тэдний гаргасан дүгнэлтийг шүүх адил тэгш байдлаар авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгдөг”<sup>45</sup> гэж доктор Г.Ганзориг бичжээ.

---

<sup>44</sup> Т.Очирбат, “Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам”, 2019, legaldata.mn

<sup>45</sup> Г.Ганзориг, “Хүний эрх, эрх чөлөө-шүүхийн шинжилгээ”, Өгүүлэл, УБ., 2015.

Судалгааны үр дүнд шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилох явдал нь шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд тулгамдсан асуудал болж байна. Энэ нь эрүүгийн хэрэгт шинжээчээр оролцдог болон оролцох боломжтой хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл албан ёсоор прокурор<sup>46</sup>, цагдаа<sup>47</sup>, АТГ<sup>48</sup>, Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн<sup>49</sup> цахим хуудсанд байршаагүй байгаатай холбоотой. Үүнийг шийдвэрлэхийн тулд шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй, шинжилгээ хийх боломжтой мэргэжилтнүүдийн бүртгэлийн тогтолцоо бий болгож шүүхийн шинжилгээний төв байгууллагад хариуцуулах боломжтой. Орон тооны бус (гэрээт) шинжээчийн улсын бүртгэлийг бий болгож ашиглах нь зүйтэй. Үүнд, иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлт гаргасан 76 байгууллага, хуулийн этгээдийн нэрс болон бусад шаардлагатай мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөл цахим хуудсандаа байршуулсан<sup>50</sup> туршлагыг нэвтрүүлэх боломжтой байж болох юм. Мөн шүүхийн шинжилгээ хийх боломжтой мэргэжилтнүүдийг судлах, шалгаруулах, зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийн хугацааг сунгах, цуцлах, аттестатчилал явуулах эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай талаар салбарын судлаачид дурдсан байна.

ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлд эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болохыг хуульчилсан. Өөрөөр хэлбэл, төрийн хяналт шалгалт хийдэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлдэг 31 субъект дээр дурдсан туршилт, судалгаа, шинжилгээ хийдэг лабораторитой байдаг. Тэдний хийсэн дүгнэлт эрүүгийн хэрэгт нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх, хамтран ажиллах боломж бүрдүүлдэг. ШШҮХ-гийн хувьд дангаараа бүх шинжилгээг хийх, дэвшилтэт техник технологийг бүрэн нэвтрүүлэх боломжгүй. Харин их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагыг түшиглэх нь илүү үр дүнтэй юм.<sup>51</sup>

<sup>46</sup> <http://prokuror.mn>

<sup>47</sup> <https://police.gov.mn>

<sup>48</sup> <https://www.iaac.mn>

<sup>49</sup> <http://nifs.gov.mn>

<sup>50</sup> [https://judcouncil.mn/site/site/status\\_page/shinjeech](https://judcouncil.mn/site/site/status_page/shinjeech)

<sup>51</sup> Хууль зүйн ухааны доктор Б.Жаргалсайханы “Шинжлэн магадлахуйн орчин үеийн асуудал-2020” эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлээс.

## ЖИШЭЭ 8. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭГЭЭР НОТЛОГДСОН ХЭРЭГ

1. 2014 оны 1 дүгээр сарын 9-10-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүрэгт гаражаас 27 ширхэг ууцны мах зэрэг эд зүйл алдагдсан гэх эрүүгийн хэрэгт хэргийн газрын үзлэгээр болон сэжигтний машинаас тусгаарлан авсан ургамлын зүйлд Мөр судлалын лабораторийн шинжээч Ж.Тамир, МУИС-ийн Байгалийн ухааны сургуулийн багш, доктор, дэд профессор Д.Сурантай хамтран шинжилгээ хийж “Шинжилгээнд ирүүлсэн ургамлын зүйл нь цагаан лууль (*Chenopodium album L.*) гэдэг нэг наст ургамал байна. Шинжилгээнд ирүүлсэн хоёр ургамлыг гэрлийн микроскопоор судалж үзэхэд ишний гадаад хэлбэр төрх (ишний гадаргуу нь хавиргалаг зузааралттай, хатуурч модожсон, гол хэсэг нь зөөлөн үсэрхэг эдтэй), ишний хөндлөн огтлол (ишний дотоод зөөлөн эд нь бөмбөлөг хэлбэртэй, сийрэг байрласан адил хэмжээний паренхим эсүүдээс тогтсон) зэрэг шинжээрээ нэг зүйл ургамал болохыг тогтоов” гэсэн;
2. 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр СХД-ийн 32-р хороо, Эмээлтийн түүхий эд авах цэгээс урд зүгт 5.7 км зайд овог, нэр тодорхойгүй цогцос олдсон эрүүгийн хэрэгт дээрх хоёр шинжээч хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ургамлын зүйлд хамтарсан шинжилгээ хийгээд “Ургамал, шороо мэт зүйлийн хэсэг байх бөгөөд уг зүйл хатаж бутарсан, иш болон цэцгэрхэг бүтэц нь байхгүй байх тул шинжилгээ хийх чанарын болон тоон үзүүлэлтийн шаардлага хангахгүй” гэсэн дүгнэлт тус тус гаргаж байсан байна.

Энэ баримт ШШҮХ-д мэргэжлийн шинжээч, лаборатори байхгүй ч тусгай мэдлэг бүхий, бусад газрын шинжээчтэй хамтран ажиллах боломж байгааг харуулж байна. Шүүхийн шинжилгээ хийх байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, бусад лабораторитай хамтран ажиллах зохион байгуулалтын болон эрх зүйн зохицуулалтыг тусгайлан судлах шаардлагатай.

## Дүгнэлт

1. ШШҮХ-гийн тооцоо, судалгааны дагуу алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн байна.
2. Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэхэд зохион байгуулалт тодорхойгүй, нэгдсэн бүртгэл байхгүй, хариуцан хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага тодорхойгүй байна.
3. ШШҮХ нь шинжлэн магадлах байгууллага тул зөвхөн шинжилгээ хийхэд гол анхаарлаа хандуулж, хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцдог байдлыг гадаад улсын нэгэн адил зогсоох.
4. Цагдаагийн байгууллагын бүтцэд хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх чиг үүрэг бүхий нэгж байхгүй байгаа нь учир дутагдалтай. Иймд цагдаагийн байгууллагын бүтцэд хэргийн газрын үзлэг хийх чиг үүрэгтэй алба шинээр байгуулах шаардлагатай байна.
5. Хэргийн газрын үзлэг хийн анхан шатны нотлох баримтыг бэхжүүлэхэд гэмт хэргийг илрүүлэх, нотлох, эцэслэн шийдвэрлэх үүрэг хүлээхгүй байгаа шинжээч голлох үүрэгтэй оролцож байгаа нь ул мөрийг хангалттай илрүүлэхэд бэрхшээл учруулж байна хэмээн экспертүүд үзэж байна.
6. Хэргийн газрын үзлэг хийх, ул мөр бэхжүүлэх, анхан шатны шинжилгээ хийх бүтцийг Цагдаагийн байгууллагад байгуулах шаардлагатай байна.

# **Гурав. ГЭМТ ХЭРГИЙГ НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

## **3.1. Гэмт хэргийг нотлох ажиллагааны сургалтын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ**

Хууль зүйн их, дээд сургуулиудад заадаг Эрх зүйч мэргэжил эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, судлах хичээлүүдийг боловсруулахдаа Боловсролын тухай хууль<sup>52</sup>, Дээд боловсролын тухай хууль<sup>53</sup>, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индекс”, 2014 оны А/174 дугаар тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу сургалт явуулдаг байна.

Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь 120 багц<sup>54</sup> цагаас доошгүй багц цагийн бүрэлдэхүүнийг доорх чиглэлээр төлөвлөж, агуулгын сонголт хийх боломж олгодог. Үүнд:

1. Ерөнхий суурь судлах хичээлийн хүрээнд: нийт багц цагийн 30 хувиас илүүгүй;
2. Мэргэжлийн суурь судлах хичээлийн хүрээнд: нийт багц цагийн 25 хувиас илүүгүй;

---

<sup>52</sup> Боловсролын тухай хууль, 4 дүгээр зүйл. “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”, 40 дүгээр зүйл. “Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцна”.

<sup>53</sup> Дээд боловсролын тухай хууль, 3 дугаар зүйл. “Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ”.

<sup>54</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 158 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”-ын 2.5 дахь хэсэг “... Нэг багц цагийн хэмжээ нь өдрийн хэлбэрээр суралцаж байгаа дундаж суралцагчийн 7 хоногийн бүтэн ачаалал буюу 40 цагтай тэнцүү байна. Дээд боловсролын сургалтын байгууллага энэхүү нормативыг харгалзан танхимын ба бие даах цагийн харьцааг хичээлийн хэлбэр бүрээр албан ёсоор тогтоож мөрдөнө...”

3. Мэргэжлийн судлах хичээлийн хүрээнд: нийт багц цагийн 45 хувиас доошгүй байхаар тус тус тусгасан байна.<sup>55</sup>

Нотлох ажиллагааны талаарх сургалтыг эрх зүйчээр гүнзгийрэн судлах хичээлийн хүрээнд Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын эрх зүй, Иргэний эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Захиргааны эрх зүй, Захиргааны процессын эрх зүй хичээлийг судалсны дараа Гэмт хэргийн нотолгооны онол, Нотолгооны онол-арга зүй, Нотлох баримтын онол гэх өөр өөр нэршилтэйгээр, 1-2 багц цагийн багтаамжтайгаар заадаг байна.

Хичээлийн агуулга, эзэмших мэдлэг, чадвар, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө (лекц, семинар, дасгал, бие даалт), хичээлээр ашиглах ном, сурах бичгийн жагсаалт зэргийг боловсруулахдаа тухайн хичээлийн хөтөлбөрт заасны дагуу, багшийн академик<sup>56</sup> эрх чөлөөнд үндэслэн боловсруулдаг байна. Судалгаанд хамрагдсан их, дээд сургуулиудын нотлох ажиллагааны талаарх хичээлийн кредит цаг, лекц, семинар, дасгал, бие даалтын цагийг хүснэгт 19-д харууллаа.

#### ХҮСНЭГТ 19. НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ

№	Сургуулийн нэр	Хичээлийн нэр, код	Кредит цаг	Үзэх цаг		
				Лекц	Семинар Дасгал	Бие даалт
1	ДХИС-ийн Цагдаагийн сургууль	Гэмт хэргийн нотолгооны онол-СТО2307	2	16	32	16
2	МУИС-ийн ХЗС	Нотолгооны онол-арга зүй - CRIL439	2	24	16	-
3	Их засаг ОУИС-ийн ХЗС	Нотлох баримтын онол-EVID415	1	16	-	-
4	ХУИС-ийн харьяа Билиг дээд сургууль	Гэмт хэргийн нотолгооны онол-LW305	2	30	30	-

<sup>55</sup> Тайлбар: Дээрх бүлэг тус бүр заавал судлах болон сонгох хичээлээс бүрдэнэ. Сонгох хичээлийг ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн хувьд сургуулийн санал болгох жагсаалтаас, харин мэргэжлийн хичээлийн хувьд оюутан багшийнхаа зөвлөмжийг авч сургуулийн санал болгосноос гадна тухайн сургуультай харилцаа бүхий өөр бусад сургууль, тэнхимийн хичээлээс сонгох боломж бүрдүүлнэ.

<sup>56</sup> Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолын хавсралт. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он) 3.15.Боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагын академик эрх чөлөөг хангана.



МУИС-ийн ХЗС, Их засаг ОУИС-ийн ХЗС, ХУИС-ийн харьяа Билиг дээд сургуулиуд нь аливаа хэрэг, маргаан (эрүү, иргэн, захиргаа, арбитраж болон бусад)-ыг нотлох явцад нотолгооны ач холбогдлыг үнэлж, дүгнэлт өгч, ашиглах чадвар эзэмшүүлэх, нотолгооны ойлголт, үе шат, нотлох ажиллагаа, нотлох баримт, түүнийг үнэлэх, ашиглах талаар онолын ойлголт, мэдлэг эзэмшүүлэх хэмээн нотлох ажиллагааны талаарх хичээлийн зорилтыг тодорхойлжээ. Дотоод хэргийн Их сургууль “Гэмт хэргийг нотлоход шаардлагатай онолын мэдлэг эзэмшүүлэн, нотлох ажиллагааны явцад гарах аливаа хүндрэлийг онол, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх арга зүйд суралцах, гэмт хэрэгтэй холбоотой нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх дадал, чадвар эзэмших, мөн нотлох баримтыг ангилж түүнд үнэлэлт өгөх, энэ ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах хандлага төлөвшүүлэх” гэж зорилтоо томъёолжээ.

Нотлох ажиллагааны талаарх сургалтын хөтөлбөрийг дараах ерөнхий агуулгын хүрээнд судалдаг байна. Үүнд:

1. Нотолгооны онол ба ойлголт, төрөл;
2. Нотолгооны арга, үе шат, зүйл, хэмжээ хязгаар;
3. Нотлох ажиллагаа;
4. Нотлох баримт, түүний шинж;
5. Нотлох баримтын цогц байдал, түүнийг ашиглах;
6. Эд мөрийн баримт;
7. Тодорхой төрлийн нотлох ажиллагаа;
8. Мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл.

Дотоод хэргийн Их сургуульд гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндсэн үүрэг бүхий мэргэжлийн үйл ажиллагааг бие даан болон багаар хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамж эзэмшсэн алба хаагчийг бэлтгэж байгаа тул тодорхой төрлийн гэмт хэргийн нотлох ажиллагааны талаар дэлгэрэнгүй судалдаг байна. Тухайлбал, Эрүүл мэндийн, Өмчлөх эрхийн, Компьютерын мэдээллийн аюулгүй байдлын, Байгаль хамгаалах журмын, Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны болон Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зэрэг гэмт хэргийн нотлох ажиллагааны талаар судалдаг байна.

Тодорхой төрлийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд ашигладаг техник хэрэгсэл ашиглах талаар Криминалистикийн хичээлээр судалж, залгамж холбоотой<sup>57</sup> Гэмт хэргийн нотолгооны онол хичээлээр эрх зүйн орчны онолын мэдлэгийг гүнзгийрүүлэн судалдаг. Тухайн хичээлийг судлах явцад идэвх оролцоо, сэдвийн шалгалт, бие даалт, улирлын шалгалтын нийлбэрээр дүгнэдэг байна. Үүнийг сургууль тус бүрээр нарийвчлан Хүснэгт 20-д харууллаа.

### ХҮСНЭГТ 20. НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

№	Сургуулийн нэр	Хичээлийн үнэлгээ (100 оноо)			Нийт оноо
		Явц (идэвх оролцоо)	Бие даалт	Улирлын шалгалт	
1	ДХИС-ийн Цагдаагийн сургууль	70	30	30	100
2	МУИС-ийн ХЗС	20-40	20-40	20-40	100
		Багш өөрийн үзэмжээр дүйцүүлэн гаргадаг <sup>58</sup>			
3	Их засаг ОУИС-ийн ХЗС	50	20	30	100
4	ХУИС-ийн харьяа Билиг дээд сургууль	50	20	30	100

### Дотоод хэргийн Их сургуулийн Шинжээч-мөрдөгч мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр

Дотоод хэргийн Их сургуулиас Цагдаагийн ажил-эрх зүй (103203) хөтөлбөрийн хүрээнд дараах ур чадвар эзэмшсэн Шинжээч-мөрдөгч бэлтгэх зорилго тавьж, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан 2018-2019 оны хичээлийн жилд анхны элсэлтээ авч, 2019-2020 оны хичээлийн жилд анхны төгсөлтөө хийсэн байна. Үүнд: Мэргэшсэн албан хаагч нь криминалистик, шинжлэн магадлахуйн болон мөрдөн шалгах ажиллагаа, хэргийн газрын үзлэгийг удирдан явуулах, мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх, оношилгоо, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах шинжлэн магадлахуйн ухааны мэдлэгтэй шинжилгээний тодорхой чиглэлээр магадалгаа, дүгнэлт гаргах чадвартай, сэтгэл зүй, ёс зүй, харилцааны ур чадвартай байх шаардлага тавьж ажиллажээ.

<sup>57</sup> Тухайн хичээлийг үзэж, судалсны дараа орох хичээл.

<sup>58</sup> МУИС-ын Захирлын 2011 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 304 тоот тушаал, МУИС-ийн бакалаврын сургалтын журам.

Тухайн хөтөлбөрийн онцлог нь бакалаврын зэрэгтэй эдийн засагч, инженер, хүний их эмч, орчуулагч, химич, биологич зэрэг мэргэжилтэй (өмнөх бакалаврын дипломын голч дүн 2.6-гаас доошгүй), цагдаагийн байгууллагад ажиллах бие бялдар, эрүүл мэнд, сэтгэцийн шалгуур хангасан, жолооны А, В ангиллын үнэмлэхтэй иргэдийг элсүүлэн хоёр жилийн хугацаанд мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийг судлуулдаг.

Хичээлийн задаргааг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

1. *Мэргэжлийн суурь хичээлд:* Бие хамгаалах бэлтгэл 1, 2, 3, Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, Ерөнхий гэрэл зураг, дүрс бичлэг, Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүй, Криминологи, Мэргэжлийн удиртгал, Цагдаагийн эрх зүй, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Эрх зүй, төрийн онол, Харилцааны болон албаны ёс зүй 2, Шинжлэн магадлахуйн онол хичээлүүдийг тус бүр 2 багц цаг, Эрүүгийн эрх зүйн тусгай анги хичээлийг 3 багц цаг, нийт 34 багц;
2. *Мэргэжлийн хичээлд:* Тагнах үйл ажиллагааны тактик 2, Хүний мөр судлал, Гэмт хэргийн зүйлчлэлийн онол, Гэмт хэргийн нотолгооны онол, Механоскопын шинжилгээ, Тагнах үйл ажиллагааны тактик 3, Хэргийн газарт мөртэй ажиллах арга зүй, Шүүх-сэтгэц гэм судлал, Шүүх эмнэлэг, Амьтны мөр судлал, Баримт судлал, Шүүх-нягтлан бодох бүртгэл хичээлүүдийг тус бүр 2 багц цаг, Криминалистикийн техник зүй, Эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий анги, Эрүүгийн процессын эрх зүйн тусгай анги, Криминалистикийн арга зүй, Криминалистикийн тактик зүй, Хууль тогтоомжийн хэрэглээ хичээлүүдийг тус бүр 3 багц цаг, нийт 42 багц цаг;
3. *Танхимын дадлага:* Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий албаны тогтолцоо, Криминалистикийн шинжилгээ зүй 1, Криминалистикийн шинжилгээ зүй 2, Гэмт хэргийн мөртэй ажиллах үйл ажиллагаа, Мөрдөн шалгах ажиллагаа сэдвээр тус бүр 1 багц цаг, нийт 6 багц цаг;
4. *Ангийн ажил:* Криминалистикийн тактик, арга зүй хичээл, Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн чиглэлээс сонгохоор тус бүр 1 багц цаг;
5. *Үйлдвэрлэлийн дадлага:* Хэргийн газрын үзлэг, Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чиглэлээр тус бүр 6 багц цаг, нийт танхимын бус сургалтыг 14 багц цагаар буюу сургалтын төлөвлөгөө нийт 96 багц цагаар явагддаг байна.

Тус хөтөлбөр нь тодорхой төрлийн бакалаврын боловсролтой иргэдийг элсүүлэн, хоёр жилийн хугацаанд эрх зүйн болон гэмт хэрэгтэй тэмцэх, криминалистик, шинжлэн магадлахуйн болон мөрдөн шалгах ажиллагаа, хэргийн газрын үзлэгийг удирдан явуулах, мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, оношилгоо, шинжилгээ хийж дүгнэлт гаргаж, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, шинжлэн магадлахуйн ухааны мэдлэгтэй, шинжилгээний тодорхой чиглэлээр магадалгаа, дүгнэлт гаргах чадвартай алба хаагчийг бэлтгэх үр дүнтэй хөтөлбөр болсон гэж үзэж байна.

### **Дүгнэлт**

1. Хуулийн сургуульд хуульч мэргэжлээр ажиллахаар суралцаж байгаа оюутан, хууль сахиулагч, мөрдөгчөөр ажиллах сонсогчид заах нотолгооны хичээл ялгамжтай байх шаардлагатай.
2. Өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллах хүн нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглах, нотолгооны арга тактик хэрэглэхээс илүү нотлох баримтын зүй тогтол, хууль зүйн шаардлага, тодорхой төрлийн нотлох баримтыг шүүхэд шинжлэн судлах чадвар, эрэлт хэрэгцээ өндөр байна.
3. Хууль сахиулагчийн хувьд нотолгооны арга тактик, нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, эдгээр ажиллагаанд техник хэрэгсэл ашиглах чадвар, тусгай мэдлэг шаардахаар байна. Түүнчлэн мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, мөрдөгч-шинжээч, шинжээч, бусад хууль сахиулагчийн хувьд нотлох баримттай харьцах ур чадвар харилцан адилгүй байгааг анхаарах нь зүйтэй.
4. Нотлох ажиллагаатай холбоотой нарийвчилсан журам, “хууль” байхгүй учир ямар ажилтан нотлох ажиллагаатай холбоотой процессыг хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй байдаг нь сургалтыг төлөвлөхөд хүндрэл учруулж байна. ДХИС-аас бусад сургуульд “Эрүүгийн хэрэг дэх нотолгооны онол, арга зүй” хичээл заавал үзэх хичээл биш, сонгон судалдаг. Энэ нь уг хичээлийг заах багш онолын төдийгүй практик дадлага туршлагатай байх шаардлагатайгаас үүдэн багшийн хүрэлцээ муу байгаатай холбоотой байж болох юм.

5. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх талаар хууль сахиулагчдад мэдлэг, ур чадвар олгох криминалистикийн шинжлэх ухааны чиглэлээр Дотоод хэргийн Их сургууль бусад хуулийн сургуультай харьцуулшгүй мэргэшсэн байдаг. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн “Багшлах бүрэлдэхүүний чадавх сайн ч онол, практик зөрдөг, нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд ашиглах техник, хэрэгсэл дутмаг байдал нь сургалтын чанарт нөлөөлдөг” гэсэн дүгнэлттэй санал нийлж байна.
6. Хичээлийн зарим хөтөлбөрт семинар, бие даалтын цагууд хангалтгүй байгаа нь онолын мэдлэгийг бататгах боломж багатай тул чадвар суухад нөлөөлдөг байх магадлалтай.
7. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн мэргэшсэн алба хаагч бэлтгэхэд их, дээд сургууль төгссөн, тодорхой мэргэжилтэй элсэгчдийг Дотоод хэргийн Их сургуульд авч, Шинжээч-мөрдөгч мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр нь үр дүнтэй байна.

### **3.2. Гэмт хэргийг нотлох ажиллагааны ном, гарын авлага, бүтээлүүдэд хийсэн дүн шинжилгээ**

Гэмт хэргийг нотлох ажиллагааны хичээл сургалтад ашиглаж байгаа номын жагсаалтыг гаргахдаа 1987 оноос хойш монгол хэлээр бичигдсэн 100 орчим ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийг ашиглалаа. Тодруулбал:

1. Эрүүгийн процессын эрх зүйн чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлага;
2. Эрүүгийн эрх зүйн чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлага;
3. Гэмт хэргийг нотлох ажиллагаатай холбоотой ном, сурах бичиг, гарын авлага;
4. Тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөн шалгах чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлага;
5. Иргэн, захиргаа, арбитрын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн талаарх ном, сурах бичиг, гарын авлага;
6. Криминалистикийн шинжлэх ухаантай холбоотой ном, сурах бичиг, гарын авлага гэж ангилан харуулж болохоор байна.

Эдгээр хөтөлбөрт хууль зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн багц хуулийг шинэчлэн найруулж 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөнөөс хойш хэвлэгдсэн ном, сурах бичиг, гарын авлага тусгагдаагүй. Тухайлбал, Эрүүгийн багц хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш гэмт хэргийг нотлох ажиллагааны талаарх нэг сэдэвт бүтээл гараагүй ба эрүүгийн процессын эрх зүйн дараах бүтээлүүдийн холбогдох бүлэгт нотлох баримт, нотлох ажиллагааны агуулга тусгагдсан байна. Үүнд:

1. Р.Баярмагнай. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт. УБ., 2017 он;
2. Б.Амарбаясгалан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Шүүхийн өмнөх болон шүүхийн шат). УБ., 2018 он;
3. Г.Наранбаатар. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхийн акт үйлдэх аргачлал. УБ., 2018 он;
4. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он;
5. Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун. Мөрдөгчийн гарын авлага. УБ., 2018 он;
6. Б.Хишигтогтох, Б.Баярмагнай. Мөрдөн байцаалтын ажиллагаа. УБ., 2018 он;

7. Б.Бат-Эрдэнэ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй (альбом, схем). УБ, 2018 он;
8. Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь (Онол, практикийн хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл). УБ., 2019 он;
9. Т.Оюунчимэг нар. Эрүүгийн хэрэг шалгаж, шийдвэрлэх ажиллагаа. УБ., 2020 он.

Мөн сургалтын хөтөлбөрт гадаад хэлээр гарсан 15 бүтээлийг хичээл сургалтад ашиглахаар заасан байх ба эдгээр бүтээлийн дийлэнх нь ОХУ-ын эрдэмтэн, судлаачдын бүтээл байгаа нь энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ хэт нэг чигийг барьсан ойлголтыг оюутан, сонсогчдод өгөхөөр байна.

Гэмт хэргийн нотлох ажиллагааны чиглэлээр Ж.Хурцгэрэл<sup>59</sup>, Д.Жаргалсайхан<sup>60</sup>, Д.Зүмбэрэллхам<sup>61</sup>, Ж.Болдбаатар<sup>62</sup>, Б.Бат-Эрдэнэ<sup>63</sup>, Ц.Гантулга<sup>64</sup>, Т.Оюунчимэг<sup>65</sup>, П.Оюунчимэг<sup>66</sup>, Л.Мөнхсайхан<sup>67</sup>, Б.Батзориг<sup>68</sup> нар эрдмийн ажил эрхэлж, хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээлүүдийг сургалтад ашигладаг байна.

---

<sup>59</sup> Дэд эрдэмтэн Ж.Хурцгэрэл, "Малын мөр, тамганд хийх траслогийн шинжилгээ", 1988.

<sup>60</sup> Дэд эрдэмтэн Д.Жаргалсайхан, "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бодит үнэний зарчим", 1991.

<sup>61</sup> Д.Зүмбэрэллхам, "Монголын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйд тооцох зарчмыг сахин хэрэгжүүлэх асуудал", (Ph.D), 2001.

<sup>62</sup> Ж.Болдбаатар, "Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн нотолгооны асуудал", (Ph.D), 2003.

<sup>63</sup> Б.Бат-Эрдэнэ, "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч шинжээчийн эрх зүйн байдал", (Ph.D), 2009.

<sup>64</sup> Ц.Гантулга, "Гэмт хэргийг илрүүлэхэд мөр нотолгооны ач холбогдолтой болох нь (амьтны мөрийн жишээн дээр)", (Ph.D), 2009.

<sup>65</sup> Т.Оюунчимэг, "Гүйцэтгэх ажлын үр дүнг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримтаар ашиглах нь", (Ph.D), 2009.

<sup>66</sup> П.Оюунчимэг, "Эрүүдэн шүүлт ба хүний эрх", (Ph.D), 2010.

<sup>67</sup> Л.Мөнхсайхан, "Монгол Улсын шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчим, түүний эрх зүйн зохицуулалтын асуудлууд".

<sup>68</sup> Б.Батзориг, "Эрүүгийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онол, практикийн асуудал", (Ph.D), 2012.

## **Дүгнэлт**

1. ЭХХШТХ шинэчлэн батлагдсантай холбогдуулан гэмт хэргийн нотолгооны онолын чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, шинэ ном, сурах бичиг хангалтгүй байна. Хуулийн хэрэглээний талаарх ойлголт нэг мөр болоогүйгээс тулгарч байгаа асуудлын талаар онол, практикийн зөвлөмж өнөөдрийг хүртэл хангалттай хэмжээнд гараагүй байна.
2. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд шинжлэх ухаан технологийн ололт, техник хэрэгсэл ашиглах арга зүй, шүүх шинжлэн судлах явцад гарсан алдаа, оноо нь эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн зохицуулалтын онцлогоос харьцангуй бага хамаардаг тул уламжлалт аргаар мөрдөн шалгах ажиллагаа явагдсаар байна.
3. Монгол Улсад гадаадын хөгжингүй орнуудын нотолгооны ном бүтээл, хэрэг мөрдөх, шүүхийн хэлэлцүүлгийн сайн туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохируулан нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага байна.



# НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

## Дүгнэлт 1. Эрх зүйн орчин

ЭХХШТХ хүчин төгөлдөр болж хэрэгжээд гурван жил өнгөрч байхад мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчид ЭХХШТХ-ийн үзэл баримтлал, шинэ төрлийн нотлох баримт цуглуулж бэхжүүлэх аргуудын талаар нэгдсэн ойлголт байхгүй, шинэлэг зохицуулалтуудыг төдийлөн ашиглахгүй, уламжлалт хуучин арга, тактикаар нотлох баримт цуглуулж бэхжүүлэх нь түгээмэл байгааг дурдах нь зүйтэй. Тэрчлэн мөрдөгч, шүүгчдийн хувьд хууль хэрэгжүүлэхэд учирдаг олон бэрхшээлийг хуульд нялзаах хандлага давамгайлж байна.

Ийм нөхцөлд бие даасан хараат бус судалгаа хийлгүйгээр мөрдөх, хяналт тавих, шүүн таслан байгууллагын үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлийг шийдэх чиглэлээр Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Хэрэг нотлох ажиллагааны явцад төрийн байгууллага, албан тушаалтанд учирч буй саадыг хуульчлан арилгах нь хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдалд хохиролтой хуульчлагдах эрсдэлтэй.

Гэвч эрүүгийн процессын хууль байнга шинэчлэгдэж байхыг шаарддаг. Учир нь, гэмт этгээдүүд үйлдлийн аргаа улам боловсронгуй болгож, илрүүлэхэд төвөгтэй болгосоор байна. Тэдэнд хуулийн хариуцлага тооцох гол үндэслэл болсон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаа нь шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтаас шууд хамааралтай.

Бид хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулах зохимжгүй гэсэн хандлагаа өөрчлөх нь зүйтэй. Эрх зүйн орчныг сайжруулж байгаа орны туршлагаас харахад процессын хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулах замаар алгуур шилжилт хийж байна.

Нотлох баримт илрүүлж бэхжүүлэхэд ашиглах техник хэрэгслийн ололт, дэвшлийг ашиглах эрх зүйн орчин нь тодорхой хэмжээнд бүрджээ. 2016 оноос хойш нийгмийн аливаа харилцааг дүрэм, журмаас илүү хуулийн хүрээнд зохицуулах болсон нь том дэвшил юм. Гэвч мөрдөгчид нотлох ажиллагаандаа шинэ төрлийн нотолгооны арга, техник хэрэгслийн дэвшлийг төдийлөн ашиглахгүй байгаа нь ЭХХШТХ-ийн хэрэгжилт, нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагаанд төдийлөн ахиц гарахгүй байхад нөлөөлж байна. Иймд нотлох баримт цуглуулж бэхжүүлэх болон тэдгээртэй уялдан бий болдог зохицуулалтыг нарийвчлан

хуульчлах шаардлага тулгарч байна. Уг хуулиар нотлох баримттай ажиллах наад захын жишгийг тогтоож өгснөөр мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчид нэгдсэн ойлголттой болно.

Өмгөөлөгчдийн хувьд нөөц бололцоогоо ашиглан техник хэрэгсэл ашиглах боломжтой, хэрэглэх сонирхол нь ч өндөр байдаг. Гэвч хууль зүйн хувьд хориглосон зүйл байхгүй ч нарийвчилсан зохицуулалт байхгүй учир мөрдөгч, прокурор, шүүгч өөрийн үзэмжээр хандахад хүргэдэг байна.

### **Санал зөвлөмж**

1. ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тодорхой байгууллагын үйл ажиллагаанд учирдаг хүндрэл бэрхшээлд тулгуурлах бус, хөндлөнгийн хараат бус судалгаанд тулгуурлан байнга шинэчилж байх.
2. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, аюулгүй байдлыг хангах, тодорхой төрлийн гэмт хэргийг нотлох онцлогийг хуульчилсан “Нотлох баримтын тухай” хуулийн төсөл боловсруулах.
3. Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, судалгаа шинжилгээ хийн, хүний эрхийг дээдэлсэн, шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах боломж бүрдүүлсэн, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартад нийцсэн хуулийн санал боловсруулдаг, сургалт, зохион байгуулалтын оновчтой арга зам эрэлхийлдэг, тогтмол үйл ажиллагаатай судалгааны нэгж ХЗДХЯ-ны дэргэд байгуулах.
4. Цахим нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.
5. Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгийг нотлох баримт болгохгүй байх заалт хуульчлагдсан. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцахгүй байх талаар Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зохицуулалтууд тусгагдсан. Хэдий тийм ч мэдүүлэг авахаас өөр бусад аргаар нотлох баримт цуглуулж бэхжүүлсэн бол нотлох баримтаар тооцохгүй байх зохицуулалтыг орхигдуулжээ. Иймд ЭХХШТХ-ийн 16.12 дугаар зүйлийн 1-д заасан “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэснийг “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг

бус, хэрцгий хандаж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь тогтоогдвол уг нотлох баримтыг энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах.

6. Өмгөөлөгч өмгөөлөх үйл ажиллагаанд техник, хэрэгсэл ашиглах боломжийг ЭХХШтХ-д нарийвчлан тусгах.
7. Төрийн болон мэргэжлийн байгууллагын хяналт шалгалт явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, цугларсан баримтат мэдээлэл нь нотлох баримтын шаардлага хангахгүй тул шууд нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй юм. Иймд хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар нотлох баримт, нотлох ажиллагааны нэг стандарт бий болгосноор давхардал гарахгүй, хяналт шалгалтын үр дүнд эергээр нөлөөлөх давуу талтай.

## **Дүгнэлт 2. Техник хэрэгслийн хангалт, зохион байгуулалт**

Шинэ хуулийн орчинд хэрэг хянан шийдвэрлэх удирдлага, зохион байгуулалт дутмаг байна. Үүний улмаас шинэ төрлийн болон зохион байгуулалттай гэмт хэргийг нотлох ажиллагаанд дэвшил гарч байгаа боловч орон нутагт энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдсэн даруй нотлох ажиллагааг шууд хэрэгжүүлэх чадавх сул байна. Нийтлэг үйлдэгддэг гэмт хэргийг нотлох ажиллагаа нь уламжлалт арга барилаар явагдсаар байна.

Нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэж болохоор заасан боловч мөрдөгчид дуу-дүрсний бичлэг, гэрэл зургийн аппарат зэргээс өөр техник хэрэгслийн ололтыг түгээмэл ашиглахгүй байна.

Нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлж шалгах, үнэлэх арга зүйг сайжруулах чиглэлийн дорвитой ажил сүүлийн жилүүдэд хийгдээгүйгээс одоогийн мөрдөгчдийн арга зүй нь цаг үеийн шаардлагыг хангахгүй байна. Мөн анхан шатны нотлох баримт цуглуулж, бэхжүүлж хэргийн газарт ашиглаж байгаа жижүүрийн шинжээч, мөрдөгчдийн ул мөр, илрүүлэх, бэхжүүлэх техник хэрэгсэл ердийн зориулалт бүхий, хуучирсан, хэрэг илрүүлэх үүргийг хүлээдэггүй зэрэг нь шинжээч хэргийн газраас нотлох баримтыг бүрэн дүүрэн цуглуулж бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын орон нутаг дахь нэгжүүд нарийн шинжилгээ хийдэггүйгээс Улаанбаатар хот дахь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн рүү зөөвөрлөхдөө шаардлага хангахгүй битүүмжилж ирүүлснээс зарим шинжилгээний зүйлийн чанар алдагдаж, шинжилгээ хийх боломжгүй болдог байна.

### **Санал зөвлөмж**

1. Мөрдөгч нотлох баримт цуглуулж бэхжүүлэх хуульчилсан тодорхой ажиллагаа бүрт ашиглагдах техник хэрэгслийн судалгааг “гадаад, дотоодын ололтыг ашиглан” хийх;
2. Мөрдөгчдийн үйл ажиллагаагаа хүнээс хамаарсан бус, техник хэрэгсэл ашиглан явуулах боломжийг бүрэн бүрдүүлж ажиллах, урсгал зардлыг сайтар тооцох;
3. Мөрдөгч, шинжээчдэд үйл ажиллагаандаа ашиглахаар өгч буй техник хэрэгслийн хангалт хийхдээ ашиглах зааврыг дэлгэрэнгүй хавсаргах.

### **Дүгнэлт 3. Шүүх шинжилгээний үйл ажиллагаа**

ШШҮХ нь дангаараа бүх төрлийн шинжилгээ хийх боломжгүй бөгөөд бусад төрлийн шинжилгээг ЭХХШТХ-ийн 27.4 дүгээр зүйлд заасны дагуу нэр бүхий төрийн 11 байгууллагаар хийлгэж байна. Хэдий тийм боловч нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, уялдаа байхгүй, тэдгээр байгууллагын мэргэжилтнүүд нь шинжээчийн эрх, үүргийг бүрэн ухамсарладаггүй, шинжээчийн дүгнэлтүүд хэлбэр, загварын хувьд хоорондоо эрс ялгаатай, шинжилгээний зардлыг хэрхэн тооцож олгох зэрэг асуудал нэг мөр шийдэгдээгүй байна. Тэрчлэн өөрсдийн үндсэн ажил биш тул ажил хэрэгч бус хандах зэргээс үүдэж гаргасан дүгнэлтийг нотлох баримтаар үнэлэхэд эргэлзээ үүсэх зэрэг хүндрэл учирдаг байна.

### **Санал зөвлөмж**

1. Шүүх шинжилгээний байгууллага нь хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын дэргэдэх туршилт, шинжилгээний байгууллагууд, их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, техник хэрэгсэл хамтран ашиглах, шинжилгээ, судалгаа, туршилт хамтран хийх боломжийг судлах замаар эрүүгийн хэргийн нотолгоог шинэ шатанд гаргах.

2. Шинжилгээ хийж дүгнэлт гаргах мэргэжилтнүүдийн судалгаа, бүртгэлийг Шүүхийн шинжилгээний төв байгууллагад бий болгож мөрдөгчдийг мэдээллээр хангах, мэргэжилтэн, шинжээчдийг сургах.

#### **Дүгнэлт 4. Сургалт, эрдэм шинжилгээ**

ЭХХШТХ-ийн талаар мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгчид харилцан адилгүй ойлголттой байна. Нотлох баримт цуглуулж бэхжүүлэх болон тээвэрлэх, хадгалах, хамгаалах, нотлох баримтыг шинжлэн судлах, хүчингүйд тооцох талаар ойлголт сул байгаа нь судалгааны дүнгээс харагдав. ЭХХШТХ-д нотлох баримтын ойлголт, нотлох баримт цуглуулж бэхжүүлэхэд техник хэрэгсэл ашиглах эрх зүйн орчин бүрдсэн боловч шинэ хуулиар бичсэн ном, сурах бичиг ховор, судалгааны ажил цөөхөн байгаагаас сургалт болон практик хэрэглээнд хүндрэл учирч байна. Мөн хуулийг нэг мөр ойлгоход иш татах судалгааны бүтээл байхгүй байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хууль зүйн их, дээд сургуулиудад зааж байгаа нотлох баримт, нотлох ажиллагаатай холбоотой хичээл нь Дотоод хэргийн Их сургуульд Гэмт хэргийн нотолгооны онол нэртэйгээр хоёр багц цагийн багтаамжтайгаар семинар, дасгал түлхүү заагддаг бол бусад их, дээд сургуульд Нотолгооны онол нэртэйгээр агуулгын хувьд эрүү, иргэн, захиргаа, арбитрын болон бусад хэрэг маргааныг нотлох ажиллагаатай холбоотой хичээлээр лекц голчилсон онолын мэдлэгийг түлхүү зааснаар төгсөгчид эрүүгийн хэргийн нотлох баримтын талаарх мэдлэгийг харилцан адилгүй эзэмшдэг байна. Мөн тухайн хичээлүүдэд ашиглаж байгаа ном, сурах бичгүүд хуучирсан, 2002 оны ЭБШХ-тай нийцүүлэн гаргасан сурах бичгүүд дийлэнх хувийг эзэлж байгаа юм.

Эрх зүйч мэргэжлээр төгсөж байгаа хүмүүст нотолгооны онол, нотлох баримтыг шинжлэн судлах асуудлыг шүүхийн практик, хуулийн хэрэглээ талаас нь, харин хууль сахиулагчаар төгсөж байгаа хүмүүст нотлох баримт цуглуулж бэхжүүлэх, түүнийг тээвэрлэх, хадгалах, тодорхой төрлийн гэмт хэргийг шууд ба шууд бус нотлох баримтаар хэрхэн нотлох мэдлэг ур чадвар нарийвчлан заах шаардлагатай.

### **Санал зөвлөмж**

1. Хууль сахиулагч, хуульчид нэгдсэн мэдээлэл, сургалтын гарын авлага, ном бүтээл байршуулдаг, туршлага солилцдог сувгуудыг өргөтгөх.
2. Эрх зүйч, мөрдөгчөөр ажиллахаар суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг ялгамжтай тогтоон, сургагч багш бэлтгэн, сурах бичиг, гарын авлагыг шинэ хуульд нийцүүлэх.
3. Өмгөөлөгчдөд техник технологи ашиглах, нотлох баримтаар тооцох, шинжлэн судлах арга зам заах сургалт, мэдээлэл өгөх ажлыг эрчимжүүлэх.

## ХАВСРАЛТ 1

### **ЖУРАМ D. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАНИУЛАХ БУЮУ ТАНЬЖ ОЛУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ (цаашид таниулах ажиллагаа гэх. Орч.)**

#### 1. Удиртгал

- 1.1. Гэмт хэргийг мөрдөх үед хэрэгт ач холбогдолтой мэдээ баримт олж авах, хадгалж, хамгаалах зорилгоор цагдаагийн алба хаагчаас хэрэгжүүлэх таниулах ажиллагааны зарчим, арга зүйг энэ журмаар тогтооно.
- 1.2. Гэмт хэрэг үйлдсэн байж болох хүнийг харсан гэрч нь эгнээгээр тогтоох<sup>69</sup>, дүрс бичлэгээр таниулах ажиллагаанд оролцоно. Таниулах ажиллагааг явуулахад дараах зүйлд анхаарч, төлөвлөлт хийсэн байна. Үүнд:
  - Гэрч нь өмнө харж байсан хүнээ таних чадвартай эсэхийг шалгах;
  - Таньж олуулах ажиллагаанд алдаа гарахаас сэргийлэх.Цагдаагийн алба хаагч энэ журмын дагуу тодорхой төрлийн таниулах ажиллагаа явуулахаас өмнө дуу хоолой ашиглаж таниулах гэх мэт ажиллагааг хэрэгжүүлсэн байж болно.
- 1.3. Таниулах ажиллагааны үед хүний хурууны хээг авч болно. Ингэхдээ дараах зорилгыг удирдлага болгоно. Үүнд:
  - хүний хурууны хээг хэргийн газраас олдсон хурууны хээтэй харьцуулах шинжилгээнд оруулах;
  - гэм бурууг тогтоож нотлох;
  - тухайн хүний хэн болохыг тогтоох.
- 1.4. Хэргийн газраас олдсон хөлийн (гутлын) мөртэй тухайн хүнээс авсан хөлийн мөрийг харьцуулах зорилгоор таниулах ажиллагааны үед хүний хөлийн (гутлын) мөрийг авна.
- 1.5. Хүний биеэс зарим төрлийн дээж<sup>70</sup> авч тухайн дээжийг таниулах ажиллагаанд ашиглаж болно. Энэ ажиллагаа нь хохирогч эсхүл хэргийн

<sup>69</sup> Эгнээгээр тогтоох *parade identification* гэрч эгнээгээр байрлал эзлүүлэн зогсоосон хүмүүс дотроос сэжигтнийг таньж олох ажиллагаа.

<sup>70</sup> Дээж нь шинжилгээнд авах хэв, хэлбэр болно.

газраас олдсон цус, үс гэх мэт DNA<sup>71</sup>-ийн мэдээлэл агуулж чадах зүйлстэй харьцуулах шинжилгээ хийх зорилгоор хэрэгжинэ.

- 1.6. Баривчлагдсан сэжигтэн, эрэн сурвалжлагдаж байгаа хүнийг хайх, хэн болохыг нь тогтоох, мөрдөлт явуулах зорилгоор тэдгээрийн гэрэл зургийг гэрэл зургийн санд авна. Сэжигтнийг батлан даалтад өгөх боломжгүй, гэмт хэрэгт эрэн сурвалжлах ажиллагаа явуулж байгаа зэрэг тохиолдлуудад баривчлагдсан сэжигтний гэрэл зургийг авч таниулах ажиллагаанд ашиглана.
- 1.7. Саатуулагдсан сэжигтнийг шалгах, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах үед таниулах ажиллагааны бусад аргыг ашиглана. Тухайлбал, сорви, шивээс зэрэг содон шинж тэмдгээр нь сэжигтнийг хайж олох, шалгахад энэ төрлийн сангаас мэдээлэл авч харьцуулалт хийж болно.
- 1.8. 1984 оны Цагдаагийн байгууллага болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн зүйл, заалт болон энэ журмын дагуу зөвхөн гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хурууны хээ, хөлийн (гутлын) мөр, гэрэл зураг, бусад дээж, хэв, хэлбэрийг авч, бэхжүүлж, хадгалж ашиглана. Ингэхдээ журмын аль зохимжтой заалтыг хэрэгжүүлэн ажиллана.

## 2. Ерөнхий хэсэг

- 2.1. Энэ журам нь нийт цагдаагийн газарт хэрэглэхэд бэлэн байдлаар хадгалагдаж, дор дурдсан хүмүүст зөвлөмж болон хэрэглэгдэнэ.
  - Цагдаагийн алба хаагч, ажилтан;
  - Баривчлагдсан хүмүүс;
  - Иргэд.
- 2.2. Энэ журмын зүйл, заалт нь хавсралттай байх ба тус хавсралтаас гадна тусгайлсан удирдамж, тайлбарыг дагаж мөрдөхгүй.
- 2.3. Журам С-ийн 1.4 дэх хэсэгт заасан сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг хүний талаарх зохицуулалт болон тэдгээрийн талаар журмаар тогтоосон удирдамж, тайлбарыг тус тус энэ журамд хэрэглэж болно.
- 2.4. Журам С-ийн 1.5 дахь хэсэгт заасан 17 насанд хүрээгүй хүний талаарх зохицуулалтыг энэ журамд нэгэн адил хэрэглэнэ.

---

<sup>71</sup> Дезоксирибонуклейны хүчил (ДНХ) нь мэдэгдэж буй бүх амьд организмын өсөлт хөгжилт, ажиллагаанд ашиглагддаг генетикийн заавруудыг агуулсан нуклейны хүчил юм.



- 2.5. Журам С-ийн 1.6 дахь хэсэгт заасан сонсгол, хэл ярианы чадваргүй, хараагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах тухай хэм хэмжээг энэ журамд нэгэн адил ойлгож хэрэглэнэ.
- 2.6. Энэ журамд:
- “холбогдох насанд хүрсэн хүн” гэснийг Журам С-ийн 1.7, тус журмын тайлбар хэсэгт заасны нэгэн адилаар ойлгож хэрэглэнэ.
  - “хууль зүйн төлөөлөгч, өмгөөлөгч” гэснийг Журам С-ийн 6.12, журмын тайлбар хэсэгт заасны нэгэн адилаар ойлгож хэрэглэнэ.
- 2.7. Баривчлах байрны албан хаагч нь журамд заасан өөрийн чиг үүрэгт хамаарах ажлыг хэрэгжүүлнэ (С-ийн 1.9-ийг үз).
- 2.8. Эрх бүхий албан хаагчийн зөвшөөрлөөр явагдах үйл ажиллагаанд энэ журмын 2.18 дахь хэсэгт заасан шаардлагыг мөрдөж ажиллана. Ингэхдээ албан хаагчийн нэр, албан тушаалыг бүртгэж тэмдэглэнэ.
- 2.9. Цагдаагийн байгууллага болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн 107 дугаар хэсэгт заасны дагуу эрх бүхий албан тушаалтан удирдан зохион байгуулах тодорхой төрлийн таниулах ажиллагаанд цагдаагийн шадар дарга, ахлах байцаагч, байцаагч, түрүүчийн зөвшөөрлийг авсан байна.
- 2.10. Энэ журмын 2.18 дахь хэсэгт заасны дагуу таниулах ажиллагааны нийт баримт тэмдэглэлд цаг хугацаа, шийдвэр гаргагчийн гарын үсгийг тусгасан байна.
- 2.11. Албан хаагч нь баривчлах байранд бүртгэл хөтөлж ажиллахдаа шаардлагатай бүх төрлийн мэдээллийг орхигдуулахгүй байхад анхаарна. Албан хаагч, ажилтны тэмдэглэлийн дэвтэрт баривчлах байранд хөтлөгдөх баримт бичгийн маягтууд заавал байх ёстой.
- 2.12. Энэ журмын дагуу явуулах таниулах ажиллагаанд сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг этгээдийг оролцуулахад түүнийг төлөөлөх холбогдох насанд хүрсэн хүнээс зөвшөөрлийг авна. Насанд хүрээгүй этгээдийн тухайд түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр таниулах ажиллагааг явуулна. Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч зөвшөөрөл өгөхөөс татгалзсан бол таниулах ажиллагааг явуулах албан хаагч 3.21 дүгээр зүйлийн дагуу таниулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж болно (Тайлбар 2А-г үзнэ үү).
- 2.13. Хэрэв таниулах ажиллагаанд оролцогч нь сохор эсхүл харааны өөр согогтой, унших чадваргүй бол баривчлах байрны ажилтан болон

таниулах ажиллагаа явуулж байгаа албан хаагч тухайн этгээдийн ойрын төрөл садан, мэргэжилтэн, холбогдох насанд хүрсэн хүн буюу мөрдөн шалгах ажиллагаанд хамааралгүй этгээдийг оролцуулна. Хэрэв сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг этгээд бие даан тухайн ажиллагаанд оролцох боломжгүй бол энэ журмын дагуу явуулах таниулах ажиллагаанд бусдыг төлөөлөн оролцогч нь таниулах ажиллагааны баримтыг баталгаажуулж болно. Насанд хүрээгүй хүүхэд, бусад эмгэг, согогтой этгээдүүдээс бусад таниулах ажиллагаанд оролцогчдод сэжигтний өмгөөлөгчийг цагдаагийн газарт хүрэлцэн ирэхийг шаардахгүй гэдгийг энэ зүйл, заалтаар зааж өгсөн байгаа (Тайлбар 2В болон С-гийн 3.15-ыг үзнэ үү).

2.14. Насанд хүрээгүй, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг сэжигтнээс шаардлагатай мэдээлэл өгөх эсхүл авахад түүний санал болгосон холбогдох насанд хүрсэн хүнийг оролцуулна. Хэрэв сэжигтний холбогдох насанд хүрсэн хүн оролцоогүй байхад анх мэдээлэл өгсөн эсхүл авахыг хүссэн бол таниулах ажиллагааг холбогдох насанд хүрсэн хүн ирсний дараа дахин явуулна. Хэрэв сэжигтэн англи хэл мэдэхгүй, хэл ярианы чадваргүй бол орчуулагч, хэлмэрч оролцуулна.

2.15. Энэ журмын дагуу таниулах ажиллагаа явуулах тохиолдолд насанд хүрээгүй, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг сэжигтэн байж болох этгээдийн холбогдох насанд хүрсэн хүнийг заавал байлцуулна (С-гийн 1.4-ийг үзнэ үү).

2.15А Таниулах ажиллагааны явцад гэрчийг оролцуулах үед гэрч сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг, насанд хүрээгүй байх сэжиг төрвөл шүүхийн өмнөх ажиглагч мэргэжилтнийг оролцуулна. Таниулах ажиллагаанд оролцож байгаа мэргэжилтэн нь гэрчээс сэжигтнийг таниулах ажиллагаа шаардах, санал тавих эрхгүй болно (Тайлбар 2АВ-г үзнэ үү).

### 3. Нэр томъёоны лавлагаа

“Зураг авах”- хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүйгээр гэрэл зураг авах;

“Хүний зураг авах”- ажиллагааг зүй ёсоор зохион байгуулна;

“Гэрэл зураг, дүрс бичлэг, зургийн хальс, түүний хуулбарууд”- зургийн боловсруулагдсан, хадгалагдсан, баримтжуулагдсан хувиуд;

“Устгах”- гэрэл зураг мэдээллийн сангаас арчигдсан байх эсхүл зураг, мэдээллийг ашиглах боломжгүй болгох.

2.17. Зөвхөн дараах тохиолдолд энэ журмаас гадна доорх хуулийг дагаж мөрдөнө:

- (i) согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэн тээврийн хэрэгсэл жолоодсонтой холбоотой хэрэгт жолоочийн согтолтын зэргийг тогтоох амьсгаа, цус, шээсний шинжилгээ хийхэд:
  - 1988 оны Замын хөдөлгөөний хуулийн 4-11 дүгээр зүйл;
  - 1988 оны Замын хөдөлгөөн зөрчигчийн тухай хуулийн 15-16 дугаар зүйл;
  - 1992 оны Зам тээвэр, байгууламжийн тухай хуулийн 26-38 дугаар зүйлийг баримтална.
- (ii) цагаачлалын тухай 1971 оны хуулийн 2 дугаар хэсгийн, 18 дугаар зүйлийн дагуу баривчлагдсан этгээдийн гэрэл зураг, хурууны хээг авах, мөн хуулийн 16 дугаар зүйл, Цагаачлал, орогнолын тухай 1999 оны хуулийн 141, 142, 144 дүгээр зүйлийн дагуу баривчлагдсан этгээдийн гэрэл зураг, хурууны хээг авч сэжигтнийг хэн болохыг таниулах ажиллагаа явуулна.
- (iii) терроризмын тухай 2000 оны хуулийн 41, 6 дугаар зүйлүүдийн дагуу тус хуулийн 41 дүгээр зүйлд заасан үндэслэлээр баривчлагдсан, 7 мөн 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр саатуулагдсан хүнээс хурууны хээ, гэрэл зураг, бусад хэв, хэлбэр авах ажиллагааг зохицуулна (“терроризмтой холбоотой зүйл, заалтууд”) (Тайлбар 2С-г үзнэ үү).
- (iv) Эрүүгийн ба нийгмийн хэв журмыг хамгаалах тухай 1994 оны хуулийн 136.2, мөн хуулийн 137.2 дугаар зүйлийн дагуу цагдаагийн байгууллагын албан хаагчаас Шотландад баривчлагдсан болон түр саатуулагдсан хүнээс хурууны хээ, гэрэл зураг, биеийн хэв, хэлбэр, дээж авах ажиллагааг хэрэгжүүлнэ.

*Тайлбар:* Шотландын цагдаагийн газраас сэжигтэн этгээдийг баривчилсан тохиолдолд Английн Уэлсийн цагдаагийн газрын эрх мэдэл, эрх үүрэг нэгэн адил хэрэгжинэ.

2.18. Таниулах ажиллагаа явуулж байгаа албан хаагч дараах тохиолдолд өөрийн нэрийг нууцалж болно:

- (a) терроризмыг мөрдөх ажиллагааны явцад;
- (b) мөн цагдаагийн алба хаагч өөрийн нэрээр таниулах ажиллагаа явуулахад аюултай гэж үзэх үндэслэл байгаа бол алба хаагч, ажилтнууд

өөрсдийн дугаар, цагдаагийн газрын нэрийг ашиглан хүчин төгөлдөр зөвшөөрлийн дагуу таниулах ажиллагаа явуулна (Тайлбар 2D-г үзнэ үү).

2.19. Энэ журмын хүрээнд:

- (a) цагдаагийн байгууллагын шинэчлэлийн тухай 2002 оны хуульд заасны дагуу цагдаагийн алба хаагчийн эрх, үүргийг эдлэх эрхтэй “томилогдсон цагдаагийн алба хаагч” үйл ажиллагаа явуулна.
- (b) цагдаагийн алба хаагч болон томилогдсон хүний хэрэгжүүлэх эрх мэдлийн хүрээ нь түүний томилолтоор тодорхойлогдоно.

2.20. Томилогдсон хүнд хэрэв эрх олгосон бол:

- (a) цагдаагийн алба хаагчийн хүч хэрэглэх эрхийг эдэлж буй томилогдсон хүн нь тодорхой үндэслэл шаардлагын дагуу хүч хэрэглэх эрхтэй.
- (b) мөн бусдын амь нас, өмч хөрөнгө, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүч хэрэглэнэ.

2.21. Томилогдсон хүнээс бусад цагдаагийн албан хаагч хуулиар олгогдсон эрхийн дагуу үүрэг гүйцэтгэж байгаа бол энэ журамд хамаарахгүй. Томилогдсон хүний үйл ажиллагааг түр саатуулах байрны цагдаагийн алба хаагч хариуцахгүй. Цагдаагийн алба хаагч нь томилогдсон хүний үйл ажиллагаа журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. Тухайлбал, дараах зүйлийг шалгасан байх ёстой. Үүнд:

- (a) цагдаагийн байгууллагын даргын тушаалаар, тухайн удирдлагын хяналтад ажиллаж байгаа эсэх;
- (b) баривчлах болон түр албадан саатуулах үйл ажиллагаа явуулахаар цагдаагийн байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж байгаа эсэх зэрэг болно.

2.22. Томилогдсон хүн буюу цагдаагийн алба хаагчдын аль аль нь хуулийн хүрээнд журмын зүйл, заалтыг мөрдөж ажиллана.

**Удирдамж, тайлбар:**

2А Энэ журмын 2.12 дугаар зүйлийн зорилго нь таниулах ажиллагааны үед сэжигтэн, гэрчүүдийн асран хамгаалагч, эцэг эхийн зөвшөөрлийг авах, насанд хүрээгүй этгээдийн эрхийг хамгаалахад орон нутгийн болон сайн дурын байгууллагуудын оролцоог хангахад оршино.

2.14 - 2.15 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагаа явуулахад насанд хүрээгүй сэжигтнийг төлөөлөх холбогдох насанд хүрсэн хүнийг оролцуулахаар заасан ба зөвхөн энэ тохиолдолд насанд хүрээгүй сэжигтэн, түүний эцэг эх, асран харгалзагчийг 2.12 дугаар зүйлийн хүрээнд оролцуулж болно. Ингэхдээ үйл ажиллагаанд оролцоогүй эцэг эх, асран харгалзагчдаас зөвшөөрөл авахаас өмнө таниулах ажиллагааны талаар мэдээлэл олгосон байна. Тэдгээрт мөн насанд хүрээгүй сэжигтэн болон холбогдох насанд хүрсэн хүнд өгсөн сэжигтний үйлдсэн хэргийн талаар болон таниулах ажиллагааны журмын талаарх мэдээллийг өгнө. Зөвхөн зөвшөөрөл олгохоос татгалзаагүй байх тохиолдолд насанд хүрээгүй сэжигтний эцэг эх эсхүл асран хамгаалагчийг хэрэв өөрсдөө хүсвэл насанд хүрээгүй этгээд болон холбогдох насанд хүрсэн хүнтэй ярилцах боломжоор хангана.

2AB Хүүхдийн шүүх болон нотлох ажиллагааны тухай 1999 оны хуулийн дагуу эмзэг гэрчийг таниулах ажиллагаанд оролцуулах тохиолдолд зөвхөн шүүхийн өмнөх туслах мэргэжилтнийг байлцуулан таниулах ажиллагаа явуулна. Таниулах ажиллагаанд оролцож байгаа мэргэжилтэн нь хэргийн гэрч нь (гэрч нь байх магадлалтай) байж болохгүй.

2B Харааны бэрхшээлтэй, унших чадваргүй этгээдүүд хэргийн баримттай танилцаж, баталгаажуулах болсон үед түүний өмнөөс өмгөөлөгчийг оролцуулж гарын үсэг зуруулна. Энэ нь хэргийн оролцогчдын (цагдаа, сэжигтэн) эрхийг хамгаалах зорилготой юм.

2C Терроризмын тухай хуулийн дагуу сэжигтнийг баривчлах үед түүнээс хурууны хээ, гэрэл зураг, бусад хэв, хэлбэр, дээж авах нь тухайн этгээдийг сэжиглэх үндэслэлийг тодорхойлоход ач холбогдолтой.

2D Энэ журмын 2.18 дугаар зүйлийн зорилго нь ноцтой, зохион байгуулалттай гэмт хэрэгт мөрдөлт явуулах, хүч хэрэглэн эсэргүүцсэн сэжигтнийг баривчлах ажиллагаатай холбоотойгоор алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, таниулах ажиллагаа явуулах удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэн заавар зөвлөгөө өгөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино. Цагдаагийн алба хаагч таниулах ажиллагаа явуулах дээрх тохиолдлуудад байцаагч, түүнээс дээш албан тушаалтан зөвлөж ажиллана.

### 3. Гэрчийг таниулах ажиллагаанд оролцуулах

3.1. Хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл өгч, сэжигтнийг тодорхойлж чадах гэрчийн туслалцаатайгаар сэжигтнийг тогтоож тэмдэглэл үйлдэнэ.

а. тэмдэглэлд гэрчид эрх, үүргийг нь сануулсан тухай, гэрчийн мэдүүлсэн сэжигтний гадаад төрх, онцлог, содон шинж тэмдгийг магадлан тодруулсан талаар тусгана.

б. тэмдэглэлийг энэ журмын 3.5, 3.10, 3.21, 3.23 дугаар зүйлд заасны дагуу гэрчийг таниулах ажиллагаанд оролцуулж, сэжигтнийг таньж олуулахаас өмнө үйлдэнэ.

Энэ журмын 3.5, 3.10, 3.21, 3.23 дугаар зүйлд заасны дагуу гэрчийг таниулах ажиллагаанд оролцуулж, сэжигтнийг таньж олуулахаас өмнө сэжигтэн болон түүний төлөөлөгчид тэмдэглэлийн хувийг өгсөн байна (Тайлбар ЗЕ-г үзнэ үү).

#### **(а) Сэжигтэн тодорхойгүй үед таниулах ажиллагаа явуулах**

3.2. Сэжигтэн тодорхойгүй байгаа боловч гэрч нь сэжигтнийг урьд нь харсан учраас таньж олох боломжтой гэж мэдүүлсэн бол журмын 3.5 - 3.10 дугаар зүйлийг баримтлан гэрчийг тодорхой газар аваачин сэжигтнийг таних эсэхийг шалгах таниулах ажиллагаанд албан ёсоор оролцуулна. Ингэхдээ дараах зүйлд анхаарна.

(а) боломж бүхий үед, 3.1(а) зүйлийн дагуу таниулах ажиллагааг явуулахаас өмнө гэрч сэжигтний дүр төрхийг тодорхойлсон, холбогдох бусад мэдээллийг өгсөн, баримт сэлт гаргаж ирсэн байх.

(б) таниулах ажиллагааны явцад гэрчийг удирдаж болохгүй бөгөөд харин тодорхой чиглэлээр харах эсхүл тодорхой хэсэг бүлэг хүмүүсийг ажиглах хүсэлт тавих зэрэг аргаар сэжигтэнтэй нүүр тулсан гэрч таньж олохоос зайлсхийх, сэжигтнийг анзаарахгүй өнгөрөх зэргээс сэрэмжилж болно. Гэрч нь сэжигтэн болон таньж олуулах ажиллагаанд оролцож байгаа бусад хүмүүсийг анхааралтай ажиглаж харьцуулалт хийх боломжийг таниулах ажиллагаа явуулах үед бүрэн хангасан байна (Тайлбар ЗF-ийг үзнэ үү).

(с) нэгээс илүү гэрч байгаа тохиолдолд тэдгээрийг хамтад нь таниулах ажиллагаанд оролцуулж болохгүй бөгөөд тус бүрийг нь сэжигтнийг таньж олох боломжоор хангана.

(д) гэрчийг таниулах ажиллагаанд оролцуулсны дараа сэжигтнийг баривчлах хангалттай үндэслэл байгаа гэх тохиолдолд бусад

гэрчүүдийг 3.4 дүгээр зүйлээс хойших зүйлүүдийн дагуу таниулах ажиллагаанд оролцуулна.

(е) цагдаагийн алба хаагч, ажилтан нь таниулах ажиллагааны үед гэрчтэй хамт байж тэмдэглэлийн дэвтэртээ тэмдэглэл хийнэ. Тухайн тэмдэглэлд хэрэгт ач холбогдолтой цаг хугацаа, газар, гэрч сэжигтнийг таньсан эсэх, хэрхэн таньсан зэргийг тусгана. Гэрч нь сэжигтнээс ямар зайд байсан, тухайн үеийн цаг агаарын байдлыг мөн тэмдэглэлд тусгана. Сэжигтнийг таниулахын тулд гэрчийг чиглүүлсэн эсэх, энэ тохиолдолд үүний үндэслэлийг тодруулах бөгөөд таниулах ажиллагааны үйл явц, процедурын талаар гэрч, сэжигтнээс мэдүүлсэн зүйлсийг аль алиныг нь тэмдэглэнэ.

3.3. Хэрэв цагдаагийн байгууллага сэжигтнийг таних бол гэрчид сэжигтний гэрэл зураг, аман зураг, гэрэл зургийн эвлүүлэг зэргийг таниулах ажиллагаанд ашиглах шаардлагагүй бөгөөд гэрчийг шууд бүлгээр тогтоох болон эгнээгээр тогтоох, дүрс бичлэгээр таниулах ажиллагаанд оролцуулна. Сэжигтэн тодорхойгүй үед Хавсралт Е-ийн дагуу сэжигтний гэрэл зураг, аман зураг, гэрэл зургийн эвлүүлэг зэргийг гэрчид үзүүлж, таниулах ажиллагаанд ашиглана.

### **(в) Сэжигтэн тодорхой үед таниулах ажиллагаа явуулах**

3.4. Сэжигтэн тодорхой бөгөөд таниулах ажиллагаанд оролцох боломжтой үед таниулах ажиллагаа явуулахад 3.5-3.10 дугаар зүйлийг мөрдөнө. Сэжигтэн “тодорхой” байх гэдэг нь цагдаагийн байгууллага уг сэжигтнийг холбогдох хэрэгт оролцсон нь нотлогдон, түүнийг баривчлах хангалттай үндэслэл байгаа гэж үзсэн хэрэг юм. Сэжигтэн “таниулах ажиллагаанд оролцох боломжтой” гэдэг нь сэжигтэн таниулах ажиллагаанд шууд оролцох боломжтой эсхүл богино хугацаанд ирж доорх таниулах үйл ажиллагааны наанадаж нэг ажиллагаанд идэвхтэй оролцох хүсэл эрмэлзэлтэй байна гэсэн үг юм:

- дүрс бичлэгээр тогтоох;
- эгнээгээр тогтоох;
- бүлгээр тогтоох.

*Дүрс бичлэгээр таниулах ажиллагаа*

3.5. Дүрс бичлэгүүдийг үзүүлж өөр ижил төстэй хүмүүсийн хамт авхуулсан дүрс бичлэгээс сэжигтнийг гэрчээр шууд таниулахыг дүрс бичлэгээр таниулах ажиллагаа гэнэ.

Сэжигтний дүр төрх тодорхойгүй үед дүрс бичлэгээр таниулах ажиллагааг ашиглаж болохгүй (Энэ журмын 3.21-ийг үзнэ үү).

Хавсралт А-гийн 2А-гийн дагуу таниулах ажиллагааны үед цагдаагийн алба хаагч гэрчид үзүүлэх дүрс бичлэгийн аль нэг хэсэг газрыг үзүүлэхгүй байх шаардлага байх эсхүл сэжигтний дүрс дээрх содон шинж тэмдгийг халхалж болохгүй байх тохиолдолд дүрс бичлэгийг хөдөлгөөнтэй бусаар буюу тодорхой зураг хэсгүүдийг гэрчид үзүүлнэ.

3.6. Дүрс бичлэгээр таниулах ажиллагаа явуулахдаа Хавсралт А-г баримтална.  
*Эгнээгээр (парад) таниулах ажиллагаа явуулах*

3.7. Таниулах ажиллагаанд оролцуулахаар сонгож авсан сэжигтэнтэй дүр төрх төстэй хүмүүстэй хамт сэжигтнийг нэг шугамд зогсоож гэрчээр таниулахыг эгнээгээр таниулах ажиллагаа гэнэ.

3.8. Энэ ажиллагааг Хавсралт А-ийн дагуу хэрэгжүүлнэ.

*Бүлгээр таниулах ажиллагаа*

3.9. Урьдчилан сонгоогүй хүмүүсийн дунд сэжигтнийг оруулж гэрчээр таниулахыг бүлгээр таниулах ажиллагаа гэнэ.

3.10. Энэ ажиллагааг Хавсралт С-ийн дагуу хэрэгжүүлнэ.

*Таниулах ажиллагааны зохион байгуулалт*

3.11. Энэ журмын 3.19 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд буюу 3.5 - 3.10 дугаар зүйлд заасан таниулах ажиллагааг мөрдөх ажиллагаанд оролцоогүй байцаагч түүнээс дээш эрх бүхий алба хаагчийн удирдлага дор явуулна. Үүнийг таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч гэж нэрлэнэ. Өөрөөр заагаагүй бол таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч өөр өөр алба хаагч эсхүл цагдаагийн ажилтныг авч, таниулах ажиллагааг 2.21 дүгээр зүйлийн дагуу явуулж болно. Өөрийн эрх мэдлийг шилжүүлэхдээ таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч ажиллагааг хянах ба шаардлагатай үед зөвлөгөө өгч байх ёстой. Мөрдөх ажиллагаанд оролцож буй цагдаагийн алба хаагч эсхүл өөр ажилтан таниулах ажиллагаанд оролцох ба таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчаар томилогдож болохгүй. Харин энэ нь таниулах ажиллагааны процедурыг сонгоход мөрдөн шалгах ажиллагааны мөрдөгчөөс зөвлөгөө авахад хамаарахгүй. Таниулах ажиллагаа явуулах шаардлага үүссэн тохиолдолд процессыг гэрч болон сэжигтний хувьд шударга байлгах үүднээс таниулах ажиллагааг аль болох цаг алдалгүй, богино хугацаанд, түргэн шуурхай явуулах ёстой.



*Таниулах ажиллагааг заавал явуулах*

3.12. Дараах тохиолдлуудад таниулах ажиллагааг заавал явуулна:

- сэжигтнийг гэрч таних боломжтой гэдгээ илэрхийлсэн тохиолдолд энэ журмын 3.5 - 3.10 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагааг заавал явуулна эсхүл сэжигтнийг таних гэрч байх ба тэр гэрч нь сэжигтнийг таних боломжтой гэдгээ илэрхийлсэн байх бөгөөд сэжигтнийг таниулах ажиллагаанд урьд өмнө 3.5 - 3.10 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагаанд оролцуулаагүй байх;
- сэжигтэн нь гэрчийн мэдүүлэгтэй санал нийлэхгүй байх бөгөөд сэжигтэн гэмт хэрэгт оролцсон эсэхэд үүссэн эргэлзээг арилгах шаардлага байхгүй байх бусад тохиолдолд таниулах ажиллагааг заавал явуулна.

3.13. Үүний адил мөрдөх ажиллагааг хариуцсан албан хаагч таниулах ажиллагаа явуулах нь ашиг тустай гэж үзсэн тохиолдолд таниулах ажиллагааг заавал явуулна.

*Таниулах ажиллагааг сонгож явуулах*

3.14. Энэ журмын 3.12 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагааг заавал явуулах тохиолдолд сэжигтэнд дүрс бичлэгээр таниулах ажиллагаа явуулахыг санал болгож болно. Хэрэв:

- (a) дүрс бичлэгээр таниулах ажиллагаа явуулах нь тохиромжгүй;
- (b) дүрс бичлэгээр таниулах ажиллагаанаас эгнээгээр таниулах ажиллагаа нь илүү ач холбогдолтой бол;
- (c) 3.16 дугаар зүйлийг мөрдөж ажиллах бол таниулах ажиллагаа явуулах алба хаагч мөрдөх ажиллагаа явуулж буй мөрдөгчтэй зөвлөлдөж чухам ямар төрлийн таниулах ажиллагаа явуулах шаардлага байгааг өөрсдөө тодорхойлно. Гэрчээс шалтгаалж (гэрчийн тоо, эрүүл мэндийн байдал, оролцох бололцоо, алсаас зорчих гэх мэт) эгнээгээр (парад) таниулах ажиллагаа явуулах боломжгүй бөгөөд эгнээгээр таниулах ажиллагаа явуулахаас хурдан зохион байгуулж хэрэгжүүлэх боломжтой бол дүрс бичлэгээр таниулах ажиллагаа явуулах нь тохиромжтой байж болно.

3.15. Сэжигтэн, түүний өмгөөлөгч, холбогдох насанд хүрсэн хүн тухайн таниулах ажиллагаанд оролцохоос татгалзсан тохиолдолд шалтгааныг асууж тодруулан, тэд чухам ямар учраас өөр таниулах ажиллагааг сонгож буйг тайлбарлуулан тэмдэглэлд тусгасан байх шаардлагатай. Хэрэв таниулах ажиллагаа явуулах эрх бүхий албан хаагч аль нэг өөр таниулах ажиллагааг

сэжигтэн болон түүний өмгөөлөгчид санал болгох шаардлагагүй гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгаж баталгаажуулна.

3.16. Мөрдөх ажиллагаа хариуцсан алба хаагч бүлгээр таниулах ажиллагааг дүрс бичлэгээр тогтоох, эгнээгээр таниулах ажиллагаанаас илүү ач холбогдолтой гэж үзвэл мөн таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч энэ ажиллагааг үр ашигтай гэж үзвэл тухайн таниулах ажиллагааг сонгож, зохион байгуулах арга хэмжээг авна.

*Сэжигтэнд танилцуулах зүйлс*

3.17. Энэ журмын 3.20 дугаар зүйлээс бусад тохиолдолд бүлгээр тогтоох, эгнээгээр тогтоох, дүрс бичлэгээр таниулах ажиллагааг зохион байгуулж явуулахаас өмнө сэжигтэнд дараах зүйлийг тайлбарлаж өгнө. Үүнд:

- (i) эдгээр ажиллагааны зорилго;
- (ii) гэрчийн хууль зүйн туслалцаа авах эрх (С-ийн 6.5 дугаар зүйлийг үзнэ үү);
- (iii) таниулах ажиллагаанд төлөөлөгч, найз нөхдөө оролцуулах эрх;
- (iv) таниулах ажиллагаанд оролцохоос татгалзах эрхийн тухай;
- (v) сэжигтэн бүлгээр тогтоох, эгнээгээр тогтоох, дүрс бичлэгээр таниулах ажиллагаанд оролцохыг зөвшөөрөөгүй бол энэ байдал нь шүүх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох тухай тайлбарлана. Таниулах ажиллагааг цагдаа нууцаар явуулж болох ба эсхүл гэрч сэжигтнийг нотолж чадах өөр таниулах ажиллагаа зохион байгуулах (3.21 дүгээр зүйлийг үзнэ үү);
- (vi) дүрс бичлэг урьд өмнө нь олдсон бол 3.20 дугаар зүйлийг үзнэ үү, сэжигтэнд тухайн дүрс бичлэгээс илүү тохиромжтой зүйл санал болгож болох тухай сануулах;
- (vii) шаардлагатай гэж үзэх тохиолдолд насанд хүрээгүй этгээдэд зориулсан тусгай арга хэмжээ авах;
- (viii) сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн, сэтгэцийн хувьд эмзэг хүмүүс оролцож буй бол таниулах ажиллагааны үед тусгайлсан зохион байгуулалт хийж болох тухай;
- (ix) таниулах ажиллагаа явуулахаас өмнө сэжигтэн гадаад төрхдөө их хэмжээний өөрчлөлт оруулах оролдлого хийх нь хожим шүүх ажиллагаанд нотлох баримт болох тухай, ингэх тохиолдолд таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч өөр таниулах ажиллагаа сонгож болно (3.21 дүгээр зүйл болон Тайлбар ЗС-г үзнэ үү);

- (x) таниулах ажиллагаа явуулж буй үед сэжигтний дүрс бичлэг эсхүл фото зургийг авах болно гэдгийг сануулах;
  - (xi) тухайн таниулах ажиллагааг явуулахаас өмнө гэрч нь сэжигтний аман зураг, гэрэл зураг, гэрэл зургийн эвлүүлгийг үзсэн тухай (Тайлбар ЗВ-г үзнэ үү);
  - (xii) таньж олуулах ажиллагаанаас өмнө сэжигтэн гадаад төрхөө өөрчлөх бол таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч бусад аргыг хэрэглэх болно (Тайлбар ЗС-г үзнэ үү);
  - (xiii) дүрс бичлэг, бүлгээр, эгнээгээр болон нүүрэлдүүлэх таниулах ажиллагаанд оролцох гэрч сэжигтнийг хэрхэн таньсан тухай сэжигтний тодорхойлолтыг сэжигтэн, түүний төлөөлөгчид танилцуулна (3.1 дүгээр зүйлийг үзнэ үү);
- 3.18. Дээрх зүйлсийг тайлбарласны дараа бичгээр үйлдэж сэжигтэнд уншуулна. Сэжигтэн нь таниулах ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн бол таниулах ажиллагааны тэмдэглэлийн хуулбарт гарын үсэг зуруулна. Таниулах ажиллагаа явуулах эрх бүхий албан хаагч гарын үсэг зурсан тэмдэглэлийн хуулбарыг авч үлдэнэ.
- 3.19. Журмын 3.17, 3.18 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагааг хорих байрны алба хаагч эсхүл мөрдөн шалгах ажиллагаанд оролцоогүй өөр алба хаагч явуулж болно, хэрэв:
- (a) таниулах ажиллагааг зохион байгуулах, явуулахаас өмнө сэжигтнийг суллах санал гарсан ба суллагдахаас өмнө нь таниулах ажиллагаа явуулах алба хаагчийг орлох албан тушаалтан байгаагүй бол 3.11 дүгээр зүйлийг үзнэ үү.
  - (b) таниулах ажиллагааг зохион байгуулах, явуулах үед сэжигтнийг баривчлах байранд үлдээхээр шийдэх ба таниулах ажиллагаа явуулах алба хаагчийг орлох байцаагчийг хүлээх нь тохиромжгүй гэх тохиолдолд 3.11 дүгээр зүйлийг үзнэ үү.
- Дээрх ажиллагааг явуулсан алба хаагч энэ тухайгаа таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчид мэдэгдэж, баталгаажуулсан тэмдэглэлийн хувийг өгнө (ЗС-г үзнэ үү).
- 3.20. Таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч болон мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан хаагчдад энэ журмын 3.17, 3.18 дугаар зүйлийн дагуу сэжигтэнд мэдэгдэл өгвөл сэжигтэн нь таниулан тогтоох бүхий л ажиллагааны үед гэрчид харагдахгүй болох арга хэмжээ авах

болно гэсэн үндэслэл бүхий сэжиг байх тохиолдолд таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч сэжигтний дүрс бичлэгийг мэдээлэл өгөх болон мэдэгдлийг олгохоос өмнө олж авсан байна. Хэрэв сэжигтний дүрсийг ийм тохиолдолд олж авсан бол сэжигтэн нь дүрс бичлэгээр таниулах ажиллагааны үед хамтран ажиллах үүднээс уг ажиллагаанд ашиглаж болохуйц өөр зураг өгч болно (3.17 дугаар зүйлийг үзнэ үү).

### **(с) сэжигтэн тодорхой боловч олдохгүй байх үед**

- 3.21. Сэжигтэн тодорхой боловч олдохгүй байгаа үед (3.4 дүгээр зүйлийг үзнэ үү) таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч дүрс бичлэгээр таниулах ажиллагаа явуулж болно (Хавсралт А-г үзнэ үү). Дүрс бичлэгээр таниулах ажиллагаанд зурган буюу хөдөлгөөнт бус дүрс ашиглахыг зөвшөөрнө. Шаардлага хангах ямар ч гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглаж болох ба шаардлагатай бол гэрэл зураг, дүрс зургийг нууцаар олж авсан байж болно. Мөн нөхцөл бүрдсэн тохиолдолд албан хаагч бүлгээр таниулах ажиллагааг сонгож авсан байж болно (Тайлбар 3D-г үзнэ үү). Энэ зүйлийн зохицуулалтыг насанд хүрээгүй этгээдийн эцэг эх эсхүл асран хамгаалагч таниулах ажиллагаанд оролцуулах зөвшөөрөл өгөхөөс татгалзсан эсхүл зөвшөөрөл авах ажиллагаа бүтэлгүйтсэн тохиолдлуудад мөн хэрэглэнэ (2.12 дугаар зүйлийг үзнэ үү).
- 3.22. Сэжигтнийг гэрч таньж чадах эсэхийг сорихдоо маш болгоомжтой хандаж нууц ажиллагааг хязгаарлах шаардлагатай.
- 3.23. 3.5, 3.10, 3.21 дүгээр зүйлийг хэрэглэх нь ач холбогдолгүй гэх тохиолдолд таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч сэжигтнийг гэрчтэй нүүрэлдүүлж болно. Энэ тохиолдолд сэжигтнийг гэрчтэй шууд уулзуулан нүүрэлдүүлнэ гэсэн үг. Нүүрэлдүүлэн байцаахад сэжигтний зөвшөөрлийг шаардахгүй бөгөөд нүүрэлдүүлэх ажиллагааг Хавсралт D-ийн дагуу хэрэгжүүлнэ.
- 3.24. Сэжигтэн нь таниулан тогтоох аливаа ажиллагааны үед хамтран ажиллах хүсэл эрмэлзэлгүй байх тохиолдолд таниулах ажиллагаанаас өмнө сэжигтнээс мэдээлэл хүсэх эсхүл түүнд мэдээлэл өгөх, дүрс зургийг гэрчид үзүүлэхээс өмнө үзэх боломж олгох шаардлагуудыг таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч хэрэгжүүлэхгүй байж болно.

**(d) Баримтжуулалт**

- 3.25. Нүүрэлдүүлэх, дүрс бичлэгээр тогтоох, эгнээгээр тогтоох, бүлгээр тогтоох зэрэг таниулах ажиллагааны үйл явцыг тусгай зориулалтын анкетад тэмдэглэж баталгаажуулна.
- 3.26. Сэжигтний хүсэлтийн дагуу таниулах ажиллагаа явуулж буй албан хаагчийн шийдвэрээр дүрс бичлэгээр тогтоох, эгнээгээр таниулах ажиллагааг явуулах нь тохиромжгүй гэж үзвэл энэ талаар тэмдэглэлд тусгаж, сэжигтэнд тайлбарлаж өгсөн байна.
- 3.27. Тэмдэглэлд дүрс бичлэгээр тогтоох, эгнээгээр тогтоох, бүлгээр таниулах ажиллагаанд хувь хүн оролцохоос татгалзсан талаар, мөн боломжтой бол 3.20 дугаар зүйлийн дагуу дүрс зургийг цуглуулах болсон үндэслэлийг тэмдэглэнэ.

**(e) Хэвлэл мэдээллээр түгээсэн үйл явдлын гэрэл зураг, дүрс бичлэг, мэдээллийг үзүүлэх**

- 3.28. Хэргийг мөрдөж сэжигтнийг тогтоох зорилгоор цагдаагийн алба хаагч, хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээсэн гэрэл зураг, дүрс бичлэгийг үзүүлж болно. Ингэхдээ тухайн гэрэл зураг, бичлэгийг гэрч болон цагдаагийн алба хаагч гэрчид (Тайлбар ЗА-г үзнэ үү) үзүүлэхдээ үгсэх эрсдэлээс зайлсхийх үүднээс эдгээр баримтыг тус тусад нь үзүүлнэ. Хэрэв сэжигтэн тодорхой байгаа бол дүрс бичлэгээр таниулах ажиллагаа, тодорхой бус байгаа бол гэрэл зургаар таниулах ажиллагаа явуулна (Тайлбар А, Е-г тус тус үзнэ үү).
- 3.29. 3.28 дугаар зүйлд заасан зорилгын дагуу олон нийтэд цацагдсан мэдээллийг гэмт хэргийн мөрдөлтөд ашиглах зорилгоор хадгалж үлдээнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан дээрх материалыг үзүүлэх нь мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулах үндэслэл байхгүй гэх тохиолдолд эдгээр материалыг сэжигтэн, түүний төлөөлөгчид 3.5-3.10, 3.21, 3.23 дугаар зүйлийн дагуу явуулах үйл ажиллагаа эхлэхээс өмнө үзүүлсэн байна. Тухайн хэргийн гэрчүүдээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл, хэргийн тухай зураг эсхүл сэжигтний тодорхойлолтыг үзсэн эсэхийг асууж хариултыг тэмдэглэж авна. Эрүүгийн хууль сахиулах тухай 1996 оны хуулийн дагуу эрүүгийн мөрдөлтийн явцад олж тогтоосон материалуудыг тусгаарлах шаардлагад энэ журам нөлөөлөхгүй.

**(f) Таниулах ажиллагааны явцад олж авсан болон ашигласан зургийг хадгалах болон устгах**

- 3.30. PACE-ийн 64A дугаар хэсэг, 5.12-ыг үзнэ үү. Энэ зүйл, заалтын дагуу сэжигтний гэрэл зургийг авах, ашиглах нь зөвхөн Нэгдсэн вант улсын дотоод, гадаадад хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөлт явуулах, гэм буруутайд тооцох зорилгоор хийгдэнэ. Мөрдөлт, таниулах ажиллагааны явцад олж авсан гэрэл зургийг мөн зорилгоор хадгалж болно.
- 3.31. 3.5 - 3.10, 3.21, 3.23 дугаар зүйлийн дагуу таниулах ажиллагаанд зориулж энэ журмын 5.12 дугаар зүйлд заасан журмын дагуу бусаар авсан гэрэл зургийг (хальс бусад хуулбарыг) доорх байдал үүсээгүй тохиолдолд устгаж болно. Үүнд сэжигтэн нь:
- (a) гэмт хэрэгт яллагдсан ба яллагдах нь илэрхий болсон, харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэг байсан;
  - (b) харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт яллагдсан;
  - (c) гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын тухай 1988 оны хуулийн дагуу харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт буруутгагдан анхааруулга авсан;
  - (d) 3.30 дугаар зүйлд заасан зорилгоор гэрэл зураг, дүрсийг хадгалах зөвшөөрөл өгсөн.
- 3.32. 3.31 дүгээр зүйлийг таниулах ажиллагааны явцад авсан гэрэл зургийг устгахад гэрч байлцуулж, тухайн устгах ажиллагааг баримтжуулна. Шаардлагатай тохиолдолд тав хоногийн дотор устгасан болохыг мэдэгдэнэ.
- 3.33. Эрүүгийн хууль сахиулах тухай 1996 оны хуулийн дагуу гэмт хэргийн мөрдөлтийн явцад цуглуулсан материалыг тусгаарлах шаардлагад энэ журам нөлөөлөхгүй.

**Удирдамж, тайлбар**

3А Тайлбар E-ийн 1 дүгээр зүйлээс бусад тохиолдолд цагдаагийн алба хаагчаас журмын энэ зүйлд заасан зорилгоор гэрчийг таниулах ажиллагаанд урьж оролцуулахдаа иргэний гэрчийг оролцуулах зарчим, хэм хэмжээг баримтална.

3В Таниулах ажиллагаанд гэрчийг оролцуулахаас өмнө аман зураг, гэрэл зураг, бусад дүрсийг урьдчилан үзүүлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг хариуцаж буй мөрдөгч энэ байдлын талаарх мэдээллийг таниулах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчид мэдэгдэх үүрэгтэй.

ЗС 3.19 дүгээр зүйлийн зорилго нь таниулах ажиллагааны үед шаардлагатай мэдээллийг өгч, хууль сануулах, таниулах ажиллагаанаас зайлсхийх, хойшлуулах боломжийг бий болгохгүй байхад оршино (3.17(ix), 3.17(xii) дэд зүйлүүдийг үзнэ үү).

ЗD Таниулах ажиллагаанд сэжигтэн нь санаатайгаар саад учруулах, бүтэлгүйтүүлэх зорилготой болохыг мэдсэн тохиолдолд 3.21 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. Мөн сэжигтэн нь таниулах ажиллагаанд оролцохоос татгалзсан тохиолдолд энэ зүйл хэрэглэгдэх бөгөөд уг ажиллагааны явцад олж авсан ямар ч дүрс бичлэг, гэрэл зургийг таниулах ажиллагаанд ашиглахыг зөвшөөрнө. Тухайлбал, CCTV, цагдан хорих байрнаас авсан бичлэг, ярилцлагын бичлэг зэргийг ашиглана (Журам F-ийн Тайлбар 2D-г үзнэ үү).

ЗE Тайлбар E-ийн дагуу гэрчид зураг үзүүлэхийг санал болгосон тохиолдолд гэрч нь сэжигтнийг анх хэрхэн тодорхойлсон талаар баримтжуулж авсан мэдээллийг мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч таниулах ажиллагаа явуулах алба хаагчид өгөх үүрэг хүлээнэ. Гэрчийн анхны тодорхойлолтыг баримтжуулаагүй тохиолдолд Хавсралт E-ийн дагуу явуулах үйл ажиллагааг хойшлуулна (Хавсралт E-ийн 2 дугаар зүйлийг үзнэ үү).

ЗF Доорх нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд 3.2 дугаар зүйлд заасан ажиллагааг хэрэгжүүлэх үед таниулах ажиллагаанд ашиглах нотлох баримтыг хүлээж авах боломжгүй болох эсхүл тэдгээрийн ач холбогдол буурна. Үүнд:

- (a) гэрч таниулах ажиллагаа эхлэхээс өмнө сэжигтнийг шууд заасан бол;
- (b) таниулах ажиллагаа эхлэхээс өмнө сэжигтэн нь тодорхой болох.

#### 4. Хурууны хээ, хөлийн (гутлын) мөрөөр таниулах ажиллагаа явуулах

(A) Мөрдөлтийн явцад хурууны хээ авах

##### (a) Ерөнхий хэсэг

4.1. Таниулах ажиллагааны явцад тухайн хүний бие махбодын онцлогоос шалтгаалсан шинж тэмдгийг тодорхойлох зорилгоор:

- (i) хурууны;
- (ii) эсхүл алганы хээг тус тус авна.

**(b) Үйл ажиллагаа**

- 4.2. Гэмт хэргийг мөрдөх явцад хувь хүний хурууны хээг түүний зөвшөөрлөөр эсхүл 4.3 дугаар зүйлд заасны дагуу бэхжүүлж авна. Цагдаагийн газарт байгаа хүн хурууны хээ өгөх зөвшөөрлөө бичгээр өгнө.
- 4.3. Цагдаагийн байгууллага болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн 61 дүгээр хэсэг нь 10 наснаас дээш хүнээс зөвшөөрөлгүйгээр хурууны хээ авах эрх олгодог.
- (a) харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдаж цагдаагийн газар саатуулагдаж байгаа хүнээс хурууны хээ авахад 61(3) дугаар зүйлийг баримтална (Тайлбар 4а-г үзнэ үү). Мөрдөлтийн явцад урьдчилан авсан хурууны хээг илрүүлсэн бөгөөд энэ нь харьцуулах шинжилгээнд оруулахад чанар хангахуйц байх ёстой.
- (b) цагдаагийн газар саатуулагдсан этгээд харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт яллагдсан бол хурууны хээ авах ажиллагааг 61(4) дүгээр зүйлд заасны дагуу явуулна (Тайлбар 4а-г үзнэ үү). Мөрдөлтийн явцад хурууны хээг илрүүлсэн, энэ нь харьцуулах шинжилгээнд оруулахад чанар хангаагүй бол энэ талаар мэдэгдсэн байна.
- (c) шүүх болон цагдаагийн газарт байгаа батлан даалттай хүнээс доорх тохиолдлуудад хурууны хээ авах ба 61(4А) дүгээр зүйлд заасныг баримтална:
- (i) батлан даалтад буй хүн нь урьдчилан хурууны хээ авсан хүн биш болох үндэслэл бүхий сэжиг байх;
- (ii) батлан даалтад буй хүн нь хурууны хээг урьдчилан өгсөн хүн биш болохыг мэдэгдсэн. Хурууны хээг байцаагч, түүнээс дээш албан тушаалын эрх хэмжээ бүхий алба тушаалтны зөвшөөрлөөр авна.

**(d) 61.6 дугаар зүйлийн дагуу:**

- (i) харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт холбогдсон;
- (ii) харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт хэрэгт анхааруулга өгсөн, анхааруулгыг тухайн этгээд зөвшөөрсөн;
- (iii) гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын тухай 1988 оны хуулийн 65 дугаар хэсгийн дагуу харьяаллын дагуу бүртгэж, баримтжуулбал зохих гэмт



хэрэгт анхааруулга өгч байсан бол хурууны хээг зөвшөөрөлгүйгээр авна.

4.4. Цагдаагийн байгууллага болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу дараах эрх мэдлийг олгодог.

(a) 4.3 (d)-д заасан этгээдийн хурууны хээг цагдаагийн газарт авна. Үндэслэл нь:

(i) хэрэгт холбогдсон этгээдийг баривчлаагүй, мөрдөлтийн явцад түүний хурууны хээг аваагүй бол;

(ii) мөрдөлтийн явцад олж авсан хурууны хээ харьцуулах шинжилгээний шаардлага хангахгүй бол.

(b) тухайн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан хүнийг зөвшөөрөлгүйгээр баривчлах.

Тайлбар: Тухайн шаардлага нь гэмт хэрэгт яллагдсан, анхааруулга, сануулга авсан этгээдэд нэг сарын хугацаанд хийгдсэн байх ёстой бөгөөд энэ хугацаа нь хамгийн багадаа долоо хоног байвал зохино.

4.5. Хурууны хээг цахим хэлбэрээр авч болно.

4.6. Зайлшгүй тохиолдолд хувь хүний хурууны хээг түүний зөвшөөрөлгүйгээр авах бол 4.3, 4.4 дүгээр зүйлийг баримтална. Ингэхдээ албадлага хэрэглэсэн байж болно.

4.7. Хурууны хээг зөвшөөрөлтэйгөөр эсхүл зөвшөөрөлгүйгээр авах тохиолдолд хувь хүнд дараах зүйлийг мэдэгдсэн байна. Үүнд:

(a) Хурууны хээ авч байгаа шалтгаан;

(b) 4.3 дугаар зүйлийн дагуу хурууны хээ авах тохиолдолд тухайн байгууллагад ингэх зөвшөөрөл олгосон үндэслэлийг тайлбарлах;

(c) өгсөн хурууны хээг санд байгаа бусад хээтэй харьцуулах зорилгоор авч байгаа тухай (Тайлбар 4В-г үзнэ үү), тухайн хурууны хээг устгах бол Хавсралт F-ийн (a)-г баримтална.

(d) хэрэв тухайн хурууны хээ заавал устгагдсан байх шаардлагатай бол Хавсралт F-ийн (a)-д заасны дагуу уг ажиллагаанд хурууны хээг эзнийг нь оролцуулан устгах ажиллагааг баталгаажуулж болно.

**(с) Баримтжуулалт**

- 4.8. Хурууны хээг зөвшөөрөлгүйгээр авах тохиолдолд үүний үндэслэл, шаардлагыг тэмдэглэлд тусгана. Хэрэв энэ үйл ажиллагааны үед албадлага хэрэглэсэн бол тухайн үед албадлага хэрэглэх болсон шалтгаан, нөхцөл байдал, байлцсан этгээдүүдийн нэрийг тэмдэглэлд тодорхой тусгана.
- 4.9. 4.7 дугаар зүйлд тусгагдсан зүйлсийг хувь хүнд мэдээлэх үед тэмдэглэлийг хөтөлж эхлэх бөгөөд хурууны хээг харьцуулах магадлалтай байгааг тайлбарлаж тэмдэглэлд тусгана.

## ХАВСРАЛТ 2

### КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАСАГТ ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙГАА ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГИЙН ЦҮНХ, БАГАЖ

Хэргийн газрын үзлэгийн цүнх, хэргийн газрын үзлэгт ашиглагдах багаж, хэрэгсэл



*Зураг 1. Хэргийн газрын үзлэгийн шинжээчийн цүнхнүүд*

Хэргийн газрын үзлэгийн цүнхэнд дараах багаж, хэрэгсэл багтсан байна.

#### **1. Мөр илрүүлэх хэрэгсэл:**

##### 1.1. Гэрэлтүүлэх хэрэгсэл:

- Зөөврийн гэрэл;
- Хэт ягаан туяаны гэрэл.

##### 1.2. Хараа зүйн багаж хэрэгсэл:

- Өгсгөгч линз

##### 1.3. Химийн урвалж бодис:

- Ердийн нунтаг;
- Соронзон нунтаг;
- Спирт;
- Супер цавуу;
- Биологи, химийн гаралтай мөр илрүүлэх бодис, уусмал.

1.4. Багс:

- Төрөл бүрийн багс (өргөн, нарийн, зөөлөн үслэг);
- Соронзон багс.

**2. Мөр бэхжүүлэх хэрэгсэл:**

2.1. Гэрэл зургийн хэрэгсэл:

- Фото аппарат, түүний дагалдах хэрэгсэл

2.2. Тэмдэглээ хийх хэрэгсэл:

- Цифр, тоо, үсэг;
- Шохой болон өнгийн бичих хэрэгсэл;
- ХГҮ-ийн хамгаалалтын тууз.

2.3. Хэмжих хэрэгсэл:

- Шугам;
- Штангенциркуль;
- 5 м урт метр;
- Электрон метр;
- Хэмжилтийн бусад төхөөрөмж.

2.4. Гарын хээний дардас авах хэрэгсэл:

- Тос;
- Өнхрүүш.

2.5. Хэв, хуулбар авах хэрэглэгдэхүүн:

- Гипс;
- Паста К;
- Наалдамхай тууз, хальс;
- Иод болон бусад химийн уураар утах хэрэгсэл;
- Схемчилсэн зураг үйлдэх хэрэгсэл.

**3. Мөр тусгаарлах хэрэгсэл:**

- Хөрөө 1 ш;
- Бахь 2 ш;
- Шил зүсэгч 1 ш;
- Алх;
- Тариур;
- Хямсаа;
- Хөвөн;
- Ариутгасан марль.

**4. Мөр битүүмжлэх хэрэгсэл:**

- Төрөл бүрийн хэмжээтэй цаасан ба нийлэг уут, дугтуй;
- Шилэн ба хуванцар сав;
- Хайрцаг.



*Зураг 2. Цүнхэн доторх хэрэгсэл*








*Зураг 3. Цүнхэн доторх хэрэгсэл*





Зураг 4. Цүнхэн доторх хэрэгсэл

## Хэргийн газрын үзлэгийн цүнхний иж бүрдэл

№	Зураг	Нэр	Тайлбар
1		гар чийдэн	Хэргийн газрын үзэгдэх орчныг сайжруулах гэрэл.
2		хямсаа, цаас зүсэгч	Хэргийн газраас эд зүйл хураан авахад зориулагдсан хямсаа болон цаасны хутга.
3		багажны иж бүрдэл	ХГҮ-ээр зарим төрлийн эд мөрийн баримт цуглуулж, хураан авахад ашиглана.
4		томруулдаг шил	Бичил ул мөр илрүүлж бэхжүүлэх болон харьцуулах шинжилгээний үед ашиглана.
5		хэргийн газрын хамгаалалтын тууз	Хэргийн газрыг хамгаалах, эд мөрийн баримт, ул мөрийг хамгаалж битүүмжлэхэд хэрэглэнэ.

6




тоо болон үсэг

Хэргийн газрын үзлэгийн үед ул мөр, эд мөрийн баримтыг дугаарлаж бэхжүүлэхэд ашиглана.

---

7



даавуун метр

Хэргийн газрын үзлэгт тусгагдсан ул мөр, эд мөрийн баримт болон шаардагдах хэмжээс авахад хэрэглэнэ.

---

8



соронзон болон энгийн багс

Хэргийн газрын үзлэгээр бичил мөр, гарын мөр, гутлын улны мөр болон бусад ул мөрийг илрүүлэхэд ашиглана.

---

9



Хэргийн газрын үзлэгээр бичил мөр болон бусад ул мөр, дээж, арчдасыг бэхжүүлж хураан авахад зориулагдсан уут, хуванцар сав, тусгай уусмал болон хөвөн, хаяг хийх шошго.

---

10



Хэргийн газрын үзлэгийн үед гарын мөр болон бусад ул мөр илрүүлэхэд зориулагдсан соронзон болон бусад нунтаг.

Хэргийн газрын үзлэгийн үед гарын мөр болон бусад ул мөрийг илрүүлэхэд объектын гадаргуун дээр түрхэж хэрэглэнэ.

---



11



шохой зуурах сав

ХГҮ-ээр илрүүлсэн гүн мөрийг хэвд цутгаж бэхжүүлэн авахад зориулсан шохой зуурах сав.

12



хусуур

Хэргийн газрын үзлэгээр илэрсэн эд мөрийн баримтыг хусаж авахад ашиглана.

13



дардасны төмөр болон тосон өнхрүүш

Цогцсын болон сэжигтэн, яллагдагчийн гарын дардас авахад хэрэглэнэ.


14

хар болон цагаан цаас,  
дардасны тос

Хэргийн газрын үзлэгээр илэрсэн гарын мөрийг нунтгийн өнгөнөөс хамаарч бэхжүүлэхэд зориулсан өнгийн цаас.

Сэжигтэн, хохирогч, яллагдагч, цогцсын гарын дардас авахад хэрэглэх тос.

15

хайч, наадаг хэмжээс,  
наалдамхай өргөн тууз

Хэргийн газрын үзлэгээр илэрсэн ул мөрийг бэхжүүлэх, тасдан авахад ашиглана.


16



хэт ягаан туяаны  
гэрэл

Хэргийн газрын үзлэгээр ул  
мөр илрүүлэхэд болон үнэт  
цаасны нууцлал шалгахад  
ашиглана.

17



шил зүсэгч болон  
хэмжих хэрэгсэл

Хэргийн газрын үзлэгээр  
илэрсэн ул мөр  
эд мөрийн баримтыг хэмжих,  
тасдан авахад ашиглана.


18



тоосон мөр илрүүлэх  
багаж

Хэргийн газрын үзлэгээр  
тоосон мөрийг илрүүлж  
бэхжүүлж хураан авахад  
хэрэглэнэ.

19



луужин

Хэргийн газрын үзлэгийн үед  
зүг чиг тогтооход ашиглана.

## ХАВСРАЛТ 3

### Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийх зарим төрлийн шинжилгээний жишиг хугацаа

№	Шинжилгээ	Хугацаа
<b>Мөр судлалын шинжилгээ</b>		
1	Хувцас, даавуун эдлэлд үүссэн гэмтэл	ажлын 5 хоног
2	Цоож болон багаж хэрэгслийн мөр	ажлын 7 хоног
3	Гутлын болон тээврийн хэрэгслийн мөр	ажлын 5 хоног
4	Хэсгээс бүхэл тогтоох	ажлын 5 хоног
<b>Бичиг баримтын шинжилгээ</b>		
1	Гарын үсэг	ажлын 7 хоног
2	Гар бичмэл	ажлын 5 хоног
3	Үнэт цаас, мөнгөн тэмдэгт, паспорт зэрэг нууцлалтай баримтыг хуурамчаар үйлдсэн, засварласан эсэхийг тогтоох	ажлын 5 хоног
4	Тамга, тэмдэгт хийх шинжилгээ	ажлын 5 хоног
5	Бичиглэл болон тамга, тэмдгийн дараалал тогтоох шинжилгээ	ажлын 5 хоног
<b>Галт зэвсгийн шинжилгээ</b>		
1	Галт зэвсгийн зориулалт, ажиллагаа	ажлын 3 хоног
2	Сумны марк, ажиллагаа	ажлын 3 хоног
3	Хонгионы харьцуулалт	ажлын 5 хоног
4	Хошууны харьцуулалт	ажлын 7 хоног
<b>Гарын хээний шинжилгээ</b>		
1	Гарын мөрийг санд харьцуулах шинжилгээ	ажлын 5 хоног
2	Гарын хээний дардсыг санд харьцуулах шинжилгээ	ажлын 3 хоног
3	Объектоос мөр илрүүлж, харьцуулах шинжилгээ	ажлын 5 хоног
<b>Авто техникийн шинжилгээ</b>		
1	Авто техникийн эд ангиудын гэмтлийн шалтгаан тогтоох	ажлын 5 хоног
2	Авто техникийн эд ангиудын харьцуулах шинжилгээ	ажлын 5 хоног
<b>Дүр зураг, дүрс, дуу бичлэгийн шинжилгээ</b>		
1	Дүрс бичлэгийн шинжилгээ	ажлын 5 хоног
2	Дуу бичлэгийн шинжилгээ	ажлын 5 хоног
3	Дүр зургийн шинжилгээ	ажлын 5 хоног
<b>Биологийн шинжилгээ</b>		
1	Шингэн цусны бүлэг тогтоох	ажлын 3 хоног
2	Хатсан цус, эд эрхтэн, үс, шүлсний бүлэг тогтоох	ажлын 7 хоног

3	Эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээ	ажлын 3 хоног
4	Эр бэлгийн эс илэрсэн тохиолдолд түүний бүлгийн харьяалал тогтоох	ажлын 7 хоног
<b>ДНХ-гийн шинжилгээ</b>		
1	Эцэг тогтоох шинжилгээ	ажлын 10 хоног
2	Эд мөрийн баримт, эд эрхтэн, булцуутай үсэнд хийх шинжилгээ	ажлын 7 хоног
3	Муудсан, шатсан эд эрхтэн, ясанд хийх ДНХ шинжилгээ	ажлын 21 хоног
<b>Бактериологийн шинжилгээ</b>		
1	БЗХӨ-ийг илрүүлэх (граммын арга+тестээр)	ажлын 3 хоног
2	БЗХӨ-ийг молекул биологийн аргаар илрүүлэх шинжилгээ	ажлын 10 хоног
3	Өсгөвөрлөх аргаар халдварын үүсгэгч тодорхойлох шинжилгээ	ажлын 10 хоног
<b>Физикийн шинжилгээ</b>		
1	Буудлагын мөр	ажлын 5 хоног
2	Буудлагын зай тогтоох	ажлын 3 хоног
3	Буудлагын тоо тогтоох	ажлын 3 хоног
4	Буудлагын чиглэл тогтоох	ажлын 3 хоног
5	Алт, мөнгөний сорьц тодорхойлох	ажлын 3 хоног
<b>Химийн шинжилгээ</b>		
1	Биологийн дээжид спирт тодорхойлох шинжилгээ	ажлын 2 хоног
2	Спирт агуулсан согтууруулах ундааны шинжилгээ	ажлын 3 хоног
3	Үл мэдэгдэх бодисын найрлага тогтоох шинжилгээ	ажлын 7 хоног
4	Эд эрхтэнд эмийн бодис тодорхойлох шинжилгээ	ажлын 5 хоног
5	Эд, эрхтэнд метилийн спирт, хлорт нэгдэл, этиленгликоль, цууны хүчил тодорхойлох шинжилгээ	ажлын 5 хоног
6	Цус, шээсэнд мансууруулах бодис тодорхойлох шинжилгээ	ажлын 5 хоног
<b>Шүүх эмнэлгийн шинжилгээ<sup>72</sup></b>		
1	Хүний биед хийх шинжилгээ	ажлын 3 хоног
2	Хүний биед нэмэлт шинжилгээ хийхээр бол	+ ажлын 5 хоног
3	Цогцос шинжлэх	ажлын 21 хоног
4	Хэргийн материалаар бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх	ажлын 21 хоног
5	Шарил шинжлэх	ажлын 21 хоног

<sup>72</sup> Энэхүү хугацааг Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/215/421 тоот хамтарсан тушаалаар баталсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх” журамд заасан.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Хууль, эрх зүйн акт

1. Эрүүгийн хууль. УБ., 2015.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017.
3. Шүүхийн шинжилгээний тухай хууль. УБ., 2009.
4. Боловсролын тухай хууль, УБ., 2002.
5. Дээд боловсролын тухай хууль, УБ., 2002.
6. Монгол Улсын Их Хурлын 1998. 18 дугаар тогтоол “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”
7. Монгол Улсын Их Хурлын 2015. 12 дугаар тогтоолын хавсралт “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024.)”
8. Монгол Улсын Их хурлын 2017. 11 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020. хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”
9. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003. 158 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”
10. Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2014. 12 дугаар сарын 15-ны өдрийн А/215/421 тоот хамтарсан тушаалаар баталсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх”
11. Архивын ерөнхий газрын даргын тушаал дугаар 68, УБ., 2009.
12. Улсын Ерөнхий прокурорын тушаал дугаар А/80, УБ., 2017.
13. Улсын Ерөнхий прокурорын тушаал дугаар А/96, УБ., 2017..
14. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код, УБ., 2015.
15. МУИС-ийн Захирлын 2011. 5 дугаар сарын 31-ний өдрийн 304 тоот тушаал “Монгол улсын их сургуулийн бакалаврын сургалтын журам”

### Ном, сурах бичиг

1. Б.Батзориг, Э.Зууннасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, УБ., 2006.
2. Р.Баярмагнай, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, УБ., 2017.
3. Б.Амарбаясгалан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Шүүхийн өмнөх болон шүүхийн шат), УБ., 2018.
4. Г.Наранбаатар, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхийн акт үйлдэх аргачлал УБ., 2018.
5. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, УБ., 2018.
6. Ж.Ганбаатар, Л.Отгонбаяр, “Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай, УБ., 2017.
7. Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, Мөрдөгчийн гарын авлага, УБ., 2018.
8. Б.Хишигтогтох, Б.Баярмагнай, Мөрдөн байцаалтын ажиллагаа, УБ., 2018.
9. Б.Бат-Эрдэнэ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй (альбом, схем), УБ., 2018.

10. Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь (Онол, практикийн хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл), УБ, 2019.
11. Т.Оюунчимэг нар, Эрүүгийн хэрэг шалгаж, шийдвэрлэх ажиллагаа, УБ, 2020.

### **Эрдэм шинжилгээний бүтээл**

1. Очирбат Т., Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллага ба гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагууд” сэдэвт судалгааны дэд тайлан, УБ., 2014.
2. Т.Очирбат, Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Диссертаци, 2019.
3. Т.Очирбат, “Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам”, УБ., 2019.
4. Г.Ганзориг, Хүний эрх, эрх чөлөө-шүүхийн шинжилгээ, Өгүүлэл, УБ., 2015.

### **Гадаад хэл дээрх бүтээл**

1. Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 31.07.2020)
2. Уголовно-процессуальный кодекс КНР (БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль)
3. Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль
4. БНСУ-ын Эрүүгийн процессын хууль (Албан бус орчуулга)
5. АНУ-ын Нотлох баримтын тухай холбооны журам (Албан бус орчуулга)
6. Английн Цагдаагийн үйл ажиллагаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хууль (Албан бус орчуулга)
7. Пан Дунмэй, Гао Минсюань. Становление и развитие китайского уголовного законодательства. Вестник Санкт-Петербургского университета, 2018 год
8. Сун Цяоцяо. Функциональная характеристика досудебного и судебногопроизводства в уголовном процессе Китая, Санкт-Петербургский государственный университет. Выпускная работа магистратуры. Санкт-Петербург, 2017 год
9. Ю. В. Козубенко. Вопросы уголовного Судопроизводства КНР, Электронное приложение к “Российскому юридическому журналу” 3/2011 год
10. Юань И. Проблемы рассмотрения доказательств по новому УПК КНР. Зарубежные научные школы. 2018 год
11. Журкина Ольга Вячеславовна “Доказательства в уголовно-процессуальном законодательстве зарубежных стран” Criminal procedure. 2016. №3.

**Бусад эх сурвалж**

1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2015. тайлан
2. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2016. тайлан
3. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017. тайлан
4. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018. тайлан
5. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2019. тайлан
6. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2020. 6 дугаар сарын тайлан
7. JCI capital” байгууллагаас 2019.д Мөрдөн байцаах албаны ажилтны сэтгэл ханамж, манлайллын нөхцөл байдалд дүн шинжилгээний тайлан

**Цахим эх сурвалж**

1. <http://ru.wikipedia.org>
2. <http://www.shuukh.mn/>
3. <https://unuudur.mn/>
4. <http://eincenter.police.gov.mn/>
5. <https://www.ac.mn/>
6. <https://nema.dri.gov.mn>
7. <http://cengeolab.com/>
8. <https://nczd.gov.mn>
9. <https://muls.edu.mn>
10. <http://inspection.gov.mn>
11. <http://inspection.gov.mn>
12. <https://www.audit.mn/>
13. <https://www.audit.mn>
14. <https://damno.barilga.mn/>
15. <http://nifs.gov.mn/>
16. <https://judcouncil.mn/site/>
17. <https://police.gov.mn/>
18. <https://www.iaac.mn/>
19. <https://www.mglbar.mn/>
20. <https://www.ama.org.mn/>







ISBN 991997422-6



9 789919 974220